

«БЭЛГИЙН БОЛОН  
НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ  
МЭНД, ЭРХИЙН ТАЛААРХ  
ОЙЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ»

Гарын авлага


Улаанбаатар хом  
2015

ma  
ma  
cash

(She changes the world)





The background is a vibrant red color. It features several faint, semi-transparent icons of gender symbols (male and female) and their combinations, some enclosed in circular shapes. A large, semi-transparent circular graphic with a wood-grain texture is centered on the page, containing the main text.

**«БЭЛГИЙН БОЛОН  
НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ  
МЭНД, ЭРХИЙН ТАЛААРХ  
ОЙЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ»**

---

Гарын авлага

**Гарын авлагыг  
боловсруулсан:**

**Ерөнхий боловсролын сургуулийн Эрүүл мэндийн багш нарт зориулсан сургалтын модулийг боловсруулсан: .....**

<b>Э.Ариуннаран</b>	<i>ХАХНХЯ-ны жендэрийн мэргэжилтэн</i>
<b>Н.Болдмаа</b>	<i>Доктор, МУИС-ийн НШУС, Социологи-Нийгмийн ажлын тэнхимийн багш</i>
<b>Г.Золзаяа</b>	<i>Хүний эрхийн Үндэсний комиссын ахлах мэргэжилтэн</i>
<b>Ч.Ундрах</b>	<i>Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах ГҮНЖ төв ТББ-ын Гүйцэтгэх захирал</i>
<b>Г.Урантүлхүүр</b>	<i>Хүнс эвсэл ТББ-ын тэргүүн</i>
<b>П.Үнэнчимэг</b>	<i>ЭМЯ, ХӨСҮТ-ийн эмч, АУ-ны магистр</i>

**Их дээд сургуулийн оюутнууд, МСҮТ-ийн болон ЕБС-ийн сурагчдад зориулсан сургалтын модулийг боловсруулсан. ....**

<b>Ц.Даваасүрэн</b>	<i>ХЭҮТ-ийн сэтгэл зүйч</i>
<b>Ж.Мөнхтайван</b>	<i>“Нутгийн хөгжлийн төв” ТББ-ын ажилтан</i>
<b>Г.Чинзориг</b>	<i>“Залуус эрүүл мэнд төв” ТББ-ын ажилтан</i>
<b>Э.Хишигбаяр</b>	<i>“Хүйсийн тэгш эрхийн төв” ТББ-ын ажилтан</i>
<b>Н.Хишигсүрэн</b>	<i>МОНФЕМНЕТ үндэсний сүлжээний зохицуулагч</i>
<b>Э.Эрдэнэцэцэг</b>	<i>Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах ГҮНЖ төв ТББ-ын ажилтан</i>

**Зорилтот бүлгүүдэд зориулсан сургалтын модуль боловсруулсан**

<b>Г.Жавхаа</b>	<i>ЛГБТ төв ТББ-ын Сайн дурын ажилтан</i>
<b>Д.Энхбаяр</b>	<i>ЛГБТ төв ТББ-ын Сайн дурын ажилтан</i>
<b>Г.Жаргалмаа</b>	<i>ЛГБТ төв ТББ-ын Сайн дурын ажилтан</i>
<b>Д.Мөнхнасан</b>	<i>Залуус эрүүл мэнд төв ТББ-ын ажилтан</i>
<b>С.Цэнд-Очир</b>	<i>Залуус эрүүл мэнд төв ТББ-ын ажилтан</i>

Монголын эмэгтэйчүүдийн сан нь эмэгтэйчүүдийн хөгжил дэвшлийн төлөө нөөц баялгийг хуримтлуулж эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллага, бүлгүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

ТЕХНИК РЕДАКТОР:

**Б.Эрдэнэчимэг**

*МОНЭС-гийн Гүйцэтгэх захирал*

**П.Даваанамжил**

*МОНЭС-гийн Тэтгэлэг олгох Хөтөлбөрийн менежер*

**Энэхүү гарын авлагыг Нидерланд Улсын  
Мама кэш сангийн дэмжлэгтэйгээр хэвлэв.**

Манай хаяг:

Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, 48-р байр, 305 тоот

Утас: 976-77119991

Э-шуудан: mones@mongol.net

## Өмнөх үг

Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байдаг билээ. Хүний эрх нь хүний нандин чанар, хүний үндсэн эрх, эрх чөлөөнд харшлах үйлдлээс хувь хүн болон аливаа бүлгийг үндэсний, олон улсын хуульчилсан хэм хэмжээгээр хамгаалагддаг гэж Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан байна. Өөрөөр хэлбэл хүний эрх бол таныг хүний зэрэгтэй, нэр төртэй амьдрахад шаардагдах наад захын баталгаа юм. Хүний эрхийн салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг бол бэлгийн эрх болон нөхөн үржихүйн эрхийн асуудал юм.

Бэлгийн эрх, бэлгийн чиг баримжаа, хүйсийн чиг баримжаа зэрэг асуудлаар бэлтгэгдсэн багш байдаггүй гэсэн шалтгаанаар ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт орсон энэ сэдвийг заахгүй орхигдуулдаг байна. Энэ асуудлаар өсвөр үеийн хүүхэд залуучуудад үнэн зөв бодитой мэдээлэл дутмаг байдаг. Ийм учир ерөнхий боловсролын сургуулийн Эрүүл мэндийн хичээлийн багш нар, өсвөр үеийн хүүхэд залуучуудын, бэлгийн цөөнхийн асуудлаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор энэхүү гарын авлагыг боловсрууллаа. Энэхүү гарын авлага нь бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн талаарх ойлголтыг олон нийтэд нэмэгдүүлэх замаар олон талт үйл ажиллагаа явуулж буй нэгээхэн хэсэг нь болж байна.

Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн чиглэлээр мэргэшсэн Бүгд Найрамдах Энэтхэг улсын Тарши байгууллагын сургагч багш нарын сургалтад оролцож, бэлтгэгдсэн 20 сургагч багш нар 3 багт хуваагдан зорилтот бүлгүүдэд сургалт явуулах модулиа боловсруулсан юм. Сургалт нь өсвөр үеийн хүүхэд, залуусын хүний эрх, бэлгийн эрх, бэлгийн чиг баримжаа, жендэр, хүйсийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд тус болох төдийгүй бэлгийн мөн чанар, баримжаа асуудлаар мэдлэгтэй болж, эрүүл, аюулгүй бэлгийн зан үйлтэй болоход нөлөөлөл үзүүлнэ гэдэгт гарын авлага боловсруулсан багийнхан итгэлтэй байна.

“Бэлгийн эрх ба нөхөн үржихүйн эрх, эрүүл мэнд” төслийг хэрэгжүүлэхийг дэмжсэн Мама кэш сан, техникийн туслалцаа үзүүлсэн Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Тарши байгууллагын сургагч багш Прабба Нагаража болон Дипика Шривастава нарт талархал илэрхийлж байна.

Өөрсдийн мэдсэн бүхнээ бусадтай хуваалцах зорилгоор сургалтын модуль боловсруулсан бүх багийн гишүүддээ их баярлалаа. Та бүхний боловсруулсан модуль нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудлаар өсвөр үеийн хүүхэд, залуучууд, энэ асуудлыг сонирхон судалж байгаа хүмүүсийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

**Монголын эмэгтэйчүүдийн сан**

## Гарчиг

### ГАРЫН АВЛАГЫГ АШИГЛАХ ТУХАЙ

8

### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

9

#### **“Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх”**

*ЕБС-ийн эрүүл мэндийн багш нарт зориулсан сургалтын модуль*

### ХОЁРДУГААР ХЭСЭГ

51

#### **“Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх”**

*Өсвөр насны хүүхэд, залуучуудад зориулсан сургалтын модуль*

### ГУРАВДУГААР ХЭСЭГ

66

#### **“Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх”**

*Бэлгийн цөөнхийн бүлгүүдэд зориулсан сургалтын модуль*

### ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ

81

#### **Нэр томъёоны тайлбар**

### Товчилсон үгийн жагсаалт

- АУ Анагаах Ухаан
- ДЭМБ Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
- МОНЭС Монголын Эмэгтэйчүүдийн Сан
- МУИС Монгол Улсын Их Сургууль
- НШУИС Нийгмийн шинжлэх ухааны их сургууль
- НҮЭМ Нөхөн үржихүйн эрүүл мэнд
- ТББ Төрийн Бус Байгууллага
- ХӨСҮТ Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв
- ХЭҮТ Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
- ХАХНХЯ Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
- TARSHI Talking About Reproductive and Sexual Health Issues  
*/Нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн асуудлаар ярилцая/*
- ЖСАХ Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл
- ЭМЯ Эрүүл Мэндийн Яам

## Гарын авлага ашиглах тухай

Өсвөр насны хүүхэд, залуучуудад зориулсан “Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх” сургалтын модулийг боловсруулахдаа бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудлаар 15 жилийн туршлага хуримтлуулсан Бүгд Найрамдах Энэтхэг улсын Тарши байгууллагын сургалтын арга зүйг ашиглалаа. Сургалтын модуль нь 3 хэсгээс бүрдэж байна. Хэсэг бүрийн агуулга, хөндөж ярих асуудал ижил бөгөөд харин сургалт явуулах арга зүй янз бүр байгаа нь энэхүү модулийн онцлог юм.

ЕБС-ийн Эрүүл мэндийн хичээлийн багш нарт зориулсан сургалтын модуль нь багш нарын бэлгийн эрх, мөн чанар, хүйсийн болон хүйсийн чиг баримжааны асуудлаарх мэдлэгийг нь гүнзгийрүүлэх зорилго тавьсан учир бусад 2 хэсгээс илүү дэлгэрэнгүй, тухайн асуудлын талаарх олон улс болон үндэсний баримт бичгүүдийг нэмэлт материал болгон ашиглах, хүний эрх болон бэлгийн эрхийн асуудлаар суралцагчдад дасгал, кейс дээр ажиллуулах арга зүйг танилцуулсан бол өсвөр насны хүүхэд, залуучууд, зорилтот бүлэгт явуулах сургалтын модульд кино үзүүлэх, дасгал болон кейс дээр ажиллуулах, тоглоомын аргыг түлхүү ашигласан болно.

Хэсэг бүр нь хавсралтуудтай бөгөөд хавсаргасан материалуудыг давхардуулахгүй байх зарчмыг баримталсан. Иймд сургалт явуулах гэж байгаа багш нар гарын авлагын бүх хэсгүүдтэй танилцсаны үндсэн дээр өөрийн сонголтоор материалыг авч ашиглах боломжтой. Хүний эрхийн тухай ойлголт, мэдлэгийг богино хугацаанд танилцуулах зорилгоор хүний эрхийн байгууллагуудаас бэлтгэсэн “Хүний эрх гэж юу вэ” баримтат киноны монгол хэл дээрх хувилбарыг татаж авч үзүүлэх линкийг тавьсан болно.

Гарын авлагын төгсгөлд нэр томъёоны тайлбарыг оруулсан байгаа. Нэр томъёоны тайлбар нь албан ёсны орчуулга биш гэдгийг анхаарна уу.



АГУУЛГА  
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

ЕБС-ИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАГШ НАРТ ЗОРИУЛСАН  
“БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД, ЭРХ”  
СУРГАЛТЫН МОДУЛЬ

**Оршил**

<b>Сэдэв 1:</b>	Бэлгийн мөн чанар .....	11
<b>Сэдэв 2:</b>	Жендэр ба жендэрийн хэвшмэл ойлголт .....	15
<b>Сэдэв 3:</b>	Хүний эрхийг танилцуулах нь .....	20
<b>Сэдэв 4:</b>	Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрх.....	23
<b>Сэдэв 5:</b>	Бэлгийн зан үйл, илэрхийлэл .....	27
<b>Сэдэв 6:</b>	Бэлгийн ба хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл ...	30
<b>Хавсралт 1.</b>	10 түлхүүрт асуулгын арга .....	34
<b>Хавсралт 2.</b>	Шинэ гариг тоглоом .....	36
<b>Хавсралт 3.</b>	Хүний эрх гэж юу вэ? .....	39
<b>Хавсралт 4.</b>	Бэлгийн ба нөхөн үржихүйн 12 эрх .....	40
<b>Хавсралт 5.</b>	Бэлгийн зан үйлийн олон төрөл, илэрлүүд .....	45

## ОРШИЛ

Энэхүү сургалтын модуль нь “Ерөнхий боловсролын дунд сургуулийн эрүүл мэндийн хичээлийн багш нарт бэлгийн болон нөхөн үржихүйн талаарх орчин үеийн ойлголт, мэдлэгийг өгөх замаар өсвөр үеийнхний бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх”-д чиглэгдэнэ. ЕБС-ийн багш нар сурагчдад нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх болон бэлгийн цөөнхийн эрхийн асуудлын талаарх мэдлэгийг олгохдоо хүний эрхийн зарчмуудыг баримтлах ёстой юм.

### Модуль нь:

1. Ерөнхий боловсролын дунд сургуулийн Эрүүл мэндийн хичээлийн багш нарын “Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд”-ийн талаарх боловсрол олгох чадавхийг нэмэгдүүлэх
2. Өсвөр үеийнхний бэлгийн болон Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролын чанарыг дээшлүүлэх, тэдэнд хүрч буй боловсролын үйлчилгээг сайжруулахад зориулагдсан болно.

### Сургалтаас хүлээгдэж байгаа үр дүн

- Багш нарын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн талаарх үндсэн ойлголтыг нэмэгдүүлнэ.
- Шинэлэг, орчин үеийн мэдээ, мэдээллээр хангана.
- Шинэлэг, оролцооны заах арга барилд сургана.
- Багш нарын бэлгийн мөн чанарын талаарх мэдлэг, хандлагыг өөрчилнө.
- Өсвөр үеийнхнийг эрүүл, аюулгүй бэлгийн зан үйлтэй болоход нөлөөлөл үзүүлнэ.

## сэдэв 1

### БЭЛГИЙН МӨН ЧАНАР

“Би юу сонссоноо хараад, ярилцаад хийвэл мэдлэг олж, туршлага хуримтлуулдаг. Би юу сурахыг хүсч байна, түүнийгээ жинхэнэ ёсоор эзэмшдэг” гэсэн идэвхитэй /Силберман, 1996/ суралцах зарчимд сургалт тулгуурлан явагдана.

#### **Зорилго: Сургалтад оролцогчдод:**

- Бэлгийн мөн чанар нэгдсэн ойлголтод хүрэх
- Суралцагчиддаа мэдээлэл хүргүүлэх

#### **Сургалтын зорилтууд**

- Бэлгийн мөн чанарыг ойлгох, зөв тодорхойлж сурах
- ДЭМБ-ын 2002 оны тодорхойлолтыг түгээх

**Үргэлжлэх хугацаа: 58 минут**

**Арга зүй:** Оролцооны аргад тулгуурлан сургалтыг явуулна. Дараах оролцооны аргуудыг ашиглана.

- Нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах
- Багаар ажиллах

**Бүтэц:** “Бэлгийн мөн чанар” сэдэвт сургалт нь дараах 5 хэсгээс бүрдэнэ.

1. Бусаддаа мэдээлэл түгээх - 20 мин
2. ДЭМБ-ын 2002 оны ажлын тодорхойлолт дээр ажиллах – 15 мин
3. Тодорхойлолтын мөрөөр ярилцах - 15 мин
4. Сургалтын дүгнэлт - 8 мин

**Хэрэглэгдэх зүйлс:** тараах материал, флипчарт цаас, маркер

## **2. Бусаддаа мэдээлэл түгээх**

Сургагч багш оролцогчдын бэлгийн мөн чанарын талаарх мэдлэгийг тандаж мэдэх зорилгоор 5 багт оролцогчдыг хувааж бэлдсэн кейсийг багуудад тарааж түүн дээр ярилцан бусад багуудад мэдээллээ түгээнэ. Бусаддаа мэдээлэл түгээх хугацаа 20 минут байна.


Ба г	Ангилал /насаар/	Кейс
Нар баг	Сургуулийн өмнөх нас	Бид хүйсийн ялгаатай байдлыг мэдэрч өвөрмөц зан төрхүүдээ мэдэж авдаг. Охидууд тоглохдоо ихэвчлэн айл гэр болж, бусдыг асарсан төрхтэй байдаг, хөвгүүд ихэвчлэн хурд, хүч шаардагдах тоглоом тоглодог. Бид цэцэрлэгтээ эмч болж тоглож байхад эрэгтэй хүүхэд, эмэгтэй хүүхдийн эрхтэн өөр өөр байдаг гэдгийг ойлгосон
Мод баг	Сургуулийн нас	Бидэнд нэг асуудал тулгараад байна. Бэлгийн хөгжил хүчтэй явагдаад байх шиг байна. Үерхэл дурлал зэрэг сэтгэлийн хөдлөлд автаад л, хүйсийн ялгавартай байдал үүсээд байгаа. Ээжээсээ асуух ёстой зарим бидний мэддэггүй зүйлс гарч ирсэн. Жишээ нь бэлгийн даавар ялгаралт, хүүхдийн бэлгийн бойжилтын шинжүүд гэх мэт. Үеийнхнээсээ асуусан чинь хүүхэд бүрт өсөлт хөгжлийн өөрийн гэсэн хэмнэл байдаг юм шиг байна билээ. Заримд нь эрт тохиолдсон байхад, зарим нь энэ тухай мэдээгүй байсан.
Галт тэрэг баг	Өсвөр нас	Бидний амьдралын хоёр дахь арван жил буюу бэлгийн бойжилтын нас эхэлж байгаа. Энэ нь биологийн хувьд бэлгийн бойжилтоор тодорхойлогддог, насанд хүрэхийн өмнөх шилжилтийн үедээ оржээ гэсэн үг гэж эрүүл мэндийн хичээл болон интернэтэд бичсэн байсан. Гэхдээ надад тэгж санагдсан. Энэ нь зөвхөн биологийн үйл явц биш юм байна. Сэтгэлзүй, нийгмийн үзэгдэл ч бас нөлөөлж харилцан адилгүйгээр бид өөрчлөгдөж байна. Бид ер бусын гэмээр хурдацтай өсөж том болохын зэрэгцээ хүч чадал маань нэмэгдэж, цаашлаад үржих чадвартай болж байна. Бидний ихэнх нь эсрэг хүйсийнхэндээ анхаарал татагдаж байхад, манай ангийн нэг эмэгтэй хүүхэд, нөгөө ангийн охинд татагдаад байгаа гэхээр хүн бүр янз бүр юм шиг ээ. Гэхдээ томчуудын өөрсдөө хийдэг, бидэнд хориглодог тэр зан үйлүүдийг туршиж үзмээр санагдах юмаа.
Цэцэг баг	Насанд хүрэгсэд	Хүний биологийн хэрэгцээг хангаж, үр удмаа үлдээх, гэр бүлийн оршин тогтнох нөхцлийг бүрдүүлж таашаал авах процесс гэж бидний ихэнх нь ингэж ойлгодог. Бэлгийн харилцаа нь гэр бүлийн амьдралын хамгийн чухал зүйлсийн нэг бөгөөд гэр бүл дэх уур амьсгалыг тодорхойлж байдаг нэгэн хүчин зүйл юм.
Тэмээн жингийн цуваа баг	Ахимаг нас	Бидний нас ахихын хирээр бидний бие махбодь, оюун ухаан, орчин өөрчлөгдөж байна. Эдгээр өөрчлөлт нь бидний бэлгийн амьдралыг ч мөн өөрчилж байна. Эмэгтэйчүүдэд цэвэршилт гэх өөрчлөлт тохиолдож байхад эрчүүд нас ахихад шодой хөвчрөх чадвар буурдаг юм байна. Зарим нэр төрлийн эмүүд, бие махбодийн өвчин эмгэгүүд, сэтгэл санааны байдал, сэтгэл гутрал гэх мэт нь бэлгийн амьдралд нөлөөлж байдаг. Гэхдээ л бидний бэлгийн мэдрэмж, сонирхол байнга л бидэнтэй хамт байдаг. Сурталчилгаагаар үзүүлдэг дүрслэлийг эс тооцвол секс бол зөвхөн залуу хүмүүсийн асуудал биш юм. 90 нас хүртлээ эрүүл, идэвхитэй бэлгийн амьдрал эрчүүд эмэгтэйчүүдэд байх нь ховор үзэгдэл биш юм.

## 2. ДЭМБ-ын 2002 оны ажлын тодорхойлолт дээр ажиллах



Сургагч багш оролцогчдод бэлгийн мөн чанарын /ДЭМБ-ын 2002 оны ажлын тодорхойлолт/ тодорхойлолтод өгөгдсөн үгүүдийг өгч зөв өгүүлбэр бүтээнэ. Энэхүү даалгаварыг оролцогчид бие даан гүйцэтгэнэ. Өгүүлбэр бүтээх хугацаа 15 минут байна.

Зураг 1.1. Бэлгийн мөн чанар



### Бэлгийн мөн чанарын тодорхойлолт

Бэлгийн мөн чанар нь хүний амьдралын гол аспект бөгөөд хүйс, гендерийн хамаарал ба үүрэг роль, бэлгийн чиг баримжаа, эротизм, дур ханамж, янаглал, нөхөн үржилт зэргийг хамарна. Бэлгийн мөн чанар нь бодол, фантаз, хүсэл, итгэл, хандлага, үнэлэмж, зан үйл, практик үйлдэл, үүрэг роль, харилцаа зэргээр хэрэгжиж илэрхийлэгдэнэ. Бэлгийн мөн чанар ийм олон талтай хэдий ч эдгээрийг бүгдийг нь дандаа илэрхийлж, хэрэглэдэггүй байна. Бэлгийн мөн чанар нь биологийн, физиологийн, нийгмийн, эдийн засгийн улс төрийн, соёлын, ёс зүйн, эрх зүйн, түүхэн, шашны зэрэг хүчин зүйлс, тэдгээрийн харилцан үйлчлэлийн нөлөөнд байдаг

/ДЭМБ 2002 оны ажлын тодорхойлолт

## 3. Тодорхойлолтыг тайлбарлаж, ярилцах



Тодорхойлолт тус бүрээр ярилцаж, оролцогчдын ойлголтын зөрүүг арилгана. Энэхүү дасгалыг ажиллуулснаар "бэлгийн мөн чанарын ойлголт хүний амьдралын гол аспект, насны онцлог, нийгмийн байр сууриас хамаарч янз бүрээр илэрдэг" гэсэн гол ойлголтыг оролцогчдод өгнө. Ойлголтын зөрүүг арилгах ярилцлага нийт 15 минут үргэлжилнэ.

Хүснэгт 1.2

Баг	Өгөгдөх үгс	Өгүүлбэр
Нар баг	амьдралын, чанар, хүний, бэлгийн, аспект, нь, гол, мөн,	Бэлгийн мөн чанар нь хүний амьдралын гол аспект
Мод баг	жэндэрийн, янаглал, зэргийг, ба, мөн, бэлгийн, үүрэг, роль, хамаарал, эротизм, нөхөн, үржилт, хамарна, бэлгийн, дур, ханамж, чиг, баримжаа, чанар, нь, хүйс, бэлгийн.	Бэлгийн мөн чанар нь үүрэг роль, бэлгийн чиг баримжаа, эротизм, дур ханамж, янаглал, нөхөн үржилт зэргийг хамарна.
Галт тэрэг баг	практик, үйлдэл, мөн, бэлгийн, фантаз, зан, үйл, итгэл, үнэлэмж, зэргээр, хандлага, үүрэг, роль, хэрэгжиж, чанар, бодол, нь, хүсэл, илэрхийлэгдэнэ, харилцаа.	Бэлгийн мөн чанар нь бодол, фантаз, хүсэл, итгэл, хандлага, үнэлэмж, зан үйл, практик үйлдэл, үүрэг роль, харилцаа зэргээр хэрэгжиж илэрхийлэгдэнэ.
Цэцэг баг	бүгдийг, хэрэглэдэггүй, чанар, олон, эдгээрийг, хэдий ч, дандаа, талтай, нь, илэрхийлж, мөн, байна, ийм, бэлгийн.	Бэлгийн мөн чанар ийм олон талтай хэдий ч эдгээрийг бүгдийг нь дандаа илэрхийлж, хэрэглэдэггүй байна.
Тэмээн жингийн цуваа баг	физиологийн, улс, төрийн, эдийн, засгийн, шашны, чанар, тэдгээрийн, соёлын, бэлгийн, эрх, зүйн, үйлчлэлийн, ёс, зүйн, зүйлс, харилцан, байдаг, түүхэн, үйлчлэлийн, хүчин, биологийн, нь, нөлөөнд, нийгмийн, зэрэг, мөн.	Бэлгийн мөн чанар нь биологийн, физиологийн, нийгмийн, эдийн засгийн улс төрийн, соёлын, ёс зүйн, эрх зүйн, түүхэн, шашны зэрэг хүчин зүйлс, тэдгээрийн харилцан үйлчлэлийн нөлөөнд байдаг.

**Гол мессэж:**

Энэхүү сэдвийн хүрээнд оролцогчдод дараах 4 гол мэдээлэл өгөхийг зорино.

- Бэлгийн мөн чанарын ойлголтыг ДЭМБ-ын 2002 оны ажлын тодорхойлолтын дагуу өгнө.
- Бэлгийн мөн чанар зөвхөн физиологийн тухай ярьдаггүй

## СЭДЭВ 2

### ЖЕНДЭР БА ЖЕНДЭРИЙН ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТ

**Сэдвийн зорилго:** Аливаа нэгэн асуудлыг авч үзэхдээ хүйс болон жендэрийн ялгаатай талаас нь дүн шинжилгээ хийн, тайлбарлахад суралцана.

#### Сэдвийн зорилтууд

- Хүйс ба жендэр нь ялгаатай ойлголт болохыг тайлбарлана.
- Жендэрийн талаарх хэвшмэл ойлголтуудад дүн шинжилгээ хийж сурна.
- Жендэрийн харилцаа, жендэрийн мэдрэмжтэй байдал, жендэрийн тэгш байдал, жендэрийн тэгш боломж гэсэн үндсэн нэр томъёонуудыг тодорхойлох чадвартай болно.

#### Үргэлжлэх хугацаа: 70 минут

**Арга зүй:** Оролцооны аргад тулгуурлан сургалтыг явуулна. Дараах оролцооны аргуудыг ашиглана.

- Brainstroming буюу ухаан бодлоо уралдуулах
- Асуулт, хариулт
- Багаар ажиллах, илтгэл тавих
- Тоглоомын арга

**Бүтэц:** “Жендэр ба жендэрийн хэвшмэл ойлголт” сэдэв нь дараах 4 хэсгээс бүрдэнэ.

1. Жендэрийн талаарх ойлголтыг тандах асуулт, хариулт – 10 минут
2. 10 түлхүүрт асуултын аргын тусламжтайгаар ярилцлага өрнүүлэх – 15 минут
3. Асуудлаар илтгэл бэлтгэх, ярилцах - 30 минут
4. Жендэрийн үндсэн ойлголтуудыг бататгах, дүгнэлт - 15 минут

**Хэрэглэгдэх зүйлс:** Тараах материал, балын харандаа, флипчарт цаас, маркер, скоч, өнгийн харандаа

#### 1. Жендэрийн талаарх ойлголтыг бататгах дасгал



Бид янз бүрийн эх сурвалжаас олон талт мэдээллийн үндсэн дээр өөр өөрийн байр сууринаас жендэрийг ойлгодог билээ. Сургагч багш оролцогчдын хүйсийн болон жендэрийн талаарх үндсэн мэдлэгийг тандаж мэдэх зорилгоор дараах асуултуудыг асууна. Оролцогчдыг нэг эгнээнд зогсоон, асуултын хариулт нь нийгмийнх бол урагшаа нэг алхам урагшлан, харин биологийнх бол хойшоо нэг алхам алхана. Оролцогчид эргэлзсэн асуултын хариултаа сургагч багшаас тодруулна. Асуулт хариултын хугацаа 10 минут.

### Биологийнх эсвэл Нийгмийнх үү?

1. Эмэгтэй хүн л зөвхөн төрдөг.
2. Эрэгтэй хүн эмэгтэй хүнийг бодвол хүч чадалтай.
3. Эмэгтэй хүнд зөвхөн эх хүний зөн совин байдаг.
4. Эмэгтэй хүн хүүхдээ хөхөөр хооллодог.
5. Эмэгтэй хүн сул дорой, ахархан бодолтой.
6. Эрэгтэй хүн эхэлж эмэгтэйд гэрлэх санал тавих ёстой.
7. Эх хүн илүү үр хүүхэдтэй хайртай.
8. Эрэгтэй хүн л манлайлан, удирдах үр чадвартай.

### Жендэрийн тодорхойлолт

Жендэр гэдэг нь тодорхой нэг соёл, иргэншил, газар нутаг, нийгэм, цаг хугацаанд эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдэд нийгмийн зүгээс оноосон үүрэг, хариуцлагууд, тэгш оролцоо юм.

Үнэн хэрэгтээ, зарим хүмүүс жендэр гэдэг нэр томъёо нь аливааг зөвхөн өөрөөр хийх үүднээс гарч ирсэн нэр томъёо гэж ойлгодог төдийгүй хөгжлийн чиглэлээр ажилладаг зарим хүмүүс энэ нэр томъёог эмэгтэйчүүд гэсэн үгтэй ижил утгатай хэмээн ойлгох явдал байдаг.

Хүйс гэх нэр томъёо нь эрэгтэй эмэгтэй хүний биологийн шинж чанаруудтай холбоотой бөгөөд тэдгээр шинжүүд нь төрөлхийн бөгөөд өөрчлөх боломжгүй байдаг. Харин нийгмийн үүргүүд өөрчлөгдөх боломжтой. Гол зорилго нь ялгавартай хандах үзлийг бий болгож байгаа нийгмийн харилцаануудыг эрх тэгш байдал ба шударга ёсонд тулгуурласан харилцаа болгон өөрчлөхөд оршиж байгаа юм. Бид хүйс болон жендэр хоёрын хоорондын зарим ялгааг /Хүснэгт 2.1/-т харууллаа.

### Хүйс ба Жендэр хоорондын ялгаанууд

### Хүснэгт 2.1

Жендэр	Хүйс
Эмэгтэй ба эрэгтэй хүнд нийгмээс оноосон үүрэг хариуцлага	Эрэгтэй ба эмэгтэй хүний биологийн шинжүүд
Цаг хугацаанаас шалтгаалан өөрчлөгдөнө.	Байнгын / тогтсон шинжүүд ба цаг хугацааны явцад өөрчлөгдөхгүй.
Өөр өөр соёл иргэншлийн хувьд ялгаатай.	Өөр соёл иргэншлийн хувьд ч ялгаагүй.
Боловсрол, орлогын түвшин, нас, нийгмийн гарал үүсэл, шашин болон бусад хүчин зүйлүүдэд нөлөөлөгддөг.	Эдийн засгийн ба нийгмийн хүчин зүйлүүдэд нөлөөлөгдөхгүй.



Зөвхөн эмэгтэйчүүдийн болон эрэгтэйчүүдийн дунд ч гэсэн тэдний нас, үндэс угсаа, орлогын түвшин, соёл, уламжлал болон бусад хүчин зүйлээс шалтгаалан ялгаатай байдаг.

Эмэгтэйчүүдийн болон эрэгтэйчүүдийн хувьд ч ижил.

## 2. Та жендэрийн мэдрэмжтэй хүн мөн үү? Асуулт хариулт, ярилцах

Оролцогчдыг 10 түлхүүрт асуултын аргын тусламжтайгаар жендэрийн мэдрэмжтэй эсэхийг олж тогтооно. Асуултад хариулсны дараа ярилцлага өрнүүлнэ. Нийт хугацаа 15 минут үргэлжилнэ.



### Жендэрийн мэдрэмжийн талаарх тайлбарлал

Бид жендэр хэмээх нэр томъёог ашиглаж байгаа зорилго нь эрэгтэй ба эмэгтэй байхтай холбоотой эдийн засаг, нийгэм ба соёлын тодотголуудад илүү анхаарлаа хандуулахыг хүсч байгаа юм. Аливаа нийгэм нь хүйсийн ялгаатай байдлуудаас үүдэн нийгмийн үүргийг “эмэгтэй” ба “эрэгтэй” хүнийх хэмээн тусгайлан оноосон байдаг. Үүнийг ойлгохын тулд бид жендэрийн мэдрэмж гэсэн ойлголтыг авч үзье.

### Жендэрийн мэдрэмжтэй гэдэг нь

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгмийн харилцаан дахь ялгаатай байдалд дүн шинжилгээ хийх шаардлагатайг ухамсарлах мөн сургалт, төсөл, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхээс өмнө эрэгтэй, эмэгтэй хүмүүст ялгаатай тусах зэрэг, сөрөг үр дүнг тооцдог чадварыг хэлнэ.

**Жендэрийн мэдрэмжтэй байх нь** алив нэгэн асуудлыг шийдвэрлэхдээ эрэгтэй ба эмэгтэй хүмүүст тэгш байдлаар хандах явдал юм. *Тодруулбал:*

1. Эрэгтэй ба эмэгтэй хүмүүсийн хооронд ямар ч ялгаа байхгүй гэж үзсэнээс аливаа асуудлыг ойлгоход жендэрийн харилцааг чухал биш гэж ойлгох.
2. Эрэгтэй ба эмэгтэй хүмүүсийн хоорондын нийгмийн харилцааг тал бүрээс нь авч үзэх чадвартай бөгөөд түүнийг нийгэм эдийн засгийн үйл ажиллагааны бүх хэсгүүдэд анхааралтай авч үзэх явдал.
3. Эрэгтэй ба эмэгтэй хүмүүсийн хоорондын ялгааг анхааралтай авч үзэх хэрэгтэйг ухамсарлах ба жендэрийн харилцааг шинжлэх.
4. Бодит байдал дээр жендэрийн ялгаатай байдал буюу зөрүүтэй явдал байсаар байхад энэхүү аливаа нөхцөл байдлыг авч үзэх, дүн шинжилгээ хийх, асуудлыг шийдвэрлэхдээ эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бодит байдлыг үл тоомсорлон хандах хандлага. / *Хавсралт 1.10* түлхүүрт асуулгын арга /



### 3. Багт хуваагдаж, илтгэл бэлтгэх

Оролцогчдыг санамсаргүй түүврийн аргаар дөрвөн багт хуваан, дараах дөрвөн асуудлыг авч үзье. Доор дурьдсан асуудал бүр дээр хүйстэй холбоотой нэг асуудал, жендэртэй холбоотой нэг асуудал, нийгэм эдийн засгийн хүчин зүйлтэй холбоотой асуудал нэгийг тус тус тодорхойлно. Ажилбар 30 минут үргэлжилнэ.

- Сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүд хүүхэд төрүүлэх үедээ амь насаа алдсаар байна.
- Өнөөгийн нийгэмд өсвөр насны охидын төрөлт нэмэгдэж байна.
- Эрчүүд биеэ үнэлэгчидтэй бэлгийн харьцаанд орж ДОХ/ХДХВ-г тараах явдал байсаар байна.
- Эрэгтэйчүүд нь нөхөн үржихүйн эрүүл мэндийн чанартай үйлчилгээг авах боломжгүй байна.

**Жендэр хэмээх ойлголт нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын харилцааг түүнд нөлөөлж байгаа нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлүүдийн хүрээнд авч үзэх хэрэгтэйг бидэнд сануулж байна. Эдгээр харилцан уялдааг авч үзэхийн тулд бид “жендэрийн харилцаа” гэсэн үг хэллэгийг хэрэглэдэг.**

#### **Жендэрийн харилцаа гэдэг нь:**

Энэ нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх үүрэг хоорондын хариуцлагыг болон тэдний эрэгтэй, эмэгтэй хүн гэдгийг тухайн соёл иргэншил нийгмийн зүгээс тодорхойлж байгаа арга зам юм.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харилцаанд нөлөөлж байгаа хүчин зүйлүүд, түүний дотор нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын өргөн хүрээний хүчин зүйлүүдийг авч үзэх шаардлагатай болно. Энэ нь хэдийгээр их цаг хугацаа шаардах төвөгтэй ажил мэт сонсогдож болох боловч тийм ч хүндрэлтэй асуудал биш.

Бид жендэрийн тэгш байдал ба тэгш боломжийн талаар одоо ярилцъя. Ижил утга агуулдаг мэт харагдах энэ хоёр үг хэллэгийг хоёуланг нь ашиглах ямар хэрэгтэй юм бол хэмээн та гайхаж байж магадгүй. Учир нь сүүлийн хэдэн арван жилд жендэр ба хөгжилтэй холбоотой асуудлууд хэрхэн үүсч хөгжиж ирсэнтэй холбоотой. Эмэгтэйчүүдийн олон хөдөлгөөнүүд ч цаг хугацааны явцад өөрчлөгдөн хөгжсөөр ирсэн. Хөдөлгөөний эхний үед эмэгтэй ба эрэгтэй хүмүүсийн эрхэлж байгаа албан тушаалын хоорондын ялгаатай байдал дээр илүү төвлөрч байсан ба тэд эрчүүд давамгайлсан нийгмийн харилцаанд эмэгтэйчүүд тэгш эрхтэй оролцох байдлын төлөө тэмцэж байсан. Нэг хэсэг бүлэг нь эрэгтэй ба эмэгтэй хүмүүсийн өвөрмөц хэрэгцээ, эрх мэдэл ба үзэл хандлага зэрэг ялгаатай талуудад анхаарлаа хандуулсан. Түүнчлэн эмэгтэйчүүдийн асуудал нь зөвхөн эмэгтэйчүүд

эрэгтэйчүүдтэй тэгш эрхтэй байх асуудлаар хязгаарлагдах ёсгүй гэж үзсэн. Нөгөө хэсэг бүлгийнхэн эмэгтэй эрэгтэй хүмүүсийн дунд байгаа ялгаатай байдал буюу ялангуяа арьс өнгө, үндэс угсаа, колончлогдож байсан түүх, бүс нутаг, хэл ба шашин зэргээс шалтгаалсан ялгаатай байдлуудад илүү анхаарлаа хандуулсан. Тэрээр эмэгтэйчүүдийн асуудал дан ганц нэг бүлгийн буюу ялангуяа зөвхөн барууны эмэгтэйчүүдийн асуудлаар тодорхойлогдох ёсгүй гэж үзсэн. Үүнээс улбаатай хоёр нэр томъёо бий болсон бөгөөд бидний өнөөдөр хэрэглэж байгаа утгыг илэрхийлэх болсон (Жендэрийн үндэсний хороо, 2008)

#### **Жендэрийн тэгш байдал гэдэг нь:**

Хүнийг хүйсээр нь ялгаварлан гадуурхахгүй байх явдлыг хэлнэ. Энэ нь нийгэм, эдийн засаг, иргэний болон улс төрийн амьдралд тэгш эрхтэй байх гэсэн утгатай.

#### **Жендэрийн тэгш боломж гэдэг нь:**

Эрэгтэй эмэгтэй хүмүүст тэгш, шударга болон зөв хандах чанар юм. Энэ нь эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдэд үүрэг, хариуцлага, аливаа нөөцийг хүртэх боломж, түүнийг захиран зарцуулах болон нийгмийн үр шимийг хүртэх боломж зэргийг хуваарилахдаа тэгш шударга хандах хандлагыг багтаадаг.

#### **4. Мэдлэгээ бататгах тоглоомын арга, дүгнэлт**

Оролцогчдыг 1 ба 2 дугаараар хоёр хэсэг болгоно. 1 дугаартай хэсэг нь дотор, 2 дугаартай хэсэг нь гадна талд өөд өдөөсөө харан тойрог болж зогсоно. Дараах нэр томъёонуудыг өөр хоорондоо ярилцана. Ярилцлага 10 минут үргэлжилнэ.

- Жендэр гэж юу вэ?
- Жендэрийн мэдрэмж гэж юу вэ?
- Жендэрийн харилцаа ямар хүчин зүйлүүдийн нөлөөн доор оршдог вэ?
- Жендэрийн тэгш байдал ба жендэрийн тэгш боломж ялгааг хэлнэ үү?

#### **Гол мессэж:**

- Жендэрийн ойлголтууд нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хүлээж байгаа өөр өөр үүрэг хариуцлага ба эрэгтэй эмэгтэй хүмүүс өөрсдийн амьдарч байгаа нийгэм, соёл иргэншил ба эдийн засгийн амьдралын хүрээнд хэрхэн харилцаж байгааг ойлгох нь чухал.
- Жендэрийн асуудлыг судлахын тулд хийх анхны алхам бол нийгэм эдийн засгийн өргөн утга агуулгын хүрээнд зөвхөн жендэртэй холбоотой асуудлууд юу байна, эсвэл зөвхөн хүйстэй холбоотой асуудлууд нь юу байгааг ялгаж салгаж ойлгох явдал чухал.

сэдэв  
**3**

ХҮНИЙ ЭРХИЙГ ТАНИЛЦУУЛАХ НЬ

**Зорилго:** ЕБС-ийн багш нарт хүний эрхийн тухай ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, хүний эрхийн хандлагад суурилсан сургалтын арга зүй төлөвшихөд нөлөөлөх,

**Зорилтууд**

- Хүний эрхийн талаар үндсэн ойлголт мэдлэгээ нэмэгдүүлэх
- Хүний эрхийн хандлагыг тодорхойлох
- Хүний эрхийн хандлагад суурилсан арга зүйг төлөвшүүлэх сэдэл төрүүлэх

**Үргэлжлэх хугацаа: 60 минут**

**Арга зүй:** Оролцооны болон танин мэдэх аргад тулгуурлан сургалтыг явуулна. Дараах оролцооны аргуудыг ашиглана.

- Мэдээлэлтэй танилцах
- Харилцан ярилцаж, хэлэлцэх, дүгнэлт хийх
- Багаар ажиллах,
- Тоглоомын арга

**Бүтэц:** “Хүний эрхийг танилцуулах нь” сэдэв нь дараах 5 хэсгээс бүрдэнэ.

1. “Шинэ гариг” тоглоом тоглох – 30 минут
2. Хүний эрх гэж юу вэ? Богино хэмжээний кино үзүүлэх – 10 минут
3. Кино болон тоглоомоос олж авсан хүний эрхийн талаарх шинэ мэдлэгийг тодорхойлж, ярилцах, дүгнэлт хийх /материал тарааж өгөх/ 10 минут
4. Хүний эрхэд суурилсан хандлагыг хамтран тодорхойлох, хүний эрхэд суурилсан хандлагын зарчмуудыг танилцуулах – 10 минут
5. Сэдвийн дүгнэлт хийх, уг хичээлээр олж авсан мэдлэгээ өөрсдийн ажил, сургалт, арга зүйдээ хэрхэн тусгах талаарх оролцогчдын байр суурь, дүгнэлтийг тодорхойлох – 10 минут

**Хэрэглэгдэх зүйлс:** Тараах материал, эрхийн болон амьдралын картууд, богино хэмжээний кино, флипчарт цаас, маркер



### 1. Шинэ гараг тоглоом /Хавсралт 2/

Хүмүүсийн хүний эрхийн талаарх ойлголт янз бүр байдаг. Үүнээс улбаалаад тэдний хүний эрхийн талаарх үзэл баримтлал, эрхэмлэх зүйл өөр өөр байдаг. Энэхүү ойлголтыг нэгтгэх, хүний эрх ямар чухал зүйл болох, аль нэг эрхийг илүү юмуу дутууд үзэх нь ямар эрсдэлтэй болох, хүний эрх нь хүнээс салгаж үл болох зүйл гэдгийг ойлгуулах зорилготой тоглоом юм. Тоглоом тоглоход 4 эрхийг илтгэх карт, 2 өөр дүрс бүхий амьдралын картуудыг хүний тоонд тохируулан урьдчилан бэлдсэн байна. Тоглоомын дүрмийг танилцуулсны дараа тогтоомыг эхэлнэ. Тоглоом 30 минут үргэлжилнэ.



### 2. Хүний эрх гэж юу вэ богино хэмжээний кино үзүүлэх

Оролцогчдоор хүний эрхийн үнэ цэнийг харуулсан тоглоом тоглуулсны дараа Хүний эрхийн тухай үндсэн ойлголтыг өгөх богино хэмжээний киног үзүүлнэ. Уг киног үзсэнээр сонирхолтой аргаар хүний эрхийн тухай ойлголтыг авч чадна. Мөн өмнөх тоглоомын үед мэдэрсэн хүний эрхийн талаарх мэдрэмж, ойлголтдоо дүгнэлт хийхэд тустай юм. Кино 10 минут үргэлжилнэ. /Хүний эрх гэж юу вэ?/ <https://www.youtube.com/watch?v=wP1v5ab2toU/>



### 3. Кино болон тоглоомоос олж авсан хүний эрхийн талаарх шинэ мэдлэгийг тодорхойлж, ярилцах, дүгнэлт хийх /тараах материал тарааж өгөх/

Энэ хэсэгт оролцогчдын тоглоом болон киноноос олж авсан шинэ мэдлэгийг тодорхойлохын тулд "Та бүхэн тоглоом тоглож, кино үзсэнээр Хүний эрхийн талаар ямар ямар шинэ мэдлэгийг олж авсан бэ?" "Хүний эрхийн талаарх таны бодолд ямар нэг өөрчлөлт орсон уу?" гэж асууна. Оролцогчид мэдээллээ солилцсоны дараа хүний эрхийн талаарх үндсэн ойлголтыг агуулсан материал тараах /Хавсралт3/



### 4. Хүний эрхийн суурь зарчмуудыг хамтран тодорхойлох, хүний эрхэд суурилсан хандлагын зарчмуудыг танилцуулах

Оролцогчдыг 2 баг болгоно. 1-р багаас Хүний эрхэд суурилсан хандлагын тодорхойлолтыг гаргахыг хүснэ. 2-р багаас Хүний эрхэд суурилсан хандлагын зарчмыг тодорхойлохыг хүснэ. Цаас, маркер тарааж өгнө. Тодорхойлолт гаргах хугацаа 5 минут байна. Үүний дараа багууд өөрсдийн гаргасан тодорхойлолтыг нөгөө багийн гишүүдэд уншиж, танилцуулна. Багууд тодорхойлолтоо танилцуулсны дараа Хүний эрхийн хандлага, түүний зарчмуудыг тодорхойлсон тараах материалыг тарааж өгч уншуулан өөрсдийн бичсэн тодорхойлолттой харьцуулахыг хүснэ. Дүгнэлт хийх хугацаа 5 минут байна.

## Хүний эрхийн суурь зарчимууд:

### Тэгш байх

Хүн болж төрснийхөө хувьд хүн бүр ижил үнэ цэнэтэй байж, адил хүндэтгэлийг эдэлнэ.

### Хуваагдашгүй байх

Иргэний, улс төрийн, нийгэм эдийн засаг, соёлын болон хамтын эрх зэрэг хүний бүх эрхүүд нэгдмэл, хуваагдашгүй байдаг.

### Ялгаварлан гадуурхахгүй байх

Арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдал болон бусад статусаас үл хамааран хэнийг ч ялгаварлан гадуурхах болохгүй.

### Харилцан хамааралтай байх

Хүний эрх нь орон гэр, сургууль, ажлын байр, зах зэрэг газар бүрт, амьдралын бүхий л хүрээг хамардаг. Өөрөөр хэлбэл аль нэг эрх нь зөрчигдөхөд бусад эрхүүдэд нөлөөлнө нөгөө талаар нэг төрлийн эрхийг хангах явдал сайжрахад өөр эрхийг эдлэх боломж илүү бүрддэг.

### Түгээмэл, салшгүй байх

Хүн оршин байгаа цагт эрхийг хүнээс тусгаарлах, салгах боломжгүй бөгөөд хүнээс салшгүй ойлголт юм.

Энэ дэлхийн аль ч өнцөгт байгаа аливаа эмэгтэй, эрэгтэй хүн, хүүхэд нь хүний төрлийг олж төрсний хувьд хүний эрхийг эдлэгч болдог. Тиймээс Хүний эрх нь ертөнцийн өнцөг, булан бүрт амьдарч байгаа хүн бүрт хамаатай. Иймд бүх хүн аливаа ялгаваргүйгээр тэгш хүртэх түгээмэл шинж чанартай.

### Хариуцлага тооцох:

#### Төртэй хариуцлага тооцох

Хүний эрхийг төр өөрийн үзэмжээр өгдөггүй. Төр нь хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахаас татгалзах, эсхүл хэсэг хүмүүсийн эрхийг хүндэтгэж, хамгаалж, хангаад бусад хүмүүсийн эрхээс татгалзах ёсгүй.

### Хүн үнэ цэнэ, нэр төртэй байх

Хүний үнэ цэнэ, нэр төр нь бүх хүмүүс хүн болж төрснийхөө хувьд ижил үнэлэгдэж, адил хүндлэл хүлээнэ гэдгийг баталгаажуулдаг. Бүх хүн нас, соёл, угсаа гарал, арьс өнгө, хүйс, бэлгийн чиг баримжаа, хэл, боломж чадвар, нийгэмд эзлэх байр суурь, иргэний харьяалал болон улс төрийн үзэл бодлоос үл хамааран ижил хүндлэлийг хүлээнэ.

### Хувь хүнтэй хариуцлага тооцох

Хүн бүр хүний эрхийг хүндэтгэх болон хүний эрхийг зөрчдөг байгууллага, хүмүүстэй тэмцэх үүрэгтэй.

### Бусад этгээдтэй хариуцлага тооцох

Корпорацууд, ТББ-ууд, сангууд, боловсролын байгууллага зэрэг нийгмийн бусад бүх хэсгүүд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үүргийг хүлээнэ.

## **Сэдвийн дүгнэлт хийх, уг хичээлээр олж авсан мэдлэгээ өөрсдийн ажил, сургалт, арга зүйдээ хэрхэн тусгах талаарх оролцогчдын байр суурь, дүгнэлтийг тодорхойлох**

Оролцогчдоос тухайн сэдвийн талаарх сэтгэгдлийг сонсож, олж авсан мэдлэгээ цаашид хэрхэн түгээх, өөрийн ажлын арга барилд хэрхэн тусгах талаар асууж харилцан туршлага солилцон, чөлөөт ярилцлага өрнүүлнэ. Чөлөөт ярилцлагын үеэр өөрсөддөө тохиолдож байсан хүний эрхийн бодит кейсээс хуваалцахыг хүснэ. Ярилцлагын хугацаа 10 минут байна.

### **Эрхээ мэдэх ямар ач холбогдолтой вэ?**

ЭРХЭЭ бүрэн дүүрэн эдлэх БОЛОМЖИЙГ олж авна. Эрхээ зөрчигдөж байна гэдгийг мэдэж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх арга хэмжээ авна. Үүгээр ч зогсохгүй эрхээ ЗӨРЧИГДӨХӨӨС ХАМГААЛЖ, түүнд нийцсэн баталгаа бүрдүүлэхийг төрөөс шаардах болно.

Эрхээ бүрэн дүүрэн эдлэнэ гэдэг нийгмийн амьдралд идэвхитэй ОРОЛЦОНО гэсэн үг. Таны оролцоо, хяналт улс төрчдийг хариуцлагатай болгож, хууль, төрийн бодлогыг сайжруулж, ингэснээр эрүүл нийгмийг бүтээх боломжтой. Эрүүл нийгэм биднийг энх тайван, амар амгалан амьдрал, хөгжил, дэвшилд хөтөлнө.

Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхийн тулд мөрдлөг болгох зарчмуудыг томьёолж ирсэн. Энэхүү зарчмыг амьдралд мөрдлөг болгох, бодит утгаар нь хэрэгжүүлэх нь хүн бүр эрх, эрх чөлөөгөө сэтгэл хангалуун эдэлж, эрхэмсэг оршихуйн баталгаа болох ёстой.

### **Гол мессэж:**

- Хүний эрх гэдэг бол хүнээс салгаж үл болох хамгийн чухал зүйл юм. Бусдын эрхийг ямагт хүндэтгэж байх нь чухал .
- Хүний эрхэд суурилсан хандлага яагаад байх ёстойг ойлгох, хүний эрхэд суурилсан хандлагын зарчмуудыг ойлгох.

## **Сэдэв 4**

### **БЭЛГИЙН БА НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРХ**

#### **Сэдвийн зорилго:**

Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрхийн талаар зөв, бодит мэдлэг олгох.

- Нөхөн үржихүйн эрүүл мэндийг өөрийн үгээр тодорхойлох
- Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрхүүдийг тоочих
- Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрхүүдийг зөрчсөн жишээ татах
- Бэлгийн ба нөхөн үржихүйн эрхүүдийн талаар зөв мэдээлэлтэй болох ач холбогдолын талаар саналаа илэрхийлэх

**Үргэлжлэх хугацаа: 60 минут**

### Арга зүй:

- Ярилцлага
- Кейс ажиллах,
- Нээлттэй хэлэлцүүлэг
- Багаар ажиллах

### Бүтэц:

1. Дасгал- 4 бүлэгт хувааж, кэйс уншиж танилцах, ярилцах – 15 мин
2. Дасгалын хэлэлцүүлэг – 20 мин
3. Бэлгийн ба нөхөн үржихүйн 12 эрхийг танилцуулах – 15 мин
4. Дүгнэлт – 10 мин

**Хэрэглэх зүйлс:** Тараах материал, балын харандаа, флипчарт цаас, маркер, скоч

## 1. Ярилцлага: Эрх гэж юу вэ? Нөхөн үржихүйн эрүүл мэнд /НҮЭМ/ гэж юу вэ?



Багш оролцогчдоос "Эрх гэж юу вэ?" гэж асууж өгч байгаа хариултуудаас эрхийг тодорхойлсон гол үгүүдийг самбар дээр бичнэ. /хүлээж байгаа хариулт, аливаа зүйлийг эдлэх, хийх гэх мэт/. Багш эрхийн тодорхойлолтыг /хавсралт 2/ самбарт харуулж, энэхүү хичээлээр бэлгийн болон НҮЭМ-ийн эрхүүдийн тухай суралцах болно гээд хичээлээ үргэлжлүүлнэ. Энэ сэдвийг орохын тулд бид бас НҮЭМ, бэлгийн амьдрал гэж юу вэ? гэсэн асуултанд хариулт авах ёстой.

### Нөхөн үржихүйн эрүүл мэнд

Нөхөн үржихүйн эрүүл мэнд нь зөвхөн нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоо нь өвчин эмгэггүй, эрүүл байх төдийгүй, бие махбодь, сэтгэл санаа, нийгмийн талаар бүрэн төгс эрүүл, хувь хүн, хосууд сэтгэл ханамжтай, аюулгүй бэлгийн амьдралтай, хэзээ, хэдэн хүүхэд төрүүлэх, өсгөх асуудлаа чөлөөтэй шийдвэрлэх байдал юм.

### Бэлгийн амьдрал

Бэлгийн амьдрал гэдэг нь бэлгийн зан үйл, түүнд нөлөөлж буй биологи, сэтгэл зүй, нийгмийн хүчин зүйлсийн цогц





## 2. Бэлгийн ба НҮЭМ-ийн эрх зөрчих – Дүрийн тоглолт

Багш оролцогчдыг 4 бүлэгт хувааж, дүрийн тоглолтын нөхцөлүүдийг хувааж өгнө /хавсралт 3/.

Бүлэг болгон нөхцөлтэй танилцаж, дүрийн тоглолт бэлтгэж, бүлэг тус бүр дүрийн тоглолтыг 5 минутын хугацаанд бусдад танилцуулна. Багш оролцогчдоос дүрийн тоглолтын дараа дараах асуултуудыг асууна: /20 мин/

- Хэний эрх зөрчигдөх гэж байна?
- Бэлгийн болон нөхөн үржихүйн аль эрх зөрчигдөх гэж байна?
- Эрх зөрчихөөс хамгаалахын тулд юу хийж болох вэ?

Багш зөв хариултыг танилцуулна.

### Дүрийн тоглолт

1. Л. 15 настай, эмэгтэй. Хэд хоногийн өмнө сургууль дээр нь эмчийн үзлэг хийсэн ба тэр өдрөөс хойш хичээлдээ явах сонирхолгүй болж, ганцаардаж эхэлсэн. Тэр хэдийгээр найзтай ч түүндээ болон аав ээждээ хэлэхээс болгоомжилж байгаа. Өөр сургуульд шилжин орох нь хамгийн зөв гэж бодож байгаа.
2. О. 17настай, жирэмсэн 17-18 долоо хоногтой. О-г төрөх үед жирэмсний хүндрэлээр ээж нь нас барсан, аав нь түүнийг 15 настай байхад өвчний улмаас нас барсан. О-ийн нагац ах эгч нар түүний жирэмснийг мэдээд маш их санаа зовж байгаагаас гадна үр хөндүүлэх нь зөв гэж бодож байна.
3. М. 13 настай, сэргэлэн, ухаалаг охин. Ээж, аав хоёр охиноороо их бахардаг, хайртай, амьдралдаа алдчих вий гэдгээс их эмзэглэдэг. Саяхнаас М-ийн сургуульд эрүүл мэндийн хичээлээр бэлгийн болон нөхөн үржихүйн талаар зааж эхэлсэн. М-ийн ээж, аав энэ сэдвээр огт ярьдаггүй бөгөөд, бэлгийн боловсрол олгосноор хүүхэд илүү задгай, замбараагүй болно гэдэгт итгэдэг билээ. Иймээс М-ийг тэр хичээлд оруулахгүй байх талаар сургуулийн захиргаатай ярилцахаар шийдсэн.
4. Д.Б 25 настай, хосууд, нэг ангид сурч байхаасаа үерхэж байгаад, сургууль соёл гэж явсаар гэр бүлээ батлуулж амжаагүй байжээ. Намрын дунд сарын шинийн 17-нд хуримаа хийхээр бэлтгэл ажил ихтэй, заваар хомс байгаа ч дүүргийн иргэний бүртгэл мэдээллийн газраас сэтгэл дундуур гарч иржээ. Учир нь “Та 2 хэзээ гэр бүл болсон бэ?” гэж асуухад хосууд шууд хариулж чадалгүй тулгамдаж, “Хурим хийх өдөр үү?” гэж эхнэр нь асуучихаж. Бүртгэгч эмэгтэй өрөөндөө олуулаа суудаг ба “Хэзээ, хаана харьцаанд орсноо мэдэхгүй одооны залуучууд уу?” гэж инээсэн байна.

### Дүрийн тоглолтын зөв хариулт

1. Л-ийн “хувийн нууцаа хадгалуулах” эрх зөрчигдөж байна.
2. О-ийн “Хүүхэдтэй болох эсэх ба хэзээ хүүхэдтэй болохоо шийдэх эрх”-ийг зөрчих гэж оролдож байна.
3. М-ийн “Мэдээлэл авах, сурч боловсрох эрх” зөрчигдөх гэж байна.
4. Д.Б-ийн “Бэлгийн эрх ” зөрчигдөж байна.



### 3. Бэлгийн ба нөхөн үржихүйн 12 эрх

Бэлгийн болон нөхөн үржихүйн 12 эрхийн /Хавсралт 4/-ийг оролцогчдод тарааж өгөн уншуулна. Уншсны дараа тус бүр дээр ярилцана. /15 мин/



### 4. Дүгнэлт /10 мин/

Сургагч багш оролцогчдоос дараах асуултуудыг асуун ярилцаж хичээлээ дүгнэнэ. Мөн оролцогчдоос сургалтын талаарх сэтгэгдэлийг сонсохоос гадна уг сургалтаас ямар ямар гол мессэж авсныг асууна, өмнөх дасгалуудын үеэр яригдаагүй нэмэлт мэдээллийг өгнө.

- Та нарын бодлоор бэлгийн ба нөхөн үржихүйн эрхүүдийн талаар зөв мэдээлэлтэй болохын ач холбогдол юу вэ? /хүлээгдэж буй хариулт: өөрийн эрхээ зөрчүүлэх байдалд орохгүй байх гэх мэт/
- Бэлгийн ба Нөхөн үржихүйн эрх зөрчигдөхөөс хэрхэн сэргийлэх вэ? / хүлээгдэж буй хариулт: зөв мэдээлэлтэй байх гэх мэт/

### Гол мессэж:

- **НҮЭМ гэдэг нь зөвхөн нөхөн үржихүйн эрхтэн тогтолцооны хувьд өвчин эмгэггүй, эрүүл байх төдийгүй, бие махбод, сэтгэл санаа, нийгмийн талаар бүрэн төгс эрүүл, хувь хүн, хосууд сэтгэл ханамжтай, аюулгүй бэлгийн амьдралтай, хэзээ, хэдэн хүүхэд төрүүлэх, өсгөх асуудлаа чөлөөтэй шийдвэрлэх боломжтой байхыг хэлнэ.**
- **Олон Улсын Гэр Бүл Төлөвлөлтийн Холбооноос олон улсын хүний эрхийн талаарх баримт бичгүүд болон бусад тунхаг бичгүүдийг үндэслэн Бэлгийн ба Нөхөн үржихүйн 12 эрхийг боловсруулан гаргасан билээ.**
- **Хүмүүс Бэлгийн ба НҮЭМ-ийн эрхийн талаар мэддэггүй эсвэл дутуу мэдлэгтэйгээсээ болж өөрийн эрхээ зөрчүүлэх байдалд ордог тул энэхүү эрхүүдийн талаар зөв, бодит мэдээлэл олгох нь нэн чухал юм.**
- **Бэлгийн ба НҮЭМ-ийн 12 эрх байдаг. Үүнд:**
  - Амьдрах эрх
  - Эрх чөлөөтэй ба халдашгүй дархан байх эрх

- Эрх тэгш байх болон бүх төрлийн ялгаварлан гадуурхлаас чөлөөтэй байх эрх
- Хувийн нууцаа хадгалуулах эрх
- Чөлөөтэй бодож сэтгэх эрх
- Мэдээлэл авах, сурч боловсрох эрх
- Гэрлэх, гал голомтоо үүсгэх эрх
- Хүүхэдтэй болох эсэх ба хэзээ хүүхэдтэй болохоо шийдэх эрх
- Эрүүл мэндийн тусламжинд хамрагдах, эрүүл мэндээ хамгаалуулах эрх
- Шинжлэх ухааны дэвшлийн үр шимийг хүртэх эрх
- Улс төрд чөлөөтэй оролцох ба эвлэлдэн нэгдэх эрх
- Эрүү шүүлт болон хүнлэг бус байдлаар хандахаас чөлөөтэй байх эрх

## СЭДЭВ 5

### БЭЛГИЙН ЗАН ҮЙЛ, ИЛЭРХИЙЛЭЛ

#### Сэдвийн зорилго:

Сургалтанд оролцогчдод бэлгийн зан үйл, илэрхийллийн талаар цогц ойлголт өгөх, улмаар зөв хандлага төлөвшүүлэх,

- Сэдвийн талаар тодорхой ойлголт, төсөөлөлтэй болж өөрсдийн чиг хандлагыг тодорхойлох
- Хэрэгцээ, шаардлагатай үед мэдээ, мэдээллийг хариуцлагатай, зөв ашиглахад туслах

**Үргэлжлэх хугацаа: 60 минут**

**Арга зүй:** Сургалтын оролцооны аргад тулгуурлана. Дараах аргуудыг ашиглана.

- Асуулт хариулт
- Нээлттэй хэлэлцүүлэг
- Оролцогчдын бие даасан дүгнэлт

**Бүтэц:**

1. Ойлголт тандах асуулт, хариулт - 20 мин.
2. Олон төрлийн зан үйлийн илэрхийлэл - 20 мин.
3. Хичээлийн дүгнэлт – 20 мин.

**Хэрэглэх зүйлс:** Тараах материал, самбар, маркер



### 1. Ойлголт тандах асуулт хариулт /20 мин /

Багш оролцогчдын бэлгийн зан үйлийн илэрхийллийн талаарх үндсэн мэдлэгийг тандаж мэдэх зорилгоор дараах 2 асуултыг нээлттэй тавина.

1. Бэлгийн харилцаа, секс гэж юу юм?
2. Ямар шалтгааны улмаас хүн бэлгийн харилцаанд ордог вэ?

Оролцогчдын хариултыг хэн нэгнээр самбар дээр бичүүлнэ. Шаардлагатай бол багш чиглүүлнэ. Асуулт хариултын үргэлжлэх хугацаа 15 минут



### 2. Олон төрлийн зан үйлийн илэрхийлэл /20 мин/

Багш холбогдох материал тарааж өгнө. Уншиж танилцах. "Буруу", "зөв", асуулт "яагаад" шалтгаан "ны талаар ярилцлага хийнэ. /Хавсралт 5/

- Хүмүүс тэр болгон хоорондоо ярьдаггүй ч бэлгийн янз бүрийн зан үйлийг хэрэглэдэг байна.
- Хүмүүсийн бэлгийн зан үйл нь эсрэг буюу ижил хүйстний дунд илэрдэг. /аман секс - 2 эр, 2 эм, эсвэл эр эм хүмүүс/
- Зарим төрлийн бэлгийн зан үйлээс хүмүүс зайлсхийж, татгалзаж болно. Гэхдээ бусад хүмүүс хоорондоо зөвшилцсөн тохиолдолд үүнийг хийж болохгүй гэсэн үг биш. Зарим нь хүлж, шийтгэхийг буруу гэхэд өөр хэн нэгэн үүнийг таашаадаг байж болно.
- Хамгийн гол нь аливаа бэлгийн зан үйл нь харилцан зөвшилцсөн байх шаардлагатай ба ийм тохиолдолд үүнийг "буруу" зан үйл гэж үзэх нь ташаа ойлголт.
- Бэлгийн харилцааны янз бүрийн төрөл байдаг гэдгийг мэдсэнээр түүнд хэрхэн яаж хандахаа өөрөө ойлгож мэдрэх хэрэгтэй. Ингэснээр ийм төрлийн мэдээлэл сонсоход цочирдохгүй бусдыг ойлгох, ялгаварлан гадуурхахгүй, зөв хандахад тус болно.
- Зарим төрлийн бэлгийн зан үйлийг гаж буруу, жам ёсноос гадуур гэж үзэх нь олонтаа байдаг. Энэ нь дэндүү хялбарчилсан дүгнэлт. /Амьтад хувцас өмсөж, сандал дээр сууж, машинаар аялдаггүй/.
- Ийм олон төрлийн бэлгийн илэрхийлэл байдгийг мэдэж ойлгосноор өөрсдийн хандлагыг тодорхойлох, энэ асуудлаар итгэж өөртөө хандсан хүмүүс /сурагч/-т нарийн зөвлөгөө өгөх, хэрэгцээт тусламж үзүүлэх, олж авсан мэдлэг, мэдээллийн үндсэн дээр өөрсдийн ажлын арга барилыг эргэн харж дахин боловсруулалт хийхэд тустай. Жишээ нь: Шулуун гэдсээр бэлгийн харилцаанд орсноор жирэмсэн болохгүй гэсэн ойлголт байдаг. Ингэснээр хамгаалалтгүй бэлгийн харилцаанд ордог ба энэ нь БЗХӨ авах магадлалыг улам ихэсгэдэг байна.



### 3. Бэлгийн харилцааны үнэлгээний үндсэн зарчим ба хэвлэл мэдээллийн хэрэгслийн нөлөөлөл 15 мин.

1. Багш бэлгийн зан үйлийн "сайн", "муу" гэж үнэлэх зарчмуудыг тайлбарлахын зэрэгцээ аюулгүй сексийн тухай ярилцлага өрнүүлэх
2. Хэвлэл мэдээллийн нөлөөллийн талаар оролцогчдын санал бодлыг хэлэлцүүлэх.

Бэлгийн харилцааг "сайн", "муу" гэж үнэлэхэд 3 үндсэн зарчмыг баримтлах ёстой.

1. Харилцан зөвшилцөл байх ёстой. /2 талын/
2. Зөвшилцөлд хүрэх насанд хүрсэн байх. /Бэлгийн насанд/ Хариуцлага хүлээх чадвартай. /Архи, мансууруулах бодис/
3. Аюулгүй байх ёстой. /Хүсээгүй хурьцал, халдварт өвчин, өвчлөлгүй байх/
  - Хэрэв хэн нэг нь зөвшөөрөөгүй бол үнсэж таалах хүртэл "муу"-д тооцогдоно.
  - Педофилоос бусад тохиолдолд дээрх 3 зүйл зөрчигдөөгүй бол буруутгаж шүүх хэрэггүй гэж үздэг.
  - Ямарваа нэг эмнэлгийн үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүс өөрсдийн үйлчлүүлэгчийг буруутгах, шүүх эрхгүй.



### 4. Сургалтын дүгнэлт 5 мин.

Багш оролцогчдоос сургалтын талаар сэтгэгдэлийг сонсож гол ямар мессеж авсныг асууна. Мөн шаардлагатай бол нэмэлт мэдээлэл өгнө.

#### Гол мессеж:

1. Хүмүүс янз бүрийн шалтгааны улмаас бэлгийн харилцаанд ордог. Шалтгаан нь тэр болгон ойлгомжтой байдаггүй. Иймээс энэ талаар нарийн мэдрэмжтэй байж **хүмүүсийн сонголтыг буруутгахгүй байх**. Хэрэв энэ асуудлаар хэн нэгэн хүн /сурагч/ илэн далангүй ярилцаж тусламж хүссэн тохиолдолд тэр хүн /сурагч/-ийг аль болох **эмзэглүүлэхгүй, үргээчихгүй чин сэтгэлээс хандах хэрэгтэй**.
2. Тухайн хүнд бэлгийн идэвхитэй амьдрал байгаа эсэх талаар шүүх нь тухайн хүн /сурагч/-ээс мэдээлэл авч чадахгүйгээр үл барам зарим тохиолдолд тэр хүн /сурагч/-ийг эмзэглүүлсэнээс болж шаардлагатай тусламж, эмчилгээ авч чадахгүйд хүргэх, улмаар бүр ноцтой сөрөг үр дагаварт хүргэх эрсдэлтэй байдаг.
3. Хүмүүс бэлгийн харилцаанд олон шалтгааны улмаас ордог төдийгүй бэлгийн **зан үйл нь янз бүрийн байдлаар илэрдэг**. Үүнийг дараагийн дасгалаас харж болно.

сэдэв  
**6**

**БЭЛГИЙН БОЛОН ХҮЙСИЙН ЧИГ БАРИМЖАА,  
ИЛЭРХИЙЛЭЛ**

**Сэдвийн зорилго:** Сургалтанд оролцогчдод бэлгийн болон хүйсийн баримжаа илэрхийлэлийн талаар цогц ойлголт өгөх, улмаар зөв хандлага төлөвшүүлэх.

- Бэлгийн болон хүйсийн баримжаа илэрхийллийг ойлгох, зөв тодорхойлж сурах,
- Бэлгийн болон хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой зөв хандлага төлөвшүүлэх.

**Үргэлжлэх хугацаа: 60 минут**

**Арга зүй:** Оролцооны аргад тулгуурлан сургалтыг явуулна. Дараах оролцооны аргуудыг ашиглана.

- Brainstroming буюу ухаан бодлоо уралдуулах
- Нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах
- Багаар ажиллах

**Бүтэц:** “Бэлгийн болон хүйсийн баримжаа илэрхийлэл” сургалт нь дараах 5 хэсгээс бүрдэнэ.

1. Ойлголт тандах асуулт, хариулт – 5 мин
2. Тодорхойлолт бүхий тест бөглөх – 15 мин
3. Тестийн мөрөөр ярилцах – 20 мин
4. Багт хуваагдаж, кейс дээр ажиллах – 15 мин
5. Сургалтын дүгнэлт – 5 мин

## **1. Ойлголт тандах асуулт хариулт**

Сургагч багш оролцогчдын бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийллийн талаарх үндсэн мэдлэгийг тандаж мэдэх зорилгоор дараах 2 асуултыг нээлттэй асууна.

1. Бэлгийн чиг баримжаа гэж юуг ойлгодог вэ?
2. Хүйсийн баримжаа илэрхийлэл гэж юуг ойлгодог вэ?

Тухайлбал таны хүйсийн баримжаа илэрхийлэл юу вэ?

Оролцогчдын өгсөн хариултыг флипчарт цаасан дээр дэс дараалуулан тэмдэглэж авна. Оролцогчид хариулт хэлж байх үед сургагч багш чиглүүлэх хариулт өгөхгүй. Асуулт хариултын үргэлжлэх хугацаа 5 минут байна

## 2. Тодорхойлолт бүхий тест дээр ажиллах /Хавсралт 6/

Сургагч багш оролцогчдод бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийллийн тодорхойлолтуудад тохирох зөв нэр томъёог олж бичих даалгавар бүхий 14 тодорхойлолттой тест тарааж өгнө. Энэхүү даалгаварыг оролцогчид бие даан гүйцэтгэнэ. Тест бөглөх нийт хугацаа 15 минут байна.

## 3. Тест дээр ажилласны дараа хийх ярилцлага

Тестээ бөглөж дууссаны дараа сургагч багш оролцогчдоос тест хэр хялбар эсвэл хүнд байсан талаарх сэтгэгдэлийг асууна. Мөн түүнчлэн тодорхойлолт тус бүрээр ярилцаж, оролцогчдын ойлголтын зөрүүг арилгана. Энэхүү дасгалыг ажиллуулснаар “хүний бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийлэл нь олон янз байдаг ба үүнээсээ улбаалан ялгаварлан гадуурхалтад өртөх ёсгүй юм” гэсэн гол ойлголтыг оролцогчдод өгнө. Ойлголтын зөрүүг арилгах ярилцлага нийт 20 минут үргэлжилнэ. Тусгайлан бэлтгэсэн танилцуулга (PPT) ашиглаж болно.

## 4. Багт хуваагдаж, кейс дээр ажиллах

Оролцогчдыг санамсаргүй байдлаар 4 багт хуваана. Багт хуваахдаа оролцогчдод 4 өөр өнгийн цаас тэнцүү тоогоор тараана. Багт хуваагдсаны дараа баг тус бүрт 1 бодит жишээ тарааж өгөх ба тухайн кейст бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийллийн ямар асуудлууд байгааг флипчарт цаасан дээр бичих даалгавар өгнө. Багууд ярилцаж дууссаны дараа өөрийн багийн даалгаврыг бусад багуудад танилцуулна. Энэхүү дасгалыг хийснээр оролцогчид бусдын бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийллийг зөвөөр ойлгож хүлээж авахаас гадна үл ялгаварлан гадуурхах хандлагад суралцана. Кейс дээр ажиллах дасгал нийт 20 минут үргэлжилнэ.

### Кейс 1

Нэгэн залуу сайхан ажил, сайн цалин, өөрийн гэсэн машинтай, орон гэртэй болсон учир ээж, аав нь түүнийг гэрлэх цаг нь болж гэж үзээд эхнэр авахыг шаарджээ. Гэвч тэр залуу гэрлэх дургүй, учир нь тэр эмэгтэй хүнд татагддаггүйгээ сайн мэддэг. Нилээн хэдэн жилийн туршид эрэгтэй хүмүүстэй бэлгийн харилцаанд орж байсан төдийгүй одоо сэтгэл таарсан залуутай удаан хугацааны харилцаа үүсгэх хүсэлтэй.

Энэ жишээнд бэлгийн болон хүйсийн баримжаа илэрхийллийн асуудал байна уу? Энэ залуу гомосексуал мөн үү? Асуултаа тайлбарлана уу?

### Кейс 2

18 настай хүү хотын олон нийтийн газруудаар явж, янз бүрийн

эрэгтэй хүмүүстэй амаар буюу бэлэг эрхтэнг хөхөх хэлбэрээр бэлгийн харилцаанд удаа дараа орж байсан. Түүнд өөрийнх нь ангийн хүү бас иймэрхүү газруудаар явдаг гэсэн мэдрэмж төрсөн боловч түүнээс шулуухан асуухаасаа эмээж байсан.

Энэ жишээнд ямар ямар асуудал тусгагдсан байна вэ? Энэ хүү гомосексуал уу? Асуултаа тайлбарлана уу?

### Кейс 3

32 настай эмэгтэй эмэгтэйчүүдийн эмчид үзүүлэх /ерөнхий үзлэгт хамрагдах/ гэж очжээ. Эмч түүнийг шинжилгээ хийлгэх, өндгөвчөө ЭХО-д харуулахыг зөвлөжээ. Гэтэл ЭХО-ны эмч тэр эмэгтэйг гэрлээгүй гэдгийг мэдээд яагаад ийм нарийн шинжилгээ хийлгэх гээд байгааг ойлгосонгүй гээд дотуур ЭХО үзлэг хийхээс татгалзжээ.

Эмч энэ эмэгтэйн бэлгийн амьдралын талаар ямар ойлголттой байна вэ? Жендэр болон бэлгийн мөн чанар, бэлгийн эрхтэй холбоотой ямар асуудлууд энэ жишээнд илэрч байна вэ? Эмчийн энэ хандлага нь эмэгтэйн бие махбодийн болон сэтгэл санааны эрүүл мэндэд ямар нөлөө үзүүлнэ гэж та бодож байна вэ?

### Кейс 4

Нэгэн эрэгтэй Итгэлийн утас руу залгаж “өөрийнхөө эхнэрийг эмэгтэй найзтайгаа сонин байдлаар хамт байж байхыг харлаа” гэж ярьжээ. Түүний хэлснээр тэр хоёр хагас нүцгэн нэг нэгнийхээ “болохгүй” газар оролдож байсан. Яагаад эхнэр нь өөртэй нь бэлгийн амьдралдаа таашаал авдаг хирнээ өөр эмэгтэйг сонирхоод байдгийг ойлгохгүй байна гэж яриу.

Та энэ эрэгтэйд юу гэж хэлэх вэ? Түүний эхнэр нь лесбиян мөн үү?

### Кейс 5

Нэртэй хуульчид нэгэн залуу хандаж өөрийнх нь хэргийг өмгөөлөхийг хүсчээ. Түүний ах нь өөрийг нь “өв залгамжлах эрх олж авах гэж хүйс солиулах хагалгаанд орсон гэж гүтгэж байна” гэж өөрийнхөө ахад гомдсон учираа хэлжээ. Гэтэл тэр хүүхэд байхаасаа эрэгтэй болох хүсэл мөрөөдөлтэй байсан ба түүндээ хүрэхийн тулд маш их зовлон бэрхшээлийг туулсан.

Жендэр болон бэлгийн мөн чанар, бэлгийн эрхтэй холбоотой ямар асуудлууд энэ жишээнд илэрч байна вэ? Та ахынх нь үйлдлийн талаар ямар үзэл бодолтой байна вэ?

### Кейс 6

Нэгэн жижиг хотод амьдардаг бүлэг хүмүүс Тайландад трансжендэр миссын тэмцээн болох гэж байгаа талаар олж мэджээ. Тэр хүмүүс өөрсдийгөө трансжендэр гэж тодорхойлдог бөгөөд бусдад өөрийгөө зөв таниулж цагийг сайхан өнгөрүүлээсэй гэж бодсоны улмаас өөрийн жижиг хотдоо бас иймэрхүү миссын тэмцээн зохион байгуулах зөвшөөрөл авахыг хүсжээ. Гэтэл захиргаанаас зөвшөөрөл олгохоос татгалзаж ийм арга хэмжээг явч дэмжихгүй гэдгээ илэрхийлжээ.



Жендэр болон бэлгийн мөн чанар, бэлгийн эрхтэй холбоотой ямар асуудлууд энэ жишээнд илэрч байна вэ? Энэ бүлэг хүмүүс тэмцээний зөвшөөрөл авахын тулд яаж нөлөөлж чадах вэ?

## 5. Сургалтын дүгнэлт

Сургагч багш оролцогчдоос сургалтын талаарх сэтгэгдэлийг сонсохоос гадна уг сургалтаас ямар ямар гол мессэж авсныг асууна. Мөн түүнчлэн сургагч багш өмнөх дасгалуудын үеэр яригдаагүй нэмэлт мэдээллийг өгнө

### *Гол мессэж:*

- *Бэлгийн чиг баримжаа гэдэг нь бэлгийн дур сонирхлын хувьд хэнд татагдаж байна вэ гэдэг мэдрэмж дээр үндэслэн хүн өөрийгөө хэн болохыг тодорхойлоход оршино. Эсрэг хүйсийн, ижил хүйсийн, эсвэл аль аль хүйсийн хүнд татагддаг байж болно.*
- *Хүйсийн баримжаа илэрхийлэл нь хүн өөрийгөө эрэгтэй, эмэгтэй, аль аль нь, эсвэл бүр өөр хүйсийн хүн гэж тодорхойлоход оршино.*
- *Хүний бэлгийн чиг баримжаа нь төрөлхийн шинж чанартай ба эхээс төрөхдөө ямар бэлгийн чиг баримжаатай байх нь тодорхойлогдсон байдаг.*
- *Бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийлэл нь бусдад ялгаварлан гадуурхагдах үндэс болох ёсгүй*

## 10 ТҮЛХҮҮРТ АСУУЛГЫН АРГА

### **Хэн юу хийдэг вэ?**

Энэ асуулт хэн ямар үүрэг хүлээдэг буюу юу хийж, ямар үйл ажиллагаа эрхэлдэгийг мэдэх зорилготой. Тухайн судалгааны хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг, хийдэг ажлын зонхилох хэлбэр мөн ялгаатай байдлыг харж болно. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн хуваарилалтын хэв шинж, ялгаатай байдлыг тодруулах эхний алхам болно.

### **Юугаар? Яаж?**

Эдгээр асуултаар ямар хөрөнгө, нөөцөөс хүртэж, ашиглаж ажил, үүргээ хэрэгжүүлдэгийг мэдэх зорилготой ба ямар баялаг, хөрөнгө, нөөцийг хэн, хэрхэн ашиглаж, хүртэж байгааг тодруулдаг.

### **Хэн юуг өмчилдөг вэ?**

Хөрөнгө, нөөцүүд ямар хэлбэрээр хэний өмчлөлд байгааг үүгээр мэдэж болно. Хөрөнгө, нөөц, баялаг хэний өмчлөлд байгаагаас олон зүйл шийдэгддэг тул энэ хэсэг нэлээд чухал юм.

*Дээрх гурван асуулт тухайн дүн шинжилгээний хүрээнд хамрагдах нийгэм, эдийн засгийн төлөв байдал дахь эдийн засаг, нийгмийн бодит байдлыг тодорхойлоход чиглүүлэгч болно.*

### **Хэн юуг хариуцдаг вэ?**

Энэ нь хүлээх хариуцлагын тухай асуулт бөгөөд хэн юуг юуны төлөө хариуцдагийг тодруулдаг.

### **Хэн ямар эрхтэй вэ?**

Үүнд хуулиар мөнбүтэц тогтолцоогоор олгогдсон эрхүүдээс гадна уламжлагдсан ёс заншилтай холбоотойгоор эдлэж байгаа эрхүүд орно. Энд хууль, дүрмээр эсвэл ёс заншил, уламжлалын дагуу өгөгдсөн эрхүүдийг ялгаж тодруулах нь зүйтэй.

### **Хэн юуг хянаж, захирдаг вэ? (орлого, зардал)**

Энэ асуултаар үйл явц, үр дүн, ашиг орлогыг хэн хянаж, захиран зарцуулах талаарх зохицуулалт, удирдлагын тогтолцоог тодруулдаг.

### **Хэн юуг шийддэг вэ?**

Шийдвэр гаргах эрх мэдлийн хуваарилалт мөн оролцоог тодорхойлоход дээрх асуултын хариултыг авч судалдаг.

*Дээрх 4-7 дугаар асуултууд нь талуудын эрх мэдэл, тэдний хяналтад байдаг хөрөнгө, нөөц мөн үйл ажиллагаа зэргээс гадна тэднээс хүлээгдэж байдаг хүлээлтүүд юу байж болохыг ч тодорхой харуулдаг.*

### **Хэн ямар ашиг хүртдэг вэ?**

Хэн юу хүртдэг буюу ашиг, орлого мөн бүтээсэн баялаг хэрхэн хуваарилагдаж буйг энэ хэсэгт мэдэж болно.

### **Хэнд ашигтай, хэнд хохиролтой вэ? (Хэн илүү хэрхэн өртөж байна вэ?)**

Тухайн харилцааны нөхцөл байдал нь хэнд ашигтай, давуу талуудыг бий болгодог мөн хэнд хохиролтой эсвэл сул талуудыг бий болгож байгааг эндээс тодруулна.

### **Нөхцөл байдлын суурь шалтгаан нь юу вэ?, Яагаад ?**

Тогтсон нөхцөл байдал мөн жендэрийн харилцаа нь хууль, дүрэм мөн бүтэц тогтолцооноос үүдэлтэй юу эсвэл тухайн газар, орон нутагт баримталдаг хэм хэмжээ, зан заншил, уламжлагдсан дадал хэвшилтэй нь холбоотой эсэхийг тодорхойлоход дээрх асуултыг хэрэглэдэг.

*Сүүлийн гурван асуулт нь нөхцөл байдал хэнд ашиггүй, хохиролтойг мөн хэнд ашигтай, ямар давуу боломжуудыг бий болгож байгааг тодорхойлдог тул өөрчлөлтийг хэн илүү хүсэж байна, хэн нь яагаад нөхцөл байдлыг өөрчлөхийг хүсэхгүй байгааг харуулдаг. Түүнчлэн нөхцөл байдлыг өөрчлөхгүй байх үндсэн шалтгаан нь хууль тогтоомж, эрх мэдлийн бүтэц тогтолцоо, дүрэм журамд байна уу эсвэл ёс заншил, уламжлалд суурилсан эсэхийг ойлгоход тусалдаг. Цаашилбал эдгээр асуултыг асууж хариултад дүн шинжилгээ хийснээр ямар өөрчлөлт хэрэгтэй байгааг харж болно*

## ШИНЭ ГАРИГ ТОГЛООМ

### Хууль №1

“Шинэ гаригийн эрхэмсэг иргэдээ, тавтай морилно уу! Та нар аз жаргалтай, нөхөрсөг гаригийн хүмүүс. Та бүхэн шинэ хүмүүстэй танилцахдаа хэзээд баяртай байдаг бөгөөд өөрийнхөө тухай тэдэнд ярьж өгөх маш дуртай. Энэ гаригийн иргэний хувьд, хүн бүр дараах 4 эрхийг баталгаатай эдэлнэ:

**НЭГДҮГЭЭРТ:** та бүхэн бие махбодийн хувьд аюулгүй байх эрхтэй – энэ эрх та бүхнийг бие махбодийн хувьд гэмтэхээс хамгаалдаг. Хүн бүрт бие махбодийн аюулгүй байдлыг илэрхийлсэн карт өгөх болно. (Оролцогчдод “бие махбодийн аюулгүй байдал” гэсэн картыг үзүүл).

**ХОЁРДУГААРТ:** та бүхэн бусдаар хүндлүүлэх эрхтэй – энэ эрх тантай хүнлэг бусаар харьцах, таныг ялгаварлан гадуурхахаас хамгаалдаг. Хүн бүрт бусдаар хүндлүүлэх эрхийг илэрхийлсэн карт өгөх болно. (Оролцогчдод “бусдаар хүндлүүлэх” гэсэн картыг үзүүл).

**ГУРАВДУГААРТ:** та шийдвэрүүдээ өөрөө гаргах боломжоор хангагдах эрхтэй – энэ эрх мөнгө, өмчтэй болоход тань, эсвэл мэдээлэл авахад тань бусдын зүгээс саад хийхээс хамгаалдаг. Хүн бүрт шийдвэрүүдээ өөрөө гаргах боломжийг илэрхийлсэн карт өгөх болно. (Оролцогчдод “шийдвэрээ өөрөө гаргах боломж” гэсэн картыг үзүүл).

**ДӨРӨВДҮГЭЭРТ:** та бэлгийн амьдралаа өөрөө мэдэх, хянах эрхтэй – энэ эрх таныг хүчээр гэрлүүлэх, бэлгийн харьцаа, арилжааны сексд хүчээр оруулах, эсвэл өөр ямар нэгэн хүсээгүй бэлгийн үйлдэл хүчээр хийлгэхээс хамгаалдаг. Хүн бүрт бэлгийн амьдралаа өөрөө мэдэх, зохицуулах эрхийг илэрхийлсэн карт өгөх болно. (Оролцогчдод “бэлгийн амьдралаа өөрөө мэдэх, хянах” гэсэн картыг үзүүл).

За, Шинэ гаригийн баяр баясгалантай иргэдээ, ирээд картуудаа авна уу. Хүн бүр сая дурдсан эрхүүдийг илэрхийлсэн 4 карт авах ёстой шүү. Тэгээд үргэлжлүүлээд мэнд усаа мэдэлцээд явна уу.”

Оролцогчид үргэлжлүүлэн мэнд усаа мэдэлцэх зуур амьдралын картуудыг 2 ангилан ширээн дээр өрж тавь. 3 минут өнгөрсний дараагаар “Анхаараарай!” гэж өндөр дуугаар зарлаад оролцогчдын анхаарлыг өөр дээрээ бүрэн төвлөрүүл.

“Хоёрдугаар хуулийг уншиж танилцуулах цаг боллоо” гэж хэлээд дараах текстийг уншиж өг:

### Хууль №2

“Шинэ гаригийн эрхэмсэг иргэдээ, манай гаригийн нийт хүн амыг хоёр хэсэгт хуваах боллоо. Та нарын тал нь “дөрвөлжин” болно, тал нь “дугуй” болно. Хүн бүр энэ хоёр бүлгийн аль нэгийг төлөөлсөн карт авна, энэ бол таны Амьдралын карт. Шинэ гариг дээр амьд явахын тулд та зайлшгүй Амьдралын карттай байх ёстой. Ирээд нэг, нэг карт аваад энгэртээ зүүнэ үү. Тэгээд урьд өмнөх шигээ мэнд усаа

үргэлжлүүлэн мэдэлцээд явна уу.” 3 минутын дараа оролцогчдыг зогсоогоод хамгийн сүүлчийн буюу гуравдугаар хуулийг уншиж өг:

### Хууль №3

“Шинэ гаригийн эрхэмсэг иргэдээ! Цаг үе өөрчлөгдлөө. Энэ мөчөөс эхлэн дугуйнууд дөрвөлжингүүдээс илүү эрх мэдэлтэй болсныг албан ёсоор мэдэгдэж байна. Би алгаа ташихад (хонх дуугаргах, шүгэл үлээх) мэнд усаа мэдэлцэж буй дугуй, дөрвөлжин хоёрын дугуй нь дөрвөлжингийнхөө 4 эрхийн нэгийг нь буюу тухайн эрхийг илэрхийлсэн картыг хурааж авах болно. Иргэд өмнөх шигээ л үргэлжлүүлэн мэнд усаа мэдэлцэж явна. Намайг алгаа таших бүрт дугуй нь учирсан дөрвөлжингийнхөө нэг эрхийг хурааж авсаар байх болно. Хэрэв дугуйн учирсан дөрвөлжин нь ганц ч эрхгүй болсон бол дугуй нь түүний Амьдралын картыг авна. Амьдралын картгүй болсон дөрвөлжин нь тоглоом дуустал хөшсөн мэт доошоо харж, гараа унжуулан хөдөлгөөнгүй, чимээгүй зогсоно. Ийм эрсдэл нүүрлэж байгаа хэдий ч дөрвөлжингүүд урьд өмнөх шигээ дугуйнуудтай учирч, мэнд усаа мэдэлцээд л явах ёстой. За, та бүхэн үргэлжлүүлээд мэдээллээ солилцож явна уу.”

*Үе үе алгаа таш (хонхоо дуугарга, шүгэлээ үлээ). Оролцогчдын 3-ны 1 нь “хөшсөн” хойно “Зогс!” гэж өндөр дуугаар зарлаад тоглоомыг зогсоо. Тэгээд “Шинэ гаригийнхан байнга хийдэг ажлаа түр зогсоогоод одоо хэлэлцүүлэг өрнүүлнэ” гэж хэл. Оролцогчдыг том тойрог болгон суулга. Дараах асуултаудыг тавин Шинэ гариг дээр амьдрах ямар байсан тухай хэлэлцүүлэг өрнүүл:*

- а. “Дөрвөн эрхээ авахад ямар санагдсан бэ? Ямар мэдрэмж төрсөн бэ?”*
- б. “Та нарыг дугуй болон дөрвөлжин болгон хуваахад ямар санагдсан бэ? Ямар мэдрэмж төрсөн бэ?”*
- в. “Дөрвөлжингүүдээ, дугуйнуудад илүү эрх мэдэл өгөхөд ямар санагдсан бэ? Ямар мэдрэмж төрсөн бэ? Эрхийг тань хэзээ л бол хэзээ хурааж авах аюул дор амьдрах ямар санагдсан бэ? Ямар мэдрэмж төрсөн бэ? Энэ нь таны биеэ авч явах байдалд хэрхэн нөлөөлсөн бэ?”*
- г. “Дугуйнуудаа, бусдаас илүү их эрх мэдэлтэй байх ямар санагдсан бэ? Ямар мэдрэмж төрсөн бэ?”*

*Дараах маягаар Шинэ гариг болон бидний амьдарч буй нийгмийг харьцуулан шинжил:*

### а. Оролцогчдод дараах асуултаудыг тавь:

- i. “Хүн бүр бидний эдэлж байсан шиг 4 эрхтэй байх ёстой юу?”*
- ii. “Бидний амьдарч буй нийгэмд хүмүүс өөр өөр бүлгүүдэд ийнхүү хуваагдсан, “ангилагдсан” байдаг уу?” (Хэрэв “хүйсээр” буюу “эрэгтэй, эмэгтэйгээр ангилагддаг, ялгагддаг” гэж дурдагдахгүй бол үүнийг нэмж хэлээрэй.)*
- iii. “Нийгэм нэг бүлэг хүмүүст өөр бүлэг хүмүүсээс илүү эрх мэдэл өгөх нь ямар үр дагавартай вэ?”*
- iv. “Нийгэм ийнхүү зарим хүмүүст илүү их эрх мэдэл олгох нь шударга уу?”*

- v. “Манай нийгэм ихэвчлэн хэнд, ямар бүлэг хүмүүст илүү эрх мэдэл олгодог вэ?”
- vi. “Зарим хүмүүс энэ эрх мэдлээ бусдын эрхийг үл хүндэтгэх, бусдыг дарамтлахад ашигладаг уу?”
- vii. “Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх мэдлийн тэнцвэргүй байдал эмэгтэйчүүдийн амьдралыг (өөрөөр хэлбэл, тэдний сонголт, хөдөлгөөн, боломжуудыг) хэрхэн хязгаарладаг вэ?”

#### б. Дараах тайлбарыг өг:

“Эмэгтэй, эрэгтэй хоёр эрх мэдлийн тэнцвэргүй байдалтай байхад эрэгтэй нь эрх мэдлээ эмэгтэйд хянаж, дарамтлахад ашиглаж байна гэж үздэг. Нийгэм, хамт олны гишүүд эрх мэдлийн энэ тэнцвэргүй байдлын талаар эргэцүүлж боддоггүй, эсвэл түүнийг хүлээн зөвшөөрдөг, эсэргүүцэж дуугардаггүй тул эрх мэдлийн тэнцвэргүй байдал нь оршин тогтносоор байдаг. Энэ байдал өөрчлөгдөхийн тулд бид өөрчлөлтийг өөрсдөө эхлүүлэх хэрэгтэй.”

**в. “Энэ өрөөнд сууж буй бид бүгд бие биенийхээ эрхийг хүндэтгэдэг хүмүүс” гэж хэл.** Тэгээд оролцогчдыг Шинэ гаригтаа эргэж очоод, мэнд усаа мэдэлцээд, хүн бүр 4 эрхийн карттай болтол картуудаа буцаан тарааж өгнө үү гэж урь.

### Хавсралт 3

#### Хүний эрх гэж юу вэ?

##### Хүний эрхийн ойлголт түүний зарчмууд

“Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүсийн ёсоор харилцах ёстой”.

##### Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 1 дүгээр зүйл

Хүний эрх нь хүнд төрөхөөс заяагдсан эрхүүд юм. Хүний эрх нь хүний нандин чанар, хүний үндсэн эрх, эрх чөлөөнд харшлах үйлдлээс хувь хүн болон аливаа бүлгийг үндэсний, олон улсын хуульчилсан хэм хэмжээгээр хамгаалагддаг. Өөрөөр хэлбэл хүний эрх бол таныг хүний зэрэгтэй, нэр төртэй амьдрахад шаардагдах наад захын баталгаа юм.

#### Хүний эрх хэнд хамаарах вэ?

Хүн бүрт хамааралтай. Өөрөөр хэлбэл, хүн бүр ямар ч ялгаваргүйгээр эрх, эрх чөлөөгөө эдлэх ёстой. Хүний эрх түгээмэл учраас дэлхийн хаана ч ижил дээдлэгдэх учиртай.



ХҮЙС



ШАШИН



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ



НИЙГМИЙН БАЙДАЛ



ГАДААД БАЙДАЛ



НАС



БЭЛГИЙН ЧИГ БАРИМЖАА



ГЭР БҮЛТЭЙ БАЙДАЛ



БОЛОВСРОЛЫН БАЙДАЛ

#### Эрхээ мэдэх ямар ач холбогдолтой вэ?

ЭРХЭЭ бүрэн дүүрэн эдлэх БОЛОМЖИЙГ олж авна. Эрхээ зөрчигдөж байна гэдгийг мэдэж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх арга хэмжээ авна. Үүгээр ч зогсохгүй эрхээ ЗӨРЧИГДӨХӨӨС ХАМГААЛЖ, түүнд нийцсэн баталгаа бүрдүүлэхийг төрөөс шаардах болно.

Эрхээ бүрэн дүүрэн эдэлнэ гэдэг нийгмийн амьдралд идэвхитэй ОРОЛЦОНО гэсэн үг. Таны оролцоо, хяналт улс төрчдийг хариуцлагатай болгож, хууль, төрийн бодлогыг сайжруулж, ингэснээр эрүүл нийгмийг бүтээх боломжтой.

Эрүүл нийгэм биднийг энх тайван, амар амгалан амьдрал, хөгжил, дэвшилд хөтөлнө.

Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхийн тулд мөрдлөг болгох зарчмуудыг томъёолж ирсэн. Энэхүү зарчмыг амьдралд мөрдлөг болгох, бодит утгаар нь хэрэгжүүлэх нь хүн бүр эрх, эрх чөлөөгөө сэтгэл хангалуун эдэлж, эрхэмсэг оршихуйн баталгаа болох ёстой.

## БЭЛГИЙН БА НӨХӨН ҮРЖИХҮЙН 12 ЭРХ

### 1. Амьдрах эрх

1.1 Эмэгтэй хүн жирэмслэлтээс болж амь нас нь хүндрэх, амь дүйсэн байдалд орж болохгүй. Үүнд “хэт эрт” “хэт ойрхон” “хэт олон” “хэт орой” гэсэн өндөр эрсдэлтэй жирэмслэлтийн хүчин зүйлүүд багтана.

1.2 Хүүхдийн амь хүйснээс хамааран эрсдэлтэй эсвэл амь дүйсэн байдалд байж болохгүй.

1.3 Хүний амь бэлгийн болон НҮЭМ-ийн тусламж үйлчилгээний хүртээмж, мэдээлэл, зөвлөгөө тааруу зэргээс болж эрсдэлтэй юмуу амь дүйсэн байдалд байж болохгүй.

1.4 Охин нярай, бага насны хүүхэд нь амиа хороох эрсдэлээс ангид байна.

### 2. Эрх чөлөөтэй ба халдашгүй дархан байх эрх

2.1 Бүх хүн бусдын эрхийг хүндэтгэх, өөрсдийн бэлгийн болон нөхөн үржихүйн амьдралыг чөлөөтэй хянаж, таашаал авах эрхтэй.

2.2 Бүх хүн өөрсдийн бүрэн, чөлөөт, мэдээлэгдсэн байдлаар бэлгийн ба НҮЭМ-тэй холбоотой эмнэлгийн туршилтаас чөлөөт байна.

2.3 Эмэгтэй хүн бүр бэлэг эрхтнийг зэрэмдэглэх бүх хэлбэрээс ангид байна.

2.4 Бүх хүн бэлгийн тарчлаан зовоох байдлаас чөлөөт байна.

2.5 Бүх хүн өөрсдийн бэлгийн чадавхи бууруулах болон бэлгийн хавьтлын талаарх буруу ташаа ойлголт болон бусад физиологийн хүчин зүйлүүд дээр үндэслэгдсэн гадны албадлага айдас, ичгүүр, гэм буруу болон сүсэг бишрэлээс чөлөөтэй байх

### 3. Эрх тэгш байх болон бүх төрлийн ялгаварлан гадуурхалаас чөлөөтэй байх эрх

3.1 Ямар ч хүнийг яс үндэс, арьс өнгө, хүйс, гэрлэлтийн байдал, гэр доторхи байр суурь, нас, хэл яриа, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал үүсэл, ядуу зүдүү байдал, өмч хөрөнгө, төрөлт болон бусад нөхцөл байдлаас болж ялгаварлаж үл болно.

3.2 Хүн бүр яс үндэс, арьс өнгө, хүйс, гэрлэлтийн байдал, гэр доторхи байр суурь, нас, хэл яриа, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал үүсэл, ядуу зүдүү байдал, өмч хөрөнгө, төрөлт болон бусад зүйлийг харгалзахгүйгээр эрүүл мэндээ хамгаалах, сайн сайхан аж төрөхөд бэлгийн ба нөхөн үржихүйн талаар мэдээлэл боловсрол олж авах, зөвлөгөө авах, үйлчилгээнд адил тэгш хамрагдах эрхтэй.

3.3 Бүх эмэгтэйчүүд ба охид өөрсдийн амьдралын агшин бүрийг дэмжих тохирсон хоол унд хэрэглэх эрхтэй бөгөөд аль нэг хүйсийг дутуу эсвэл давуутайд үзэх эрэгтэй, эмэгтэйчүүдийн үүргийн талаар хэвшсэн үзэл санаанд дулдуйдсан



атгаг сэжиг, ёс заншил чөлөөт байх эрхтэй.

**3.4** Ямар ч эмэгтэй хүнийг бэлгийн болон НҮЭМ-ийн үйлчилгээ, түүний хөгжил дэвшлийн талаар мэдээлэл авах, боловсрол эзэмших үйл ажиллагаанд ялгаварлаж үл болно.

**3.5** Ямар ч хүнийг тухайлсан хүн амын бүлгийн эсрэг ялгаварлан гадуурхсан ямар нэг бэлгийн болон НҮЭМ-ийн хөтөлбөрт хүчээр хамруулж үл болно.

**3.6** Бүх хүн өөрсдийн яс үндэс, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болоод бусад санаа бодол, үндэсний эсвэл нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрөлт бусад байдлын улмаас үүссэн хүчирхийллийн бүх хэлбэрээс өөрийгөө хамгаалуулах эрхтэй.

**3.7** Эмэгтэй хүн бүр жирэмсэн эсвэл хүүхэд төрүүлсний улмаас нийгэм ахуй болон ажил эрхлэлтийн хүрээнд ялгаварлан гадуурхагдахаас хамгаалуулах эрхтэй.

**3.8** Ямар ч хүн нас, хүйс, оюуны болон биеийн хөгжлийн доголдолтой байдлын улмаас бэлгийн болон НҮЭМ, үүнтэй холбоотой хэрэгцээ бүхий эрүүл мэндийн халамж, үйлчилгээ авахад ялгаварлан гадуурхагдах ёсгүй.

#### **4. Хувийн нууцаа хадгалуулах эрх**

**4.1** Бэлгийн ба НҮЭМ-тэй холбоотой тусламж үйлчилгээ, зөвлөгөө, мэдээлэл нь үйлчлүүлэгчийн бие даасан эрхийг хангаж хувийн мэдээллийг баталгаатай нууцлах ёстой.

**4.2** Бүх эмэгтэйчүүд нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлаар чөлөөтэй сонголт хийх эрхтэй. Үүнд аюулгүй баталгаат үр хөндөлтийн асуудал ч хамаарна.

**4.3** Бүх хүн баталгаатай, сэтгэл хангалуун бэлгийн амьдралтай байхын хамт уг эрхээ эдлэхдээ бусдын эрх, сайн сайхныг анхаарч мөрдөлт, мөшгилт эсвэл эрх чөлөө буюу нийтийн оролцооны хязгаарлалтаас айхгүй байна.

**4.4** Бэлгийн болон НҮЭМ-ийн мэдээлэл, зөвлөгөө зэрэг бүх үйлчилгээ нь хувь хүний болоод хосууд ялангуяа залуучуудын өөрсдийнх нь бие даасан байдал болон нууцыг хамгаалах эрхийг хүндэтгэх ёсон дээр үндэслэсэн байна.

#### **5. Чөлөөтэй бодож сэтгэх эрх**

**5.1** Бүх хүн өөрсдийн бэлгийн болон нөхөн үржихүйн амьдралын талаар үг хэлэх, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй.

**5.2** Бүх хүн өөрсдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл ахуйтай холбогдсон сургалт болон мэдээлэл авах, бодол, дотоод сэтгэл болон шашны улмаас үүссэн хязгаарлалтын эсрэг хамгаалуулах эрхтэй.

**5.3** Эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд нь үйлчилгээг тухайлбал жирэмслэхээс хамгаалах арга болон үр хөндөлтийг шууд хийхэд бэлэн бус тохиолдолд үйлчлүүлэгч өөрөө татгалзах эрхтэй. Амь насанд нь аюул тохиолдсон

эгзэгтэй үед энэ эрх хамаарахгүй.

5.4 Бүх хүн бэлгийн болон НҮЭМ-ийн үйлчилгээ, бусад асуудлыг бодож сэтгэх эрх чөлөөг хязгаарлах хэрэгслүүр болсон шашны номлол, сүсэг бишрэл, гүн ухааны болон ёс заншил тайлбарлахаас хол чөлөөтэй байх эрхтэй.

#### 6. Мэдээлэл авах, сурч боловсрох эрх

6.1 Бүх хүн өөрийн нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндтэй холбоотой боловсрол олж авах, зөв мэдээллээр хангагдах эрхтэй бөгөөд энэ мэдээлэл нь аль нэг хүйсийг илүүд үзэх бус, хэвшмэл үзлээс ангид байхын сацуу бодит, шүүмжлэлтэй болон олон ургальч аргаар илэрхийлэгдсэн байна.

6.2 Бүх хүн өөрсдийн нөхөн үржихүйн болон бэлгийн амьдралтай холбоотой ямар нэгэн шийдвэр гаргахад хангалттай байхууц бүрэн, чөлөөтэй, боловсрол ба мэдээллээр хангагдах эрхтэй.

6.3 Бүх хүн хүсээгүй жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх болон төрөлтийг зохицуулах бүх аргуудын давуу болон сул тал, эрсдэлийн талаар бүрэн мэдээлэл авах эрхтэй.

#### 7. Гэрлэх, гал голомтоо үүсгэх эрх

7.1 Хүн бүр тухайн хүний бүрэн, чөлөөтэй бус болон сайн дурын зөвшөөрөлгүйгээр гэрлүүлэхээс хамгаалуулах эрхтэй.

7.2 Бүх хүн тухайлбал бэлгийн замын халдварт өвчний улмаас жирэмслэх эсэх нь эргэлзээтэй болсон, үргүйдэлтэй хүн ч НҮЭМ-ийн тусламж үйлчилгээ авах эрхтэй.

#### 8. Хүүхэдтэй болох эсэх ба хэзээ хүүхэдтэй болохоо шийдэх эрх

8.1 Бүх эмэгтэйчүүд НҮЭМ-ээ хамгаалах, эсэн мэнд амаржих, амь насанд аюулгүй баталгаатай үр хөндөлтийн үйлчилгээ авах зэргээр шаардлагатай мэдээлэл, боловсрол, үйлчилгээ авах эрхтэй бөгөөд энэ нь үйлчлүүлэгчид хялбар дөхөм, боломжтой, тохиромжтой байх хэрэгтэй.

8.2 Бүх хүн төрөлтийг зохицуулах найдвартай, үр дүнтэй, тохиромжтой арга хэрэглэх ба чөлөөтэй сонгох эрхтэй.

8.3 Бүх хүн хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх аюулгүй болон боломжийн аргыг чөлөөтэй сонгох, хэрэглэх эрхтэй.

#### 9. Эрүүл мэндийн тусламжинд хамрагдах, эрүүл мэндээ хамгаалуулах эрх

9.1 Хүн бүр бэлгийн болон НҮЭМ, эрүүл мэндийн талаарх чанартай үйлчилгээг хүртэх эрхтэй.

9.2 Хүн бүр ХДХВ/БЗДХ өвчин ба үргүйдлийг оношлох, эмчлэх, аюулгүй баталгаат үр хөндөлтийн үйлчилгээ, төрөлтийг зохицуулах зэрэг эрүүл мэндийн бүх төрлийн цогц үйлчилгээ авах эрхтэй.

**9.3** Бүх хүн, охид эмэгтэйчүүд эрүүл мэндэд харш уламжлалт аргуудаас хамгаалуулах эрхтэй.

**9.4** Бүх эмэгтэйчүүд зөв мэдээлэл дээр суурилсан жирэмслэлт, төрөлт, үргүйдлийг зохицуулах талаар зөвлөгөө авах ба өөрөө шийдвэр гаргах эрхтэй.

**9.5** Бүх хүн эрүүл мэндийн анхан шатны тусламжийн нэг хэсэг болох бэлгийн ба НҮЭМ-ийн цогц, хүртээмжтэй, санхүүгийн болон газар зүйн байршлын хувьд тохиромжтой, нууцыг хадгалсан үйлчилгээг авах эрхтэй.

**9.6** Бүх эмэгтэйчүүд жирэмслэлтэй холбоотойгоор төрсний дараах үе ба жирэмсэн болон хөхүүл үеийн хугацаанд тохирсон хоол, хүнс хэрэглэх эрхтэй.

**9.7** Бүх хүн эрүүл мэнд, ажиллах орчноо аюулгүй байлгах, нөхөн үржихүйн эрхээ сахин хамгаалахын төлөө тэмцэх эрхтэй.

**9.8** Ажиллаж буй эхчүүд жирэмсний амралт тэтгэмж болон нийгмийн халамжийн бусад мөнгөн тусламж авах эрхтэй.

**9.9** Бүх хүн бэлгийн болон НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээнд хамрагдах дараах эрхүүдийг эдлэх эрхтэй. **Үүнд:**

- *Бэлгийн болон НҮЭМ-ийн тусламж үйлчилгээний ашиг тус, хүртээмж, эрхийн талаар мэдээлэл авах*
- *Нас, хүйс, бэлгийн чиг хандлага, гэрлэлтийн байдал, шашин шүтлэг, улс төрийн итгэл үнэмшил, нийгмийн гарал үүсэл, хөгжлийн бэрхшээл зэргээс хамаарахгүйгээр үйлчилгээ авах.*
- *Төрөлтийг зохицуулах аргуудаас чөлөөтэй сонгох*
- *БЗДХ, хүсээгүй жирэмслэлт, хүчирхийлэлээс хамгаалах аюулгүй байдал*
- *Зөвлөгөө үйлчилгээг тохиромжтой орчинд авах*
- *Хувь хүний нууцыг хадгалуулах*
- *Хүндлэлтэй, эелдэг найрсаг, анхаарал халамжтай харьцаа*
- *Үйлчилгээ авахад тохилог байх*
- *Баталгаатай үйлчилгээг үргэлжлүүлэн авах*

*Авч буй үйлчилгээнийхээ талаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх*

## **10. Шинжлэх ухааны дэвшлийн үр шимийг хүртэх эрх**

**10.1** Бүх хүн үргүйдэл, жирэмслэлтээс хамгаалах арга, үр хөндөлттэй холбоотой НҮЭМ-ийн тусламж үйлчилгээний шинэ техник, технологи ашиглаж эрүүл мэндээ хамгаалах эрхтэйгээс гадна эрүүл мэндэд нь хохирол учруулж болох технологиос татгалзах эрхтэй.

**10.2** Бүх хүн өөрсдийн эрүүл мэнд, сайн сайхан амьдралын тусын тулд НҮЭМ-ийн тусламж үйлчилгээнд ашиглаж буй эрүүл мэндэд нь хохирол учруулж болох технологиос татгалзах эрхтэй.

**10.3** Бүх хүн найдвартай, баталгаатай НҮЭМ-ийн технологи, тусламж үйлчилгээ авах эрхтэй.

### **11. Улс төрд чөлөөтэй оролцох ба эвлэлдэн нэгдэх эрх**

**11.1** Бүх хүн бэлгийн болон НҮЭМ, түүний эрхийн төлөө санал бодлоо солилцох, цуглах, хэлэлцэх эрхтэй.

**11.2** Бүх хүн бэлгийн болон НҮЭМ-ийг дэмжих зорилгоор эвлэлдэн нэгдэж нийгэмлэг байгуулах эрхтэй.

**11.3** Бүх хүн бэлгийн болон НҮЭМ, түүний эрхийн талаар Засгийн газарт нөлөөлөх үйл ажиллагаа явуулах эрхтэй.

### **12. Эрүү шүүлт болон хүнлэг бус байдлаар хандахаас чөлөөтэй байх эрх**

**12.1** Хүүхдийг ашиглах хэлбэрүүд тухайлбал: бэлгийн сэдэлттэйгээр ашиглах, биеэ үнэлэх, бүх төрлийн бэлгийн гаж зуршилд ашиглах, хүчирхийлэх, доромжлох, тарчлаах, хууль бус бэлгийн үйл ажиллагаанд хүч хэрэглэн оруулах, хүүхдийг мөнгө олох зорилгоор ашиглах ба садар самуун кино, дүрс бичлэг, сурталчилгааны материалд ашиглахаас хамгаалуулах эрхтэй.

**12.2** Ямар ч хүнийг түүний бүрэн чөлөөт байдал ба сайн дурын зөвшөөрөлгүйгээр туршилтын аливаа эмчилгээнд албадан оруулж үл болно. Ялангуяа бэлгийн болон жирэмслэлтийг зохицуулах эмчилгээний арга техникийг хүн дээр турших ёсгүй.

**12.3** Бүх эмэгтэйчүүд нь биеэ үнэлүүлэх, худалдагдахаас хамгаалуулах эрхтэй.

**12.4** Бүх иргэд, эмэгтэй эрэгтэй хүмүүс бэлгийн болон нөхөн үржихүйтэй нь холбоотой хүчирхийлэл, доройтуулах эмчилгээнээс хамгаалуулах, ялангуяа зэвсэгт мөргөлдөөний үед хамгаалуулах эрхтэй.

**12.5** Бүх хүн бэлгийн хүчирхийлэл, доромжлол, хэрцгийлэл, бэлгийн гаж зуршлаас хамгаалуулах эрхтэй.

Хавсралт 5

**Бэлгийн зан үйлийн олон төрөл, илэрлүүд**

Нэр томъёо	Тайлбар
Шулуун гэдсээр бэлгийн харилцаанд орох	Өөрийн бэлэг эрхтэн, хуруу бусад эд зүйлсийг хавьтагчийн шулуун гэдсэнд хийх
Аналингус	Ам хэлээр хавьтагчийн хошногоны нүхээр оролдох
Аутоэротик бүтэлт	Гар хангалга хийх үед амьсгалаа боож дур тавилтыг хүчтэй болгох нь зарим тохиолдолд санамсаргүй амь насанд хүрэх аюултай.
Бестиалит	Ямар нэг амьтантай бэлгийн харилцаанд орох. Үүнд аман секс, шулуун гэдсээр болон үтрээгээр бэлгийн харилцаанд орох хамаардаг.
Хазах	Хамтрагчийн бие, ялангуяа хүзүү, мөрийг хөхөртөл хазаж, шимэх
Дарлал ба шийтгэл	Хамтрагчаа хүлэх аргаар хөдөлгөөнийг хязгаарлан бие мах бодь болон сэтгэл санааны хувьд хүмүүжүүлэх, шийтгэх маягаар дарлаж бэлгийн харилцаанд орох. Энэ шийдэлд хоёр хамтрагчийн аль алиных нь бэлгийн дур хүсэл хүрдэг ба үүнийг хоёр тал зөвшилцөж байж үйлддэг.
Куннулингус	Эмэгтэйн бэлэг эрхтэнийг уруул, амаар оролдох
Хуурай бэлгийн харилцаа	Үтрээг зориудаар хуурай болгож үрэлтийн мэдрэмжийг нэмэгдүүлэх. Ингэснээр эрэгтэйн хувьд таашаал авах мэдрэмж ихэсдэг ч эмэгтэйн хувьд үтрээ урагдаж гэмтэх, улмаар бэлгийн замаар дамжих халдвар авах эрсдэл улам нэмэгдэх аюултай

Эротали	Сэрэл өдөөх элдэв зүйлс хэлж, ярих
Эксгиционизм	Бэлэг эрхтэнийг ил гаргаж бэлгийн таашаал мэдрэх
Фантази	Сэрэл хөдөлгөх зүйлс төсөөлж бодох
Феллат	Эрэгтэй хүний бэлэг эрхтэнийг амаар өдөөж сэрэл хөдөлгөх /эр/эм/
Фетишизм	Дотуур хувцас, гутал, савхи гэх мэт эд зүйлсээр сэрэл өдөөх
Хуруу, гараа хийх	Хамтрагчийн анус, үтрээрүү хийх
Флагелац	Хамтрагч эсвэл өөрийгөө ташуураар сэрлээ хөдөлгөх
Фротаж	Биесээр үрэлцэж хоёулаа таашаал авах
Үнсэлцэх	Хавьтагчийн уруул болон биеийг үнсэж таашаал авах
Гар хангалга	Бэлэг эрхтэнээ үрж бэлгийн таашаал авах. Хийсвэр төсөөлөл, порнографи, секс тоглоом зэргийг ашиглах.
Харилцан гар хангалга	Хамтрагчид бэлэг эрхтэнээ гараар эсвэл секс тоглоомоор үрж сэрлээ өдөөх. Мөн өөртөө гар хангалга хийж байгаагаа харах байдал хамаарагддаг.
Некрофили	Хүний цогцосийг төсөөлж бодох, оролдох эсвэл хавьтаж бэлгийн таашаал мэдрэх
Озонагли	Хүний биеийн үнэр үнэрлэж сэрлээ хөдөлгөх
Порнографи	Бэлгийн харилцааг харуулсан кино, видео бичлэг үзэх, эсвэл бэлгийн харилцааны тухай хэвлэсэн материал уншиж сэрлээ хөдөлгөх, давхар гар хангалга хийх магадлалтай.

Садомазохизм	Биеийн болон сэтгэл санааны зовлон учруулж байж бэлгийн таашаал авдаг / садист/ ба ийм зовлон мэдэрч байж таашаал авдаг /мазохист/ хүмүүсийн бэлгийн харилцаа. Дүрд тоглох, ташуурдах, хүлэх г.м. төрөл бүрийн хэрэгслийг ашиглаж болдог.
Бэлгийн харилцаа	Хөвчирсэн бэлэг эрхтэнээ үтрээрүү хийх. Үүнээс гадна аливаа нэвтрэн орох бэлгийн үйлдлийг бас ингэж тодорхойлдог байна.
Тоглоом	Тоглоом гэдэг нь сэрэл хөдөлгөх зорилготой ашигладаг янз бүрийн эд зүйлсийг хэлдэг. Хиймэл бэлэг эрхтэн бас ордог байна.
Жаран ёс	Бэлгийн харилцаанд орж буй хосууд нэгэн зэрэг биесийн бэлэг эрхтнийг амаар оролдож таашаал мэдрүүлэх
Трибадизм	Бэлгийн таашаал мэдрэх зорилгоор өөрийн бэлэг эрхтэнийг хамтрагчийн гуя эсвэл бэлэг эрхтэнд үрэх
Троилизм	Гурван хүн нэгэн зэрэг бэлгийн харилцаанд орох
Войеризм	Бусдын хурьцал үйлдэж байгааг харах, сонсох эсвэл усанд орж байгааг харж бэлгийн таашаал авах

### Асуулт 1

Энэ жагсаалтаас Та алийг нь “зөв” хэлбэр гэж үзэж байна? 3 хэлбэрийг сонгоно уу.

### Асуулт 2

Энэ жагсаалтаас Та алийг нь “буруу” хэлбэр гэж үзэж байна? 3 хэлбэрийг сонгоно уу.

### Асуулт 3

Та ямар шалгуураар дээрх сонголтыг хийсэн бэ?

### Дасгал ажлын зорилго:

- Бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийллийг ойлгож, тодорхойлж сурах
- Баримжаа илэрхийлэлтэй холбоотой өөр хүмүүст тохиолддог бэрхшээл, туршлагаас судлах

### Хугацаа: 15 минут

Доорх тодорхойлолтуудыг уншиж жагсаалтаас уг тодорхойлолтод тохирсон нэр томъёог оноож тавина уу!

Асексуал	Гомосексуал	Куийр
Бисексуал	Гомофоби	Хүйсээ солиулсан хүн
Гей	Интерсекс	Трансжендэр
Гетеросексуал	Лесбиян	Транссексуал
Гетеросексизм	Эрэгтэй хүн	Трансвестит
Эмэгтэй хүн		

1. Бэлгийн дур сонирхлын хувьд ижил болон эсрэг хүйсийн хүнд татагддаг хүн.

Хариулт:

2. Бэлгийн дур сонирхлын хувьд ижил хүйсийнхээ хүнд татагддаг хүн.

Хариулт:

3. Бэлгийн дур сонирхлын хувьд эсрэг хүйсийн хүнд татагддаг хүн.

Хариулт:

4. Бүх хүн гетеросексуал байх ёстой гэсэн үзэл баримтлал ба энэ нь хүмүүст байх ёстой “зөв”, “хэвийн” бэлгийн баримжаа илэрхийлэл гэсэн ойлголт. Энэ үзэл баримтлал нь бусад бэлгийн баримжаа илэрхийллийг үгүйсгэхэд хүргэдэг.

Хариулт:

5. Өөрийгөө эмэгтэй гэж тодорхойлсон хүн буюу эмэгтэй хүний бэлэг эрхтэн, нөхөн үржихүйн эрхтэн байхгүй байж болно.

Хариулт:



6. Бэлгийн дур сонирхлын хувьд ямарч хүнд татагддаггүй хүн.

Хариулт:

7. Гомосексуал хүмүүсийг үл хүлээн зөвшөөрч, ямарч үндэслэлгүйгээр тэднээс айх явдал. Энэ нь гомосексуал хүмүүсийг ялгаварлан гадуурхах, алагчлах, ад үзэх, үзэн ядах байдлаар илэрхийлэгддэг.

Хариулт:

8. Эрэгтэй, эмэгтэй аль альнийх нь физиологийн шинж тэмдэгтэй төрсөн хүн. Ийм хүмүүс өөрөө өөрийгөө эрэгтэй эсвэл эмэгтэй гэж тодорхойлно.

Хариулт:

9. Бэлгийн дур сонирхлын хувьд эмэгтэй хүнд татагддаг эмэгтэй хүн.

Хариулт:

10. Өөрийгөө эрэгтэй гэж тодорхойлсон хүн буюу эрэгтэй хүний бэлэг эрхтэн, нөхөн үржихүйн эрхтэн байхгүй байж болох хүн.

Хариулт:

11. Бэлгийн дур хүслээ төрүүлэх зорилгоор эсрэг хүйсийнхээ хүний хувцсыг өмсдөг хүн. Ихэвчлэн эмэгтэй хүний хувцс өмсдөг эрэгтэй хүн байдаг

Хариулт:

12. Гетеросексуал үзэл баримтлалын эсрэг байдаг хүн. Үүнд гомосексуал, гей, интерсекс, лесбиян, трансжендэр хүмүүс хамаарна. Зарим үг энэ хүмүүст доромжлол мэт санагдаж болох боловч бусад нь үүнийг өөрийн эрч хүчээ илэрхийлэх байдал болгон ашиглаж, үүгээр дамжуулан өөрсдийн гетеросексуал биш, нийгэмд давамгайлсан гетеросексуал үзэл баримтлалын эсрэг байр суурьтай, өөрийгөө гетеросексуал гэж үздэггүй хүмүүст оноосон элдэв нэрэнд сэтгэл дундуур байдгаа илэрхийлдэг.

Хариулт:

13. Нэг хүйсээс нөгөө хүйсрүү шилжилт хийхэд шаардлагатай олон төрлийн үйл явц. Үүнд гормоны эмчилгээ, үс шилжүүлэн суулгах, үс арилгах, хэл яриа засах гэх мэт процедур орох ба хүний бэлэг эрхтэн, зарим тохиодолд нөхөн үржихүйн эрхтэнг өөрчлөх мэс ажилбар орно.

Хариулт:

14. Өөрийн хүйсээ төрөлхийн хүйсээсээ өөрөөр тодорхойлдог хүн. Өөрийгөө “гурав дахь” хүйсийн хүн гэж тодорхойлж магадгүй, үгүй ч байж магадгүй. Трансжендэр хүмүүс

**нь эмэгтэй хүний хувцас өмсөж, эмэгтэй хүн шиг биеэ авч явдаг эрэгтэй хүн байж болно. Эсвэл эрэгтэй хүний хувцас өмсөж, эрэгтэй хүн шиг биеэ авч явдаг эмэгтэй хүн байж болно. Харин гомосексуал биш**

Хариулт:

### **Ашигласан материал**

1. Жендэрийн үндэсний хороо, (2008). Жендэрийн агуулгатай бодлого үйл ажиллагаа. Гарын авлага 1. Жендэрийн үндсэн ойлголтууд (хууд. 15). Улаанбаатар.
2. [http://gametlibrary.worldbank.org/FILES/453\\_Guidelines%20for%20gender%20sensitive%20indicators%20-%20summary.pdf](http://gametlibrary.worldbank.org/FILES/453_Guidelines%20for%20gender%20sensitive%20indicators%20-%20summary.pdf)

АГУУЛГА  
ХОЁРДУГААР ХЭСЭГ

ӨСВӨР НАСНЫ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛСАН  
“БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ, ЭРҮҮЛ МЭНД” СУРГАЛТЫН  
ХӨТӨЛБӨР

Оршил

Сэдэв 1	Хүний эрхийн тухай үндсэн ойлголт.....	53
Сэдэв 2	Жендэрийн тухай ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх нь.....	55
Сэдэв 3	Бэлгийн орон зай, бэлгийн эрх.....	57
Сэдэв 4	Бэлгийн зан үйл.....	58
Сэдэв 5	Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл.....	60
Хавсралт 1	Сургалтын үнэлгээний хуудас.....	63
Хавсралт 2	Сургалтын жишиг хөтөлбөр.....	64
Хавсралт 3	Эрэгтэй эмэгтэй хүмүүс юугаараа ялгаатай вэ?.....	65
	асуулгын хуудас	

## Оршил

Их дээд сургууль болон Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутнууд, ЕБС-ийн ахлах ангийн сурагчид нь бэлгийн эрх болон нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийн асуудлаар тодорхой мэдлэг туршлага хуримтлуулсан байдаг билээ. Харин зарим тохиолдолд найз нөхөд, үе тэнгийнхнээс авсан мэдээлэл нь тэр бүр үнэн зөв байдаггүй учир бэлгийн болон нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийн асуудлаар үнэн зөв мэдээлэл өгөх замаар тэдний мэдлэг, хандлага, зан үйлд нь нөлөөлөх зорилгоор сургалтын модулийн энэ хэсгийг боловсруулж байна. Сургалтад 14-22 насны өсвөр насны болон оюутан залуусыг оролцуулна.

Сургалтаа явуулахын өмнө болон дараа нь оролцогчдынхоо нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудлаарх мэдлэгийг тогтоох ба сургалт дууссаны дараа мэдлэг нь хэрхэн нэмэгдсэнийг харьцуулж үзэх хэрэгтэй. /Хавсралт 1/

Өсвөр насны хүүхдүүд болон залуучуудад зориулсан сургалтын хөтөлбөр нь бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлыг дасгал, кейс дээр ажиллах, мэдлэгийг сорих асуулга дээр ажиллах байдлаар сургалтыг явуулна.

## Сургалтын бэлтгэлийг хэрхэн хангах вэ?

- Сургалтын хөтөлбөрийг 1 өдөрт багтаан хийхээр гаргана. /Хавсралт 2/
- 2 болон түүнээс дээш сургагч, чиглүүлэгч оролцоно.
- Сургалтад 24 оролцогч хамруулах нь оролцооны аргыг хэрэглэхэд тохиромжтой (6, 6 хүнтэй 4 бүлэгт хуваагдах боломжтой).
- Мэдээллийн багц тараах (хөтөлбөр, танилцуулга, бүлгийн ажлын зааварчилгаа г.м-ийг багтаасан байх)
- Бичиг хэргийн зүйлс (өнгийн маркер, өнгийн цаас, хайч, скоч, цавуу, самбар флипчарт, нөүтбүүк, проектор, дэлгэц, нэр бичих пайз)
- Сандлыг (урдаа тавиуртай сандал байвал бүр сайн) тойруулж байрлуулна.
- Анх суухдаа оролцогчид дурын суудалд сууна. Гэхдээ бүлгийн ажил бүрийн өмнө оролцогчдын байрлалыг сольж, өөр өөр багт оруулбал зүгээр. Ийнхүү бүлгүүдийн бүрэлдэхүүнийг дахин, дахин өөрчлөх нь оролцогчдод илүү олон хүнтэй танилцаж, олон янзын хүнтэй харилцаж, хамтран ажиллаж, нүүр хагарахад тус болно.
- Чиглүүлэгч болон сургагч нар сургалтын үеэр багуудад орон хамтдаа ажиллаж болно. Гэхдээ өөрөө давамгайлахгүй байх, оролцогчдын оролцоог жигд байлгах зохицуулалтыг байнга хийж байх хэрэгтэй.

## Танилцах цаг

**Зорилго:** Оролцогсад, чиглүүлэгч- сургагч нарыг хооронд нь танилцуулах, нүүр хагалах, хөгжилтэй, дулаан бүлээн уур амьсгал бүрдүүлэх

**Хугацаа: 25 минут**

**Хэрэглэгдэх зүйлс:** өнгийн цаас, цавуу, хайч, олон өнгийн маркер бичгийн цаас гэх мэт бичиг хэргийн зүйлс

Хэрхэн явуулах вэ? Оролцогчид өөрсдийгөө илэрхийлэх гар хийнэ (зурж болно, өнгийн цаас хайчлаад хийж болно). Зааварчилгааг өгөхдөө өөрийнхөө гарыг ямар ч байдлаар, чөлөөтэй сэтгэж хийж болохыг чиглүүлэгч тайлбарлана. Таван хуруун дээрээ өөрийгөө илэрхийлэх 5н зүйлсийг бичнэ, эсвэл зургаар илэрхийлж, хайчилж наана.

*Оролцогч бүр гараа танилцуулна. Чиглүүлэгч нар ч мөн оролцож өөрсдийгөө танилцуулна.*

## СЭДЭВ

### 1

## ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

**Зорилго:** Хүний эрх гэж юу вэ, хүн бүр өөрийн гэсэн эрхтэй гэдгийг ойлгох

**Зорилт:** Хүний суурь эрхийг хэлэлцэж, эдгээр нь хоорондоо хэрхэн уялдаж байгааг оролцогчдод ойлгуулах.

**Хугацаа: 30 мин**

№	Сэдвийн хуваарилалт	Хугацаа	Тайлбар
1	"Хүний эрх гэж юу вэ?" баримтат кино	10 минут	<a href="https://www.youtube.com/watch?v=wP1v5b2toU/">https://www.youtube.com/watch?v=wP1v5b2toU/</a>
2	15 минут	5 минут	
3	Дүгнэлт		

**Хэрэглэгдэх зүйлс:** Самбарын цаас, маркер тараах болон, нэмэлт материал: Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал

**Арга зүй:** Кино, дасгал ажиллуулах

### 1. “Хүний эрх гэж юу вэ?” кино үзүүлэх

Хүн бүр өөрийн гэсэн эрхтэй. Хүний эрх бол хэрэгцээнээс үүдэлтэй. Хүний эрхийн үүднээс харвал хүн бүр амьд явах төдийгүй нэр төртэй амьдрах адил тэгш эрхтэй бөгөөд нэр төртэй амьдруулахын тулд хүн бүрт тодорхой суурь нөхцөл, боломжуудыг хангаж өгсөн байх шаардлагатай.

/ <https://www.youtube.com/watch?v=wP1v5ab2toU//>

### 2. Дасгал ажиллуулах

#### Дасгалын танилцуулга.

Хүний эрх нь хүний хэрэгцээнээс үүдэлтэй бөгөөд хүн болгонд эдгээр эрх нь хэрэгтэй, шаардлагатай гэдгийг тайлбарлаж дасгалаа эхлүүлнэ. Хүний эрх нэгдмэл, хоорондоо уялдаа холбоотой, харилцан хамааралтай нэгийг нь зөрчвөл ноцтой үр дагавар гарч болдгийг харуулах зорилгоор энэ дасгалыг хийж байгааг тайлбарлах.

Оролцогчдыг 5, 5 хүнтэй 4 багт хуваагаад Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалаас бэлгийн болон нөхөн үржихүйн эрхүүдээс сонгуулж, энэ эрх нь зөрчигдвөл хүмүүст ямар ямар үр дагавар гарахыг хэлэлцэх даалгавруудыг багуудад өгнө.

**Анхаарах зүйл:** Сургагч багш оролцогчид олон үр дагавар нэрлэж болох ч хамгийн ноцтой гарсан 3 үр дагаврыг сонгож төвлөрөхийг зөвлө.

Баг бүрээс гарсан илтгэгч нь багийнхаа ажлыг тайлбарлана. Дараах асуултуудын дагуу хэлэлцүүлэг хийнэ.

- Аль нэгэн эрх зөрчигдсөнөөс үүсэх эдгээр үр дагаврын дотор таны санаанд ороогүй шинэ зүйл нэрлэгдсэн үү
- Нэгээс олон эрх зөрчигдвөл юу болох вэ?
- Ямар үр дагавар нь хүүхдүүдэд хамгийн ноцтой сөрөг нөлөө үзүүлэх вэ?
- Энэ дасгалаас эрхийн харилцан хамаарлын талаар юу ойлгосон бэ? (жишээлбэл хүний эрхийг бүрэн эдлэхийн ач холбогдлын тухай)

сэдэв  
2

ЖЕНДЭРИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ МЭДЛЭГИЙГ  
НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

**Зорилтууд:** Жендэрийн талаар ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх,

**Хугацаа: 33 минут**

№	Сэдвийн хуваарилалт	Хугацаа	Тайлбар
1	"Эрэгтэй эмэгтэй хүмүүс юугаараа ялгаатай вэ?" асуулгын хуудсыг тарааж оролцогчдоор бөглүүлнэ.	5 минут	<b>Хавсралт 3</b>
2	"Эрэгтэй эмэгтэй хүмүүс юугаараа ялгаатай вэ?" асуулгын хэлэлцүүлэг, тайлбар	15 минут	
3	Хүйс болон жендэрийн тодорхойлолт танилцуулах	3 минут	
4	Жендэрийн үүргийг мэдрүүлэх дасгал	10 минут	

**Хэрэглэгдэх зүйлс:** флипчарт, маркер, асуулгын хуудас

**Аргачлал:** Асуулгын хуудас дээр ажилуулах, дасгал

**Хүйс болон жендэрийн ялгаа:**

**Дасгал 1:** Эмэгтэй болон эрэгтэй хүмүүсийн хоорондын ялгаа /Хавсралт 3 - Оролцогчдоос авах асуулга/

**Дасгал 2:** Жендэрийн үүргийг ойлгуулах дасгал

- Бүх оролцогчдыг нүдээ аньж, өөрт тухтай байдлаар суухыг хүснэ (Хоёр хөлийн улаа газарт тавьж суух нь тайвшруулах байрлал байдаг).
- Оролцогчдод "Хүүрнэл 1"-ийг тайван удаан уншиж өгнө.
- Оролцогчдоос юу мэдэрсэн, ямар санагдсан, юу бодогдсон талаар асууна.
- Оролцогчдод "Хүүрнэл 2"-ийг тайван удаан уншиж өгнө.
- Оролцогчдоос юу мэдэрсэн, ямар санагдсан, юу бодогдсон талаар асууна.

### Хүүрнэл 1

Та бол багаасаа л бие султай эрэгтэй хүүхэд, 9 нас хүртлээ эмнэлэгт хэвтэж эсвэл гэртээ хэвтэрийн дэглэм барьсан (дотроо 5 тоолоорой). Харин таны бие хамаагүй дээр болж 10 настайгаасаа үеийнхэнтэйгээ мөр зэрэгцэж сургуульд явах боллоо. Гэвч багаас бие султай байсан болохоор бусад хөвгүүд шиг хурдан хөдөлгөөнтэй, идэвхитэй, хүчтэй байж чаддаггүй байлаа (дотроо 5 тоолоорой). Ангийн хөвгүүд өдөр ирэх тусам “доожоогүй, сул дорой, охин шиг” гэх мэтээр доромжилдог, шоолдог, зарим нь бүүр цохиж авдаг болсон байлаа. Танд юу мэдрэгдэж байна вэ? Юу бодогдож байна? Цаашид сургуульдаа явах хүсэл байна уу? (дотроо 5 тоолоорой).

### Хүүрнэл 2

Нэг өдөр та хичээлдээ сууж байлаа. Гэтэл нэг хөвгүүн таны хажууд суугаад “эрэгтэй хүн заавал хүчтэй, хөдөлгөөнтэй, зоригтой байж эр хүн болдоггүй юм” хэмээн хэлээд тантай найзалж, байнга л хамт тоглодог боллоо (дотроо 5 тоолоорой). Танд одоо юу мэдрэгдэж байна вэ? Юу бодогдож байна вэ? (дотроо 5 тоолоорой).

### Сэдвийн дүгнэлт:

Тухайн хүүрнэлийг сонссоны дараа төрсөн сэтгэгдлээс хуваалцана. Түүний дараа хүйс болон жендэрийн ялгаатай байдлын талаарх ойлголтоо нэгтгэнэ.

- Жендэрийн ойлголтууд нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хүлээж байгаа өөр өөр үүрэг хариуцлага ба эрэгтэй эмэгтэй хүмүүс өөрсдийн амьдарч байгаа нийгэм, соёл иргэншил ба эдийн засгийн амьдралын хүрээнд хэрхэн харилцаж байгааг ойлгох нь чухал.
- Жендэрийн асуудлыг судлахын тулд хийх анхны алхам бол нийгэм эдийн засгийн өргөн утга агуулгын хүрээнд зөвхөн жендэртэй холбоотой асуудлууд юу байна, эсвэл зөвхөн хүйстэй холбоотой асуудлууд нь юу байгааг ялгаж салгаж ойлгох явдал чухал.



## сэдэв 3

### БЭЛГИЙН ОРОН ЗАЙ, БЭЛГИЙН ЭРХ

**Зорилго:** Бэлгийн орон зай (sexuality) нь бидний амьдралын үндсэн төлөв байдал буюу насан туршид хамаарах хүйс ба жендэрийн баримжаа илэрхийлэл болон үүрэг роль, бэлгийн чиг баримжаа, дур хөдлөл, таашаал, янаглал, нөхөн үржихүй зэргийг тодорхойлдог өргөн хүрээний асуудал гэдгийг ойлгуулах.

**Хугацаа: 42 мин**

№	Сэдвийн хуваарилалт	Хугацаа	Тайлбар
1	Дасгал	5 минут	
2	Танилцуулга	15 минут	
3	Бүлгийн ажил	12 минут	
4	Дүгнэлт	10 минут	

**Хэрэглэгдэх зүйлс:** Нөүтбүүк, проектор, флипчарт, маркер, өнгийн цаас, хайч, цавуу

**Арга зүй:** Тархины дайралт/brainstorming/, танилцуулга, бүлгээр ажиллах

#### **Дасгал 1**

Бэлгийн орон зай гэдэгт юуг ойлгож байна вэ? гэсэн асуултаар брэйносторминг хийж оролцогчдоос хэлсэн үгсийг самбар дээр бичнэ. (5мин)

#### **Танилцуулга**

Бэлгийн орон зай гэж юу болох, бэлгийн эрх гэж юу болох талаар хэлэх, ямар агуулгатай, яагаад бидний амьдралын салшгүй хэсэг болох талаар ойлголт өгч танилцуулна. (15мин)

#### **Бүлгийн ажил**

Бүлгийн ажил: оролцогчдыг 5,5-аар 4 багт хувааж бэлгийн эрх, бэлгийн орон зай сэдвээр баг бүр нэг нэг эерэг мессэж боловсруулах, постер хийх даалгавар өгнө. (10 мин)

*Бүлгийн ажил танилцуулах баг бүрт 3 минут.  
Чиглүүлэгч багш дүгнэлт хийнэ. (10 мин)*

**Гол мессэж:**

- Бэлгийн мөн чанар нь хүний амьдралын гол аспект бөгөөд хүйс, жендэрийн хамаарал ба үүрэг роль, бэлгийн чиг баримжаа, эротизм, дур ханамж, янаглал, нөхөн үржихүй зэргийг хамарна. Бэлгийн мөн чанар нь бодол, фантаз, хүсэл, итгэл, хандлага, үнэлэмж, зан үйл, практик үйлдэл, үүрэг роль, харилцаа зэргээр хэрэгжиж илэрхийлэгдэнэ. Бэлгийн мөн чанар ийм олон талтай хэдий ч, эдгээрийг бүгдийг нь дандаа илэрхийлж, хэрэглэдэггүй байна. Бэлгийн мөн чанар нь биологийн, физиологийн, нийгмийн, эдийн засгийн, улс төрийн, соёлын, ёс зүйн, эрх зүйн, түүхэн, шашны зэрэг хүчин зүйлс, тэдгээрийн харилцан үйлчлэлийн нөлөөнд байдаг. (ДЭМБ-ын 2002 оны ажлын тодорхойлолт)
- Хүний бэлгийн мөн чанар нь хувь хүмүүсийн бэлгийн асуудлаарх мэдлэг, итгэл, хандлага, үнэлэмж, зан үйл, зэргийг багтаана. Түүний олон талын тоонд хүний бэлгийн системийн анатоми, физиологи, биохими, хамаарал, чиг баримжаа, үүрэг роль, хувь зан чанар, бодол, сэтгэл, харилцаа зэрэг багтана. Хүний ёс зүйн, шашны, ёс суртахууны байдал нь түүний бэлгийн мөн чанарын илэрхийлэлд нөлөөлнө. (SIECUS-н тайлан, боть 24 #3, 1996)

СЭДЭВ  
**4**

БЭЛГИЙН ЗАН ҮЙЛ

**Зорилго:** Оролцогчдод бэлгийн зан үйлийн талаар ойлголт олгох, бэлгийн сайн болон буруу зан үйл гэж ангилал бий эсэх

**Хугацаа : 60 минут**

№	Сэдвийн хуваарилалт	Хугацаа	Тайлбар
1	Бүлгийн ажил	20 минут	
2	Бүлгийн ажлын танилцуулга	20 минут	
3	Дүгнэлт танилцуулга	10 минут	
4	Багшийн нэгдсэн дүгнэлт	10 минут	

**Хэрэглэгдэх зүйлс:**

Флипчарт цаас, өнгийн маркер 8ш, скоч, өнгийн стикер цаас-20 ш

**Арга зүй:** Дасгал, тоглоомын арга  
Оролцогчдыг тав, таваар 4 баг болгон хуваана. Баг болгон хуваахдаа тоглоом тоглуулна.

### Бүлгийн ажил:

Хүмүүс яагаад, ямар зорилготой бэлгийн харьцаанд ордог вэ? Бүх оролцогчдоос асууна. Чиглүүлэгч багш оролцогчдын хэлсэн хариултыг самбар дээр бичнэ. -5 мин

1. Баг бүрт флипчарт цаас тараан өгч, багаараа ярилцан бэлгийн зан үйлтэй холбоотой зүйлсийг бичүүлнэ. Үүнд бэлгийн харьцааны байрлал, -15мин
2. Багууд өөрсдийн бүлгийн ажлаас голгэсэн 5 зан үйлийг (давхардуулахгүйгээр) танилцуулна. Чиглүүлэгч тайлбарлахад тусалж болно. 20мин
3. Үүний дараа оролцогчид тус бүр өнгийн стикер цаасан дээр бэлгийн зан үйлийн талаарх /бүлгүүдийн ажилтай холбоотой/ өөрийн **САЙН** болон **МУУ** гэж бодож буй гурав, гурван зан үйлийг тодорхойлж бичнэ.
4. Оролцогчдын бичсэн цаасыг хураан авч зан үйл тус бүр дээр сайн мууг гаргаж ирнэ. 10мин

Чиглүүлэгч багш дүгнэлт хийнэ.-10 мин

### Гол мессэж:

- Хүн бүрийн харах өнцөг өөр. Чамд муу гэж санагдсан зүйл өөр хүнд сайн зүйл гэж боддог. Хичээлийн эхлэл хүмүүс яагаад, ямар зорилготой бэлгийн харьцаанд ордгийг санацгаая.
- Сайн, муу гэж ангилахдаа дараах зүйлсийг ангилах хэрэгтэй. Энэ 3 зүйлийг зөрчөөгүй бол МУУ зүйл гэж ялгаварлан гадуурхах доромжлох хэрэггүй.
- Насанд хүрсэн, өөрийн өмнө хариуцлага, үүргээ хүлээх чадвартай ухамсарласан.
- Мансууруулах бодис, архи согтууруулах ундаа хэрэглээгүй.
- Аюулгүй байдал. /Хүсээгүй жирэмслэлт, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүчирхийллэс ангид/

сэдэв  
**5**

**БЭЛГИЙН ЧИГ БАРИМЖАА, ХҮЙСИЙН БАРИМЖАА  
ИЛЭРХИЙЛЭЛ**

**Зорилго:** Хүн бүрийн ялгаатай байдал болоод бэлгийн орон зай, түүний олон янзын байдлыг ойлгуулж, ЛГБТ хүний эрхийн талаарх ойлголтоо гүнзгийрүүлэх

**Хугацаа: 55 минут**

№	Сэдвийн хуваарилалт	Хугацаа	Тайлбар
1	Мэдлэгийг сорих асуулт, хариулт	5 минут	
2	Дүрийн тоглолт	20 минут	
3	Дүрийн тоглолтын талаарх саналаа хуваалцах	20 минут	
4	Кино	10 минут	

**Хэрэглэгдэх зүйлс:**Тараах материал

**Арга зүй:** Оролцогчдын мэдлэгийг сорих асуулт, хариулт, кейсүүд дээр ажиллах дасгалууд, кино үзүүлэх

**Дасгал 1:**

Бэлгийн чиг баримжаа,хүйсийн илэрхийлэл гэж юу вэ?Асуулт хариулт:5 минут үргэлжилнэ.

**Дасгал 2:**

Оролцогчид өөрийн сэтгэгдлээ хэлсний дараа бодит кейс дээр тулгуурлан бэлтгэсэн дүрд тоглуулна. /Бэлтгэх хугацаа 10 минут/

**Жүжиглэх хугацаа баг тус бүр 10 минутаас хэтрэхгүй байх**

**Мэдрэмжийг нь хуваалцана: нийт 20 минут**

**Кейс 1**

Дорж одоо 13 настай 8-р ангид суралцдаг. Хичээл номондоо сайн бөгөөд маш даруухан нэгэн хөвгүүн. Доржийг ангийхан болон тэр хавийн найзууд үе тэнгийхэн “Гомо” гэж доог тохуу хийдэг, энэ нь түүнд маш их дарамттай байдаг бөгөөд хаанаас хэн гарч ирээд элдвээр хэлээд зодох бол гэсэн байнгын айдастай явдаг, үеийн эрэгтэй найзууд нь охин шиг гэж хэлж зоддог. Дорж энэ

байдлаасаа үнэхээр залхаж, гей болж төрснийхөө төлөө өөрийгөө үзэн яддаг болж сүүлдээ хичээлээ тасалдаг болж, сургуулиасаа гарсан. Дорж энэ байдлаас болж гэрээсээ гарахаа больж, зөвхөн өөртэйгөө ярьдаг болж, зожиг, аливаа зүйлээс амархан айдаг, ичдэг хүүхэд болсон. /Дүрд тоглох явцад хугацаанаасаа хэт их хэтрүүлэхгүйгээр баяжуулж тоглож болно/

### Кейс 2

Цог 19 настай их сургуульд сурдаг. Сурлага сайтай бөгөөд улсын томоохон сургуульд сурдаг. Цог бага байхаасаа л бусдаас өөр гэдгээ мэдэрч ихээхэн шаналж, нууж явдаг байсан. Учир нь Трансжендэр /өөрийгөө биологийн төрөлх хүйснээсээ эсрэгээр мэдэрдэг, төсөөлдөг/ юм.

Тэр өрөөндөө орой болгон эмэгтэй хувцсаа гарган өмсөж, нүүр, уруулаа буддаг. Цог энэ үед өөрийнхөөрөө аз жаргалтай төгс эмэгтэй болсон мэт хөөрөн догдолдог. Өглөө болоод сургуулийн зүг алхахдаа тэр дургуй хүргэсэн эрэгтэй хувцсаа өмсөж өөрт тавгүй мэдрэмжээ нуун, дотроо харин өөрийгөө эмэгтэй хүн хэмээн төсөөлөн алхдаг. Нэгэн удаа орой Цог эмэгтэй хувцастайгаа хотын гудамжаар алхан явж байгаад ангийхаа хэдэн залуустай тааралджээ. Харамсалтай нь тэдгээр залуус согтуу байсан бөгөөд Цог руу дайран элдвээр доромжлон танхааран зодож амь насанд нь хүржээ. Гэхдээ гэрийхэн энэ хэргийг нуун дарагдуулсан бөгөөд хуулийн хариуцлагыг залуус хүлээгээгүй юм.

### Кейс 3

Ундрал 25 настай эмэгтэй дээд боловсролтой боломжийн ажил эрхэлдэг, Ундрал хэзээ ч хөвгүүдтэй үерхэж үзээгүй бөгөөд харин ч сайн найз байж чаддаг нэгэн, гэрийхэн нь Ундралыг байнга хүнтэй суу ачаа үзмээр байна яагаад эрэгтэй хүнтэй үерхэхгүй байна гээд шахаж, сэтгэлээр унадаг, энэ их асуудлаас болоод Ундрал тусдаа амьдрахаар болсон. Ундрал өөрийн хайртай найз охинтойгоо хамт санаа зовох зүйлгүй амьдарч эхэлсэн. Нэгэн амралтын өдөр Ундрал найз охинтойгоо хэвтэж байхад нь ах нь орж ирж дүүгээ лесбиян гэдгийг мэдэн ихээхэн уурлан зодож биед нь хүнд гэмтэл учруулсан. Ундрал тэр өдрөөс эхлэн тэргэнцэр дээр суун гэртээ ганцаараа цонх ширтэн нүдэндээ нулимстай, зүрхэндээ шархтай үлдсэн. Харин гэрийхэн нь лесбиян байхаас нь болиулж чадлаа гэсэн ойлголттой үлдсэн.

### Дасгал 3. Кино үзүүлэх

Богино хэмжээний кино үзүүлнэ. 10 минут

/you tube.com [https://www.youtube.com/watch?v=\\_zBjKxycXW](https://www.youtube.com/watch?v=_zBjKxycXW)

### Гол мессэж:

- Бэлгийн баримжаа илэрхийлэл гэдэг нь бэлгийн дур сонирхолын хувьд хэнд татагдаж байна вэ? гэдэг мэдрэмж дээр үндэслэн хүн өөрийгөө хэн болохыг тодорхойлоход оршино. Эсрэг хүйсийн, ижил хүйсийн, эсвэл аль аль хүйсийн хүнд татагддаг байж болно.
- Хүйсийн баримжаа илэрхийлэл гэдэг нь хүн өөрийгөө эрэгтэй, эмэгтэй, аль аль нь, эсвэл бүр өөр хүйсийн хүн гэж тодорхойлоход оршино. Бэлгийн баримжаа илэрхийлэлийн адил нийгэм биологийн шинж тэмдгийг чухалчилж хүйсийн баримжаа илэрхийлэлийг тогтоож ирсэн.
- Баримжаа илэрхийлэл гэдэг нь байнга, ямар нэгэн өөрчлөлтгүй тогтмол байдаг зүйл биш нэг хүн өөрийгөө хэдэн өөр янзаар тодорхойлж болно. Хүний бэлгийн болон хүйсийн баримжаа илэрхийлэл нь амьдралынх нь туршид өөрчлөгдөж ч болно.
- Баримжаа илэрхийлэл нь өөр хүмүүс гутаан доромжлох, ялгавралан гадуурхах явдалтай тулгарах нь олонтаа. “Зөв” гэж тогтоосон хэм хэмжээнээс өөр байх тусам тулгарах ялгавралан гадуурхалт илүү хүчтэй байдаг.
- Нийгэмд тогтсон хэвшмэл ойлголт нь зарим бэлгийн болон хүйсийн баримжаа илэрхийлэлийг гутаан доромжлох, ялгавралан гадуурхах явдлыг нэмэгдүүлдэг.

Бүлэг тань ерөнхий сэдвийнхээ хүрээнд ач холбогдол бүхий ярилцлага өрнүүлж л байгаа бол тэднийг анх тавьсан асуултаас хазаахад нь та саад болох хэрэггүй. Та өөрийн туршлагын хүрээнд мэддэг, чаддаг аргаар асуултуудаа асууж дасгалуудаа зохион байгуулах боломжтой. Хэрэв зарим оролцогч бүрэг ичимхий буюу үг хэлэх зориг муутай байгаа нь анзаарагдвал та өөрөө санал бодлоо хэлээд, тэдний нэгийг энэ тал дээр ямар бодолтой байгааг нь асууж болно. Нийт бүлэг болон оролцогч бүрийн хэрэгцээнд мэдрэмжтэй хандаж, шаардлагатай үед ярилцлагын чиглэлийг эвтэйхэн өөрчилж, хүн бүртэй эелдэг харьцаж, харилцан суралцах үйл явцад бусдын адил оролцож байх л юм бол та сургалтыг үр дүнтэйгээр чиглүүлж байна гэсэн үг.

Хавсралт 1

**“Бэлгийн болон нөхөн үржихүйн эрх ба хүний эрх” сургалтын  
өмнөх, дараахь тест**

Дараах хичээлүүдээс ойлгосон, бүрэн ойлгож чадаагүй,  
хангалттай бус гэсэн сонголтуудаас сонгоно уу? /чагтлана/

Хүний эрхийн үндсэн ойлголт /Жендэр/

**Сайн дунд муу**

Бэлгийн орон зай

**Сайн дунд муу**

Сэргээх дасгал

**Сайн дунд муу**

Бэлгийн зан үйл

**Сайн дунд муу**

Бэлгийн эрх

**Сайн дунд муу**

Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл

**Сайн дунд муу**

Өөр санал хүсэлтээ бичнэ үү?

.....  
.....

Таны хувьд чухал гэсэн ямар сэдэв байсан бэ?

.....  
.....

Чухал биш гэсэн сэдэв юу байсан бэ?

.....  
.....

Илүү дэлэрэнгүй сурах шаардлагатай гэж үзэж байгаа хичээлийн сэдэв

.....  
.....

Чиглүүлэгч, сургагч нарын ур чадвар таны сэтгэлд хүрч байна уу? Яагаад?

.....  
.....

Сургалтандаа идэвхитэй оролцсонд баярлалаа.

## Хавсралт 2

### Сургалтын жишиг хөтөлбөр /1 өдрийн/

Цаг	Сэдэв
09:00-09:10	Оролцогчдыг бүртгэх
09:10-09:15	Сургалтын нээлт
09:15-09:40	Танилцах (Галлерей аргаар танилцах)
09:40-10:00	Дүрмээ батлах, хүлээлтээ тодруулах <ul style="list-style-type: none"><li>Оролцогч нар</li></ul>
10:00-10:30	Хүний эрхийн үндсэн ойлголт <ul style="list-style-type: none"><li>Сургагч багш</li></ul>
10:30-11:05	Жендэрийн тухай ойлголт <ul style="list-style-type: none"><li>Сургагч багш</li></ul>
11:05-11:20	Цайны завсарлага
11:20-12:00	Бэлгийн орон зай, бэлгийн эрх <ul style="list-style-type: none"><li>Сургагч багш</li></ul>
12:00-12:50	Үдийн хоол
12:50-13:00	Сэргээх дасгал
13:00-14:00	Бэлгийн зан үйл <ul style="list-style-type: none"><li>Сургагч багш</li></ul>
14:00-14:10	Сэргээх дасгал /бүжиг/
14:10-15:10	Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл <ul style="list-style-type: none"><li>Сургагч багш</li></ul>
15:10-15:25	Цайны завсарлага
15:25-16:25	Дүгнэлт ярилцлага
16:25-16:30	Сургалтын хаалт



**Эрэгтэй эмэгтэй хүмүүс юугаараа ялгаатай вэ? асуулгын хуудас**

1. Эмэгтэй хүмүүс арай хүч султай.  
а. Зөв б. Буруу
2. Хөвгүүд охидуудаас илүү нийгмийн идэвхитэй, түрэмгий байдаг.  
а. Зөв б. Буруу
3. Эмэгтэйчүүд эрчүүдээс илүү сэтгэл хөдлөл ихтэй байдаг.  
а. Зөв б. Буруу
4. Өсвөр насандаа хөвгүүдийн хоолой өмнөхөөсөө бүдүүн болдог.  
а. Зөв б. Буруу
5. Эмэгтэйчүүд эрчүүдээс илүү их ярьдаг.  
а. Зөв б. Буруу
6. Эмэгтэйчүүд илүү хурдан хямардаг.  
а. Зөв б. Буруу
7. Эмэгтэйчүүд нууцыг задруулахдаа эрчүүдээс хурдан.  
а. Зөв б. Буруу
8. Эрчүүд эмэгтэйчүүдээс илүү их инээдэг.  
а. Зөв б. Буруу
9. Эцэг эхэд хүүхэд нь эрэгтэй эсвэл эмэгтэй төрөх ялгаагүй.  
а. Зөв б. Буруу
10. Ихэнх эмэгтэйчүүд санхүүгийн хэрэгцээгээ өөрөө хангаж чадна гэдэгтээ итгэлтэй байдаг.  
а. Зөв б. Буруу
11. Зүрхний шигдээс нь эрчүүдэд илүү тохиолддог.  
а. Зөв б. Буруу
12. Эрэгтэй эмэгтэй хүмүүс нөхөн үржихүйн эрхтэний хувьд ялгаатай.  
а. Зөв б. Буруу

**Ашигласан материал**

**“БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД, ЭРХ”**  
сургалтын материал-Tarshi, МОНЭС Сургагч бэлтгэх сургалтын гарын авлага.

АГУУЛГА  
ГУРАВДУГААР ХЭСЭГ

**“БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД, ЭРХ”-ИЙН  
ЗОРИЛТОТ БҮЛЭГТ ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН МОДУЛЬ**

Оршил

Сэдэв 1: Хүний эрх ба бэлгийн эрх.....	69
Сэдэв 2: Жендэрийг ойлгох нь.....	70
Сэдэв 3: Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрх.....	72
Сэдэв 4: Бэлгийн мөн чанарыг ойлгох нь.....	75
Сэдэв 5: Бэлгийн зан үйл, түүний олон төрөл янз.....	78
Сэдэв 6: Бэлгийн баримжаа, хүйсийн илэрхийлэл.....	79

## Оршил

Оюутан залуучууд, лесбиян, гей, трансжендэр охид эмэгтэйчүүдийн дунд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх, хүний эрхийн талаар мэдлэг, мэдээлэл дутмаг байгаагаас хүсээгүй жирэмслэлт, хүчирхийлэл, аливаа халдварт өвчинд өртөх, өөрийгөө болон хамтрагчаа эрсдлээс хамгаалах, эрхээ эдлэж чадахгүй байх, хохирсон эрхээ сэргээлгэж чадахгүй байх явдал гарсаар байна. Дээрх бүлгийн дунд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх, хүний эрхийн талаар мэдээлэл олж авах хэрэгцээ шаардлага байна хэмээн үзэж зорилтот бүлгийг сонгосон юм. Энэ сургалтын модулийг 16-25 насны зорилтот бүлгийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх, хүний эрхийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд зориулан боловсрууллаа.

Сургалтыг оролцооны аргад тулгуурлан, туршлагад суурилсан дасгал ажиллуулж, хэлэлцүүлэг өрнүүлэн дүгнэлт хийлгэх аргачлалаар явуулах нь сургалтад оролцогчидтой хоёр талын идэвхтэй харилцаа бий болгоход чухал ач холбогдолтой учир сургалтыг бүлгээр ажиллан “надад хэлбэл би мартана, надад үзүүлбэл би санана, намайг оролцуулбал харин би ойлгоно” гэсэн зарчмаар явуулахад анхаарч модулиа боловсрууллаа.

### Сургагч багш нарын гүйцэтгэх үүрэг

- Сургагч багш мэдлэг ур чадварыг оролцогчдод дамжуулж, асуултанд хариулдаг (эсвэл хариултыг нь дараа заавал олоод хэлнэ гэдэг) ба буруу ойлголтыг засаж тодруулах
- Сургагч багш нь үнэт зарчим, өндөр ёс суртахууныг оролцогчдод бий болгохыг хичээнэ. Тухайлбал, өсвөр үеийнхэн болон насанд хүрэгчид үе тэнгийнхээ эрэгтэй, эмэгтэй хүмүүстэй бүгдтэй адил тэгш харьцаж, жендэрийн тэгш эрхийг дэмжих үүрэг хариуцлагыг үүрэх хэрэгтэй гэх мэт.
- Сургагч багш оролцогчдыг хичээлд бүрэн дүүрэн оролцох замаар сургалтаар өгч буй мэдлэг ур чадварыг олж авах явдлыг дэмжсэн байдлаар хичээлээ удирдана.

### Сургалттай холбоотой санал сэтгэгдлийг цуглуулах

Оролцогчдын сургалттай холбоотой санал сэтгэгдлийг цуглуулах нь (зөвхөн сургалтын агуулга биш, зохион байгуулалтын асуудлууд багтана) сургагч багшид шаардлагатай өөрчлөлт хийхэд тус болдог гэдгийг оролцогчдод тайлбарлана. Чиглүүлэгч нараас хоёр хүний үнэлгээний багийг сайн дурын үндсэн дээр бүрдүүлнэ. Тэдний хийх ажил нь оролцогчдын санал сэтгэгдлийг нь цуглуулж сургалтын дараа мэдээлэх явдал юм. Санал сэтгэгдлээ хэлнэ гэдэг нь сургалтын өмнөх асуулгын нэгэн адил хяналт үнэлгээний чухал арга юм.

## **Сургалтын үеэр баримтлах дүрэм тогтоох**

Сургалтын явцад сурах үйл явц, харилцааг үр дүнтэй болгоход туслах сургалтын явцад баримтлах дүрмээ боловсруулна. Оролцогчид чиглүүлэгчид хамтран сургалтын туршид баримтлах дүрмээ тогтооно. Үүний дараа аливаа үйл ажиллагааны үеэр дүрэм тогтоож баримтлахын ач холбогдлын талаар ярилцана.

Сургалтын эхэнд бүлгээрээ баримтлах дүрэм, үйл ажиллагааны удирдамж боловсруулан зөвшилцөж, дүрэм журам яагаад чухал болохыг ойлгуулна. Эмзэг сэдэв хөндсөн сургалтын дүрэмд орох нэг нэн чухал заалт бол бүх оролцогчдын мэдээллийн нууцыг хадгалах явдал юм. Хэн ч бусад оролцогчдынхоо хувийн мэдээллийг гадагш тараах ёсгүй гэдгийг маш сайн ойлгуулах хэрэгтэй. Зарим бүлэг хэн нэгэн гомдсон уурласан байвал түүнийгээ хэлэх ёстой гэсэн заалт дүрэмдээ тусгадаг бөгөөд ингэснээр түүнийг уурлуулсан гомдоосон хүнд уучлал гуйх боломж олгодог. Жендэр, яс үндэс, хувийн зан чанартай холбоотой тоглоом шоглоом, хэлсэн үгнээс болж гомдсон, доромжлуулсан мэт сэтгэгдэл төрсөн хүмүүсийн хувьд энэ нь ихээхэн ач холбогдолтой юм.

Оролцогчид бүгд тодорхой заалт бүхий дүрэм дээр тогтсоны дараа, тэрхүү жагсаалтыг сургалтын танхимд сургалт дуустал ил байрлуулна. Зарим үед оролцогчдыг хамтран баталсан дүрмээ санахыг хүсэх шаардлага гарч болно.

## **Нийтлэг үндсэн дүрэм**

- Санал нийлэхгүй байсан ч бусаддаа хүндэтгэлтэй хандах
- Идэвхитэй оролцох
- Өөрт эвгүй санагдсан үйл ажиллагаанд оролцохгүй байх эрхтэй
- Бусдынхаа яриаг таслахгүй сонсох
- Мэдээллийн нууцыг хадгалах
- Цагаа барих
- Гар утсаа унтраах

## **Сургалтын өмнөх асуулга**

Сургалтаар хамрах сэдвүүдийн талаарх оролцогчдын мэдлэг, хандлага, чадварын суурь түвшинг тогтоох үүднээс сургалтын өмнөх асуулгыг бөглүүлдэг. Чиглүүлэгч оролцогчдыг асуултуудад өөрсдийн үзэл бодлын үүднээс хариулахыг зөвлөж дэмжих хэрэгтэй.

Энэхүү сургалтын өмнөх асуулга нь залуучуудын зорилтот бүлэгт гарсан интервенцийн үр нөлөөг үнэлэхэд хэрэглэдэг арга хэрэгсэлтэй адилаар юм.

Хяналт үнэлгээ нь чанарын хяналтанд маш чухал.

## СЭДЭВ 1

### ХҮНИЙ ЭРХ БА БЭЛГИЙН ЭРХ

**Зорилго:** Хүний эрхийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх

**Хугацаа:** 60 минут

№	Сэдвийн хуваарилалт	Хугацаа	Тайлбар
1	Хүний эрх гэж юу вэ? Кино, ярилцлага	20 минут	
2	Хүний эрх ба бэлгийн эрх танилцуулга	15 минут	
3	Кейс дээр ажиллах	15 минут	
4	Дүгнэлт	10 минут	Хавсралт 2

**Арга зүй:** Танилцуулга, кино, кейс дээр ажиллах

Тус сэдвийн ерөнхий танилцуулга (Тус сэдвийн хүрээнд дурдагдах, цаашид юу ярих талаар товч танилцуулна)

**Хүний эрхийн тухай кино үзүүлэх/Хүний эрх гэж юу вэ?**

<https://www.youtube.com/watch?v=wP1v5ab2toU/>

#### ТАНИЛЦУУЛГА

##### Хүний эрх ба бэлгийн эрх

- НҮБ-ын түгээмэл тунхаглалд зааснаар хүний үндсэн 30 эрх байдаг бөгөөд эдний нэг нь БЭЛГИЙН ЭРХ юм. Та бэлгийн эрхийн тухай юу мэдэх вэ? Бэлгийн эрх гэж юу вэ?
- Хүний үндсэн эрхүүд нь бүгд хоорондоо холбоо хамааралтай байдаг ба энэ эрх илүү энэ эрх сүүлд байх ёстой гэх мэтээр эрэмбэлэх ёсгүй. Бэлгийн эрх бол таны Амьд явах эрх, Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, Боловсрол авах эрх гэх мэт эрхүүдтэй ижил маш чухал эрх юм. Хүн бүр төрөхөөсөө нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байдаг. Бэлгийн эрхэд дараах эрхүүд хамаарагдана:
  - Бэлгийн эрх чөлөөт бусдаас хараат бус байдал
  - Бэлгийн эрх тэгш байдал

- Бэлгийн эрүүл мэндээ хамгаалуулах эрх
- Бэлгийн нууцлал
- Нөхөн үржихүйн сонголтоо хүссэн үедээ чөлөөтэй хийх
- Бэлгийн боловсрол авах
- Бэлгийн сонголтоо өөрөө хийх эрх гэх мэт
- Хүний эрхэд тулгуурласан хандлага хамгаас чухал байр суурьтай байдаг. Бид бүхэн ямар ч тохиолдол ямар ч нөхцөлд хэн нэгнийг буруутгаж, шүүмжлэх ёсгүй юм. Бид бүхэн дээрх эрхүүдийг эдэлдэг шиг бусад бүх хүмүүс бэлгийн эрхээ эдлэх ёстой юм.

## СЭДЭВ 2

### ЖЕНДЭРИЙГ ОЙЛГОХ НЬ

**Зорилго:** Жендэр болон хүйсийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх

**Хугацаа:** 50 минут

№	Сэдвийн хуваарилалт	Хугацаа	Тайлбар
1	Дасгал	10 минут	
2	Хэлэлцүүлэг	20 минут	
3	Жендэр ба хүйсийн ялгаатай байдал хэлэлцүүлэг	10 минут	
4	Дүгнэлт ярилцлага	10 минут	

**Арга зүй:** Дасгал, хэлэлцүүлэг

**Дасгал** 10 минут

Оролцогчдыг нэг эгнээнд зогсооно. Доор өгөгдсөн 7 хэвшмэл ойлголтуудыг уншина. Тухайн хэвшмэл ойлголт нь биологийн үзэгдэл гэж бодсон хүүхдүүд

арагшаа алхана. Нийгмийн үзэгдэл гэж бодсон хүүхдүүд урагшаа алхана. Оролцогчид бие биенээ дагаж шийдвэр гаргахаас сэргийлж нүдийг нь боолгоно.

### Хэвшмэл ойлголтууд

1. Эмэгтэй хүн эрэгтэй хүнээс илүү зөөлөн сэтгэлтэй
2. Хүүхдийг эх хүн хөхөөр хооллодог.
3. Эмэгтэй хүн жирэмсэн болдог, харин эрэгтэй хүн жирэмсэн болдоггүй
4. Эрэгтэй хүн эмэгтэй хүнээс илүү сексийн дур хүсэлтэй байдаг.
5. Жинхэнэ эр хүн уйлдаггүй
6. Эхийн зөн совин гэж байдаг
7. Өсвөр насны эрэгтэй хүүхдийн хоолой бүдүүрдэг

### Хэлэлцүүлэг-20 минут

Дээрх хэвшмэл ойлголтуудаас аль нь нийгэм аль нь биологитой холбоотой ойлголт болох асуудлаар ярилцана. Хэвшмэл ойлголтууд хаанаас төрдөг, бодит байдал ямар байгаа талаарх мэдээлэл өгнө. /Доогуур зурсан 3 нь л биологитой холбоотой бусад нь нийгмийн нөлөөгөөр үүсдэг байна./

### Хэлэлцүүлэг 10 минут

Жендэр болон хүйсийн ялгааны асуудлаар ярилцах, оролцогсдын санал бодлыг сонсох.

### Дүгнэлт ярилцлага:

#### **Гол мессэж:**

- Жендэр: Эрэгтэй, эмэгтэй хүмүүс, тэдний бие биенээсээ ялгаатай байдлыг, тэдэнд оногддог үүрэг ролийн талаар нийгмээс үзэх үзэл баримтлал. Ерөнхийдөө хүмүүс өөрсдийгөө холбогдох жендэртээ хамааруулж, тэр жендэртээ тохирсон байдлаар биеэ авч явдаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүст зохистой зан үйл гэж соёлоор тодорхойлогдсоны дагуу жендэрийн үүрэг ролийг хуваарилдаг ч жендэрийн тодорхойлолт нь тухайн хүн өөрийгөө эрэгтэй, эмэгтэй жендэрийн аль нэгэнд хамаарагдана эсхүл алинд нь ч хамаарахгүй гэж үзэж байгаа мэдрэмж юм.
- Хүйс: Төрөлхөөс заяасан эм, эрийн биологийн ялгаа. Үүнд үтрээ, пенис зэрэг анатомын ялгаа, тухайн хүний хромосомд илэрдэг генийн ялгаа, сарын тэмдэг, сперм боловсруулалт зэрэг физиологийн ялгаа орно.

сэдэв  
3

БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЭРХ

**Зорилго:** Хүний бэлгийн эрх гэж юу болох, хэрхэн зөрчигддөг талаарх ойлголтыг сургалтанд оролцогчид өөрсдөө гаргаж ирнэ.

**Хугацаа: 60 минут**

№	Сэдвийн хуваарилалт	Хугацаа	Тайлбар
1	Кейс дээр ажиллах	25 минут	
2	Танилцуулга	15 минут	
3	Дүгнэлт ярилцлага	20 минут	

**Арга зүй:** Кейс дээр ажиллах, хэлэлцүүлэг, тараах материал

**Кейс**

УБ хотод Учрал гэдэг бүсгүй амьдардаг байжээ. Тэрээр Тулга гэдэг залуутай хайр сэтгэлийн холбоотой болж нэлээд хугацаа өнгөрсний дараагаар түүнтэйгээ хамтран амьдрах болов. Бие биедээ маш их хайртай хосууд үнэхээр аз жаргалтай амьдарч байлаа. Гэсэн хэдий ч тэдний амьдрал тийм ч хангалуун бус байсан тул Тулга амьдралаа дээшлүүлэхээр Судан улс руу энхийг сахиулах ажилд явахаар шийдэв. Учрал иргэний дайн ихтэй байгаа учир хайртдаа санаа зовж Судан руу явуулах дургүй байгаагаа илэрхийлсэн боловч амьдралд нь дэм болохуйц ихээхэн хэмжээний мөнгөн тэтгэмж авна гэж Тулга ятгасаар зөвшөөрүүлэв. Ингээд Тулга явж хайрт амраг руугаа байнга ярьдаг, хаяа хэдэн төгрөг явуулж 1 жилийг ардаа үдэв.

Байнга ярьдаг нөхөр нь хэл чимээгүй 3 сар болов. Учрал санаа нь зовж хамт явсан даргаас нь асуухад:

Дайн гарсан, хөл үймээн ихтэй байгаа хот руу томлилтоор явсан. Ирэх ёстой хугацаа нь болсон боловч сураггүй л байна. Бид ч бас санаа зовж хайлгаж байгаа. Тулгын сураг гарвал шууд мэдэгдэхээ амлаад утсаа таслав.

Ингээд ахиад 3 сарын дараа Тулга дайны үеэр албан үүргээ гүйцэтгэж яваад амь эрсэдсэн тухай Учралд мэдэгдэл ирэв.

Чин үнэнчээр хайрт амрагаа хүлээсэн бүсгүйн сэтгэл маш их шаналж Учрал хэдэн сарыг амьд үхсэн нь мэдэгдэхгүй өнгөрөөжээ. Түүнийг хараад санаа нь зовсон гэрийнхэн нь Болд гэх их сайн залуутай суухыг шаардаж эхэлжээ. Болд Учралд үнэхээр хайртай төдийгүй бэл бэнчин сайтай залуу юм санж. Учрал дургүй байсан ч



гэрийнхнийхээ ятгалгаар аргагүй эрхэнд Болдтой сууж төд удалгүй хөл хүнд болов.


Ийнхүү 5 сарын дараа Тулга гэнэт л хүрээд ирэв. Хөл үймээн ихтэй хотод дайн босгогчдод олзлогдож 1 жил гаран хоригдож байгаад азаар мултарч гэртээ эргэж ирсэн нь энэ юм.

Тулга Учралд бүхнийг ойлгуулж өөр дээр нь эргэн ирэхийг хүсэв. Учрал харин яахаа мэдэхээ больсон тул гэрийнхэн нь шийдвэрийг гаргахаар болов.

Та тэдний оронд байсан бол ямар шийдвэр гаргах байсан бэ?

- А. Тулгатай буцаж нийлнэ.
- Б. Болдтой үлднэ.
- В. Бусад /...../

### Танилцуулга. Хүний эрх ба бэлгийн эрх



### Бэлгийн эрх

- + Бие махбодийн хувьд халдашгүй дархан байх
- + Зөвшөөрөх, эс зөвшөөрөхөө зөвхөн өөрөө шийдэх
- + Таашаал, сэтгэл ханамж бүхий аюулгүй бэлгийн амьдралаар амьдрах
- + Бэлгийн амьдралын нууцлалаа хадгалах
- + Шинжлэх ухааны үндэстэй, баталгаатай мэдээллээр хангагдах
- + Бэлгийн боловсролыг хүртэх
- + Бэлгийн эрүүл мэндийн үйчилгээ хүртэх
  - Бэлгийн амьдралдаа сэтгэл дундуур байх
  - Хамтрагчтайгаа тэгш бус харилцаатай байх
  - Үл ойлголцох
  - Наснаас үл хамааран бие махбодийн халдлагад өртсөн /Биед зөвшөөрөлгүй гар хүрэх, бэлгийн холбогдолтой доромжлол, хошигнол г.м/

- Бэлгийн халдлага, хүчирхийлэлд өртөх /Хүсээгүй байхад бэлгийн үйлдэл хийх зорилгоор халдах, завдах/
- Бэлгийн амьдралын талаарх мэдээллийг баталгаагүй эх сурвалжаас авах, эсвэл огт авахгүй байх

### Нөхөн үржихүйн эрх

- Хүүхэдтэй болох эсэх, хэзээ, хэдэн хүүхэд төрүүлэхээ өөрөө мэдэн шийдэх
- Нөхөн үржихүйн шинжлэх ухааны үндэстэй, баталгаатай мэдээллээр хангагдах
- Нөхөн үржихүйн эрүүл мэндийнүйлчилгээ хүртэх
  - Хувийн амьдрал, шийдвэрт дур мэдэн оролцох, шүүх, буруутгах /жишээ нь: хүүхэд гаргахыг шахах, хувийн амьдралыг нь асуун шалгаан, шүүн хэлэлцэх, зөв буруугийн үнэлэмж тавих/
  - Эрүүл мэндийн үйлчилгээнд сэтгэл дундуур байх, хангалтгүй гэж үнэлэх, итгэхгүй байх, айх
  - Жирэмсний үед: Эмчийн хяналт, хүртээмж, багтаамжийн хувьд хангалтгүй
  - Төрөх үе: Дэд бүтэц, эмнэлэгийн байр, төрөх газар хүрэлцээгүй, улсын төрөх эмнэлэг нь шатлалтай, үйлчилгээний ялгаатай, авилгалын асуудалтай, ялгаварлан гадуурхалт их, эмч ажилчид нь хүний эрхийн ойлголтгүй

**Жишээ нь:** Өөрийн хүссэн үед жирэмснээс хамгаалах хэрэгслийг чөлөөтэй хэрэглэж, дур хүсэл таашаалаа чөлөөтэй илэрхийлж чадахгүй байх. г.м

### Дүгнэлт

#### **Гол мессэж:**

- Хүний эрх гэдэг бол хүнээс салгаж үл болох хамгийн чухал зүйл юм. Бусдын эрхийг ямагт хүндэтгэж байх нь чухал .
- Хүний эрхэд суурилсан хандлага яагаад байх ёстойг ойлгох, хүний эрхэд суурилсан хандлагын зарчмуудыг ойлгоход чухал ач холбогдолтой
- Сонголт, Нэр төр, Олон талт байдал, Тэгш байдал, Хүндэтгэл зэрэг үнэт зүйлс нь хүний эрхийн ойлголтын тухай мэдлэгийн суурь үндэс юм. Эдгээр үнэт зүйлс нь хүн бүрийн үнэ цэнийг баталгаажуулдаг. Эдгээрийг бэлгийн мөн чанар, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх гэсэн ойлголтуудтай зайлшгүй холбон авч үзэх шаардлагатай. Дээрх үнэт зүйлсийг оруулаагүй тохиолдолд үйлчлүүлэгчдийнхээ ашиг сонирхолыг хамгаалж, түүнд нийцсэн үйлчилгээ болон нөлөөллийн ажлыг үр ашигтай явуулах боломжгүй болно. Тухайлбал, бэлгийн мөн чанараа сонгох сонголтыг баталгаажуулна гэдэг нь “идэвхтэй бэлгийн амьдралтай гэр бүлгүй хүн бэлгэвч, жирэмснээс хамгаалах арга хэрэгсэл /ЖСАХ/ хэрэглэх эрхтэй” гэсэн үг юм.

Насанд хүрээгүй жирэмсэн эмэгтэй, бэлгийн цөөнх, амьдралын боломж тааруу иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд маш ихээр ялгаварлан гадуурхалтанд өртөж нөхөн үржихүйн эрхээ эдэлж чадахгүй байна.

Дэлхий даяар 1,8 тэрбум залуучууд бэлгийн болон нөхөн үржихүйн эрхээ эдлэх боломжгүй, эрсдэлд байна.

Дэлхий даяар өрнөж буй иргэний нийгмийн хөдөлгөөнүүдэд олон сая залуучууд нэгдэн шударга ёсыг шаардаж байна. Орон нутгийн, үндэсний, олон улсын хэмжээнд ажилладаг идэвхтэн тэмцэгчид өөрсдийн амьдрал, боловсролын талаар бүрэн дүүрэн мэдээлэл авах, хүний эрх, ялангуяа бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг хэрэгжүүлэхэд нийгмийн амьдралын бүхий л салбар дахь залуучууд нэгдэж хувь нэмрээ оруулах хэрэгтэй.

+ Эдлэх ёстой эрх

- Зөрчигдөж буй эрх /Тэмдэглэгээ/

## СЭДЭВ

### 4

#### БЭЛГИЙН МӨН ЧАНАРЫГ ОЙЛГОХ НЬ

**Зорилго:** Хүний бэлгийн мөн чанар нь хүний төрөхөөс өгөгдсөн, хүний амьдралын туршид үргэлжлэх маш өргөн хүрээний асуудал бөгөөд хүний амьдралын мөн чанар юм гэдгийг ойлгуулах

**Хугацаа : 50 минут**

№	Сэдвийн хуваарилалт	Хугацаа	Тайлбар
1	Хэлэлцүүлэг	35 минут	
2	Дүгнэлт ярилцлага	15 минут	

**Хэрэглэгдэх зүйлс :** Урьдчилан бэлтгэсэн чиглүүлэх асуулт бүхий мэдээллийн хуудас, тараах материал

**Арга зүй :** Оролцооны аргаар, харилцан ярилцах хэлбэрээр явагдана.

### Хэлэлцүүлэг

Хүний бэлгийн мөн чанар буюу хүний бэлгийн амьдралын талаар ямар ойлголттой байна вэ? Секс гэдгийг хэрхэн ойлгож байна вэ? гэсэн чиглүүлэх гол

асуултаа тавьж эхлэх бөгөөд товч хариултыг сонсоно. Үүний дараа хүний бэлгийн мөн чанарын талаарх ДЭМБ-ын тодорхойлолт /2002 он/:

*“Бэлгийн мөн чанар нь хүний амьдралын үндсэн төлөв байдал буюу амьдралынх нь туршид хамаарах хүйс ба жендэрийн баримжаа илэрхийлэл болон үүрэг, бэлгийн баримжаа, хүйсийн илэрхийлэл, дур хөдлөл, таашаал, янаглал, нөхөн үржихүйг тодорхойлдог. Хүн өөрийн бэлгийн мөн чанараа бодол, мөрөөдөл, хүсэл, итгэл үнэмшил, үнэт зүйлс, зан үйл, үүрэг, харилцаагаар дамжуулан мэдэрдэг ба илэрхийлдэг. Бэлгийн мөн чанар ийм олон хэмжигдэхүүнүүдийг агуулдаг ч энэ бүхнийг мэдэрдэг, илэрхийлдэг байх албагүй. Бэлгийн мөн чанарт биологийн, физиологийн, нийгмийн, эдийн засгийн, улс төрийн, ёс зүйн, соёлын, хууль эрх зүйн, түүхийн, шашны, оюуны гэх мэт олон хүчин зүйлсийн харилцан үйлчлэл нөлөөлдөг”*

### **Оролцогчдоос асуух асуултууд:**

- Дээрх тодорхойлолт нь яагаад ийм урт байна вэ?
- Нарийвчилсан тодорхойлолт бэлгийн мөн чанарын талаар бидэнд ямар ойлголт төрүүлж байна вэ? асуулт тавьж харилцан ярилцах явцдаа энэ нь хүний амьдралын мөн чанар бөгөөд маш өргөн хүрээний асуудал юм гэдэг ойлголтыг өгнө.
- Хүйс гэж юу вэ? Бэлгийн мөн чанартай яаж холбогдож байна?

“Хүйс гэдэг нь төрөхөд тогтоодог эрэгтэй, эмэгтэй хүний биологийн ялгаа юм. энэ ялгааг анатомын хувьд нөхөн үржихүйн эрхтэн, генетикийн хувьд хромосомын бүтэц, физиологийн хувьд нөхөн үржихүйн эрхтэний үйл ажиллагаан дээр үндэслэн тогтоодог” гэсэн тодорхойлолтыг хэлнэ. Хүйсийн тодорхойлолт нь бэлгийн мөн чанарын ойлголттой нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоогоор уялдаа холбоотой болохыг тайлбарлана.

- Жендэр гэж юуг хэлж байна? Хэрхэн ойлгож байна? Бэлгийн мөн чанартай яаж холбогдож байна?  
Жендэрийн үүрэг нь эрэгтэй, эмэгтэй хүнд хамааруулан ойлгож хэвшсэн нийгмийн хүлээлт дээр суурилдаг нийгмээс бидэнд тулгаж буй дүр юм. Түүнчлэн жендэрийн баримжаа илэрхийлэл нь тухайн хүний өөрийн төрөлхийн мэдрэмж дээр суурилсан байдаг ба тухайн хүн өөрийгөө эрэгтэй, эмэгтэй, эсвэл аль нь биш гэж мэдэрдэг, илэрхийлдэг. Энэ нь бэлгийн мөн чанарын ойлголттой хүн өөрийгөө мэдэрч, тодорхойлж буй байдалтай уялдаа холбоотой болохыг тайлбарлана.
- Бэлгийн чиг баримжааг хэрхэн ойлгож байна? Бэлгийн мөн чанартай яаж холбогдож байна?  
Бэлгийн чиг баримжаа гэж хувь хүн бэлгийн хувьд өөрийн баримжаагаа илэрхийлж буй байдал нь бэлгийн чиг баримжаа юм. Бэлгийн чиг баримжаа нь эсрэг хүйс, ижил хүйс, нэгээс илүү хүйсийн хүнд татагдах байдлыг хэлнэ. Энэ нь бэлгийн мөн чанарын ойлголттой хүний төрөлхийн мөн чанараар уялдаа холбоотой болохыг тайлбарлана.

- Секс гэдгийг хэрхэн ойлгож байна?  
Секс нь хүний бэлгийн амьдралын нэг хэсэг бөгөөд бэлгийн үйлдэл хийх зан үйл гэдгийг тайлбарлаж ойлгуулна.
- Таашаал мөн дотно байдал гэдгийг хэрхэн ойлгож байна? Бэлгийн мөн чанартай яаж холбогдож байна?  
Таашаал, янаглал гэдэг нь тодорхой үйлдэл, дүрс бүхий бодол зэргээс үүдэн сэрэл хөдлөх, дур хүсэл төрөх, ханамж авахыг хэлнэ. Дотно байдал гэдэг нь өөр хэн нэгэнтэй байхад ойр, дотно мэдрэмж төрөхийг хэлнэ. Эдгээр нь бэлгийн мөн чанарын ойлголттой хэрэгцээнд суурилсан байдлаар уялдаа холбоотой болохыг тайлбарлана.
- Нөхөн үржихүй гэж юу вэ? хэрхэн ойлгож байна? Бэлгийн мөн чанартай яаж холбогдож байна?

Нөхөн үржихүй гэдэг нь жирэмслэх, хүүхэд тээх болон гэр бүл төлөвлөлтийг хэлнэ. Нөхөн үржихүй нь бэлгийн мөн чанарын ойлголттой хүний төрөлхийн мөн чанараар уялдаа холбоотой болохыг тайлбарлана.

**Үргэлжлэх хугацаа / 35 мин /**  
**Ярилцлагын дүгнэлт /15 минут/**

Бэлгийн мөн чанар нь хүний амьдралын үндсэн төлөв байдал буюу амьдралынх нь туршид хамаарах хүйс ба гендэрийн баримжаа илэрхийлэл болон үүрэг, бэлгийн баримжаа, хүйсийн илэрхийлэл, дур хөдлөл, таашаал, янаглал, нөхөн үржихүйг тодорхойлдог. Хүн өөрийн бэлгийн мөн чанараа бодол, мөрөөдөл, хүсэл, итгэл үнэмшил, үнэт зүйлс, зан үйл, үүрэг, харилцаагаар дамжуулан мэдэрдэг ба илэрхийлдэг. Бэлгийн мөн чанар ийм олон хэмжигдэхүүнүүдийг агуулдаг ч энэ бүхнийг мэдэрдэг, илэрхийлдэг байх албагүй. Бэлгийн мөн чанарт биологийн, физиологийн, нийгмийн, эдийн засгийн, улс төрийн, ёс зүйн, соёлын, хууль эрх зүйн, түүхийн, шашны, оюуны гэх мэт олон хүчин зүйлсийн харилцан үйлчлэл нөлөөнд байх хүний төрөхөөс өгөгдсөн, хүний амьдралын туршид үргэлжлэх маш өргөн хүрээний асуудал бөгөөд хүний амьдралын мөн чанар юм

**Гол мессэж:**

- Хүний бэлгийн мөн чанар нь хүний төрөхөөс өгөгдсөн, хүний амьдралын туршид үргэлжлэх маш өргөн хүрээний асуудал бөгөөд хүний амьдралын мөн чанар юм

сэдэв  
5

БЭЛГИЙН ЗАН ҮЙЛ, ТҮҮНИЙ ОЛОН ТӨРӨЛ  
ЯНЗ

**Зорилго:** Сургалтанд оролцогсдод бэлгийн зан үйл гэдгийг ойлгуулах ,  
сайн бэлгийн зан үйл муу бэлгийн зан үйлийн талаарх ойлголт, мэдлэгийг  
нэмэгдүүлэх .

**Хугацаа : 60 минут**

№	Сэдвийн хуваарилалт	Хугацаа	Тайлбар
1	Бүлгийн ажил	54 минут	
2	Дүгнэлт ярилцлага	7 минут	

**Хэрэглэгдэх зүйлс :** Флипчарт цаас, өнгийн маркер – 8ш, скоч – 1ш, хоёр өнгийн  
стикер цаас – 20ш

**Аргачлал:** Оролцооны аргаар явагдана. Суралцагчдыг тав таваар 4 багт  
хуваана.

- Хүмүүс яагаад бэлгийн харьцаанд ордог бэ? Асуулт тавин хариулт бүрийг  
чиглүүлэгч багш самбар дээр бичнэ. / 5 мин /
- 4 багт флипчарт цаас тараан баг тус бүрээр бэлгийн зан үйлийн олон  
төрөл хэлбэрүүдийг жагсаан бичүүлнэ. Дуусмагц нь хураан авч өлгөнө.  
/ 15 мин /
- Баг тус бүрээс нэг нэг гишүүн ээлжилж гарч ирээд өөрийн багийн хийсэн  
ажил дээрх онцгой гэж үзсэн, эсвэл нэмэлт тайлбар хийх шаардлагатай  
гэж тооцсон гурав гурван бэлгийн зан үйлийн талаар бүх багт тайлбар  
өгнө. Чиглүүлэгч багш үүнд нь туслаж болно. / 20 мин /
- Бүх суралцагсдад 2 өөр өнгийн стикер цааснаас нэг нэгийг тараан өгч,  
нэг өнгөн дээр нь нийт багуудын жагсаан бичсэн бэлгийн зан үйлүүдээс  
өөрсдийн сайн гэж бодож буй 1-ээс 2 бэлгийн зан үйлээ, үлдсэн нэг өнгийн  
цаасан дээрээ муу гэж бодож буй зан үйлээсээ мөн 1-ээс 2 –ыг сонгон  
бичээд багшид хураалгана. / 3мин /
- 2 оролцогч саналаараа гарч ирэн өөр өөр өнгийн маркер бариад 4  
багуудын жагсаан бичсэн ажил дээр хураан авсан өнгийн цаасан дээрх  
сайн гэж үзсэн зан үйлүүдийг нэг өнгөөр, оролцогсдын саналын дагуу муу  
гэж үзсэнийг өөр нэг өнгөөр ялган тэмдэглэнэ. / 10 мин /

*Сэдвийн төгсгөлд: Чиглүүлэгч багшийн дүгнэлт явна. / 7 мин /*

**Гол мессэж:**

Хүн бүр янз бүрийн шалтгаанаар бэлгийн харьцаанд ордог. Үүнд янз бүр хэлбэр төрлийн зан үйлүүд багтана. Хэт хувийн үзлээр энэ зан үйл нь гаж буруу жам ёсноос гадуур, энэ нь сайн гэж хялбарчилсан дүнгэлт хийх нь өөрөө ташаа ойлголт юм.

- Сайн секс гэж 2 хамтрагч хуулийн дагуу хариуцлага хүлээх насанд хүрсэн бөгөөд хоорондоо харилцан зөвшилцсөний үндсэн дээр бэлгийн харьцаанд орсон байх
- Архи согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглээгүй, эрүүл саруул байх ёстой
- Хүсээгүй жирэмслэлт болон бэлгийн замаар дамжих халдвар авахаас ангид, аюулгүй бэлгийн харилцаа байх

сэдэв  
**6**

**БЭЛГИЙН БАРИМЖАА, ХҮЙСИЙН  
ИЛЭРХИЙЛЭЛ**

**Зорилго :** Хүний бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл нь төрөлхийн, хүйс болон бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийллийн олон янз байдал, биологийн хувьд ялгаатай байдал нь ялгаварлан гадуурхалтын үндэс биш гэсэн цогц мэдээлэл өгөх, бэлгийн чиг баримжаа хүйсийн баримжаа илэрхийллийн нэр томъёоны тайлбар өгөх

**Хугацаа: 50 минут**

№	Сэдвийн хуваарилалт	Хугацаа	Тайлбар
1	Танилцуулга	30 минут	
2	Дүгнэлт ярилцлага	20 минут	

**Хэрэглэгдэх зүйлс :** зөөврийн компьютер, проектор, бэлтгэсэн илтгэл ( ППТ)

**Аргачлал :** Илтгэл тавьж хэлэлцүүлэг өрнүүлэх аргаар явагдана.Илтгэл / 30 мин /

## Сэдвийн дүгнэлт

Хүний бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл нь төрөлхийн бөгөөд олон янз байдлаар илэрхийлэгддэг мөн биологийн хувьд ч өөр өөр ялгаатай байдаг. Энэ өнөөгийн нийгэмд тулгамдаж байгаа асуудал болж буй ялгаварлан гадуурхалтын суурь шалтгаан биш гэсэн цогц мэдээлэл авч эерэг үнэн зөв бодит мэдээлэлтэй болсон. Мөн бэлгийн чиг баримжаа хүйсийн баримжаа илэрхийллийн талаарх нэр томъёог сайн ойлгож авсан гэсэн дүгнэлтэд хүрлээ. / 20 мин /

### Гол мессэж:

- **Бэлгийн чиг баримжаа гэдэг нь** бэлгийн дур сонирхлын хувьд хэнд татагдаж байна вэ гэдэг мэдрэмж дээр үндэслэн хүн өөрийгөө хэн болохыг тодорхойлоход оршино. Эсрэг хүйсийн, ижил хүйсийн, эсвэл аль аль хүйсийн хүнд татагддаг байж болно.
- **Хүйсийн баримжаа илэрхийлэл нь** хүн өөрийгөө эрэгтэй, эмэгтэй, аль аль нь, эсвэл бүр өөр хүйсийн хүн гэж тодорхойлоход оршино.
- Хүний бэлгийн чиг баримжаа нь төрөлхийн шинж чанартай ба эхээс төрөхдөө ямар бэлгийн чиг баримжаатай байх нь тодорхойлогдсон байдаг.

## Сургалтын нэгдсэн хэлэлцүүлэг, дүгнэлт

Бүх чиглүүлэгчид оролцогчидтой тойрог үүсгэн сууж өөр өөрсдийн сэдэвтэй холбоотой дүгнэх хэлэлцүүлгийг чиглүүлэх асуултуудынхаа хүрээнд оролцогчдын санал сэтгэгдлийг нь асууж хүсэн хүлээсэн хүлээлт нь биелэсэн эсэх талаар харилцан ярилцаж сургалтыг дүгнэнэ.

### Сургалтын дараах асуумж бөглүүлэх Сургалтын хаалт

Зохион байгуулагч энэ өдрийн сургалтын ололт амжилт, дутагдлын талаар товч дурьдаад оролцогчдод сургалтанд хүрэлцэн ирсэн явдалд нь чиглүүлэгчдийн өмнөөс талархаж байгаагаа илэрхийлнэ. Сургалт амжилттай болсоныг дахин дурьдаад цаашид энэ өдрийн сургалтаар олж авсан мэдээ, мэдээллээ сургалт болон аливаа үйл ажиллагаанд ашиглах, найз нөхөд үе тэнгийхэндээ түгээх мөн нягт харилцаа холбоотой байж хамтран ажиллахыг уриалан сургалт хаасныг мэдэгдэнэ.



## НЭР ТОМЪЕОНЫ ТАЙЛБАР ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ

### **Бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийллийн үндсэн ойлголтуудын талаарх нэр томъёоны тайлбар**

Дараах нэр томъёонууд нь бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийллийг тодорхойлоход хэрэглэгддэг. Энэ жагсаалт нь бүрэн дүүрэн биш байж болох юм. Учир нь эдгээр нэр томъёонуудыг тогтмол хэлэлцэж, шинэчилдэг учир цаг хугацааны явцад эдгээрийн утга, хэрэглээ нь өөрчлөгдөн шинэчлэгддэг. Бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийллийн олон төрөл байдаг гэдгийг ойлгох нь хамгаас чухал

#### **НЭР ТОМЪЁО**

**Бэлгийн чиг баримжаа илэрхийлэл:** Бэлгийн дур сонирхлын хувьд хэнд татагдаж байна вэ? гэдэг мэдрэмж дээр үндэслэн хүн өөрийгөө хэн болохыг тодорхойлоход оршино. Эсрэг хүйсийн, ижил хүйсийн, эсвэл аль аль хүйсийн хүнд татагддаг байж болно.

**Хүйсийн баримжаа илэрхийлэл:** Хүн өөрийгөө эрэгтэй, эмэгтэй, аль аль нь, эсвэл бүр өөр хүйсийн хүн гэж тодорхойлоход оршино. Бэлгийн баримжаа илэрхийллийн адил нийгэм биологийн шинж тэмдэгийг чухалчилж хүйсийн баримжаа илэрхийллийг тогтоож ирсэн.

**Бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийлэл:** Өөр хүмүүс гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах явдалтай тулгарах нь олонтаа. “Зөв” гэж тогтоосон хэм хэмжээнээс өөр байх тусам тулгарах ялгаварлан гадуурхалт илүү хүчтэй байдаг. Нийгэмд тогтсон хэвшмэл ойлголт нь зарим бэлгийн болон хүйсийн баримжаа илэрхийллийг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах явдлыг нэмэгдүүлдэг.

**Асексуал:** Бэлгийн дур сонирхлын хувьд ямарч хүнд татагддаггүй хүн.

**Бисексуал:** Бэлгийн дур сонирхлын хувьд ижил болон эсрэг хүйсийн хүнд татагддаг хүн

**Гей:** Бэлгийн дур сонирхлын хувьд эрэгтэй хүнд татагддаг эрэгтэй хүн. Гэхдээ энэ нэр томъёо нь ижил хүйсийнхээ хүмүүст татагддаг эрэгтэй, эмэгтэй аль ч хүнийг тодорхойлно

**Гетеросексуал:** Бэлгийн дур сонирхлын хувьд эсрэг хүйсийн хүнд татагддаг хүн.

**Гетеросексизм:** Бүх хүн гетеросексуал байх ёстой гэсэн үзэл баримтлал ба энэ нь хүмүүст байх ёстой “зөв”, “хэвийн” бэлгийн баримжаа илэрхийлэл гэсэн ойлголт. Энэ үзэл баримтлал нь бусад бэлгийн баримжаа илэрхийллийг үгүйсгэхэд хүргэдэг.

**Гомосексуал:** Бэлгийн дур хүслийн хувьд ижил хүйсийнхээ хүнд татагддаг хүн.

**Гомофоби:** Гомосексуал хүмүүсийг хүлээн зөвшөөрдөггүй, ямарч үндэслэлгүйгээр тэднээс айх, тэднийг үзэн ядах явдал. Энэ нь гомосексуал хүмүүсийг ялгаварлан гадуурхах, алагчлах, ад үзэх, үзэн ядах байдлаар илэрхийлэгддэг.

**Интерсекс:** Эрэгтэй, эмэгтэй аль альнийх нь физиологийн шинж тэмдэгтэй төрсөн хүн. Ийм хүмүүс өөрөө өөрийгөө эрэгтэй эсвэл эмэгтэй гэж тодорхойлно

**Лесбиян:** Бэлгийн дур сонирхлын хувьд эмэгтэй хүнд татагддаг эмэгтэй хүн.

**Эрэгтэй хүн:** Өөрийгөө эрэгтэй гэж тодорхойлсон хүн буюу эрэгтэй хүний бэлэг эрхтэн, нөхөн үржихүйн эрхтэн байхгүй байж болно.

**Куийр:** Гетеросексуал үзэл баримтлалын эсрэг байдаг хүн. Үүнд гомосексуал, гей, интерсекс, лесбиян, трансжендэр хүмүүс хамаарна. Зарим үг энэ хүмүүст доромжлол мэт санагдаж болох боловч бусад нь үүнийг өөрийн эрч хүчээ илэрхийлэх байдал болгон ашиглаж, үүгээр дамжуулан өөрсдийн гетеросексуал биш, нийгэмд давамгайлсан гетеросексуал үзэл баримтлалын эсрэг байр суурьтай, өөрийгөө гетеросексуал гэж үздэггүй хүмүүст оноосон элдэв нэрэнд сэтгэл дундуур байдгаа илэрхийлдэг.

**Хүйсээ солиулсан:** Нэг хүйсээс нөгөө хүйсрүү шилжилт хийхэд шаардлагатай олон төрлийн үйл явц. Үүнд гормоны эмчилгээ, үс шилжүүлэн суулгах, үс арилгах, хэл яриа засах гэх мэт процедур орох ба хүний бэлэг эрхтэн, зарим тохиодолд нөхөн үржихүйн эрхтэнг өөрчлөх мэс ажилбар орно

**Трансжендэр:** Өөрийн хүйсээ төрөлхийн хүйсээсээ өөрөөр тодорхойлдог хүн. Өөрийгөө “гурав дахь” хүйсийн хүн гэж тодорхойлж магадгүй, үгүй ч байж магадгүй. Трансжендэр хүмүүс нь эмэгтэй хүний хувцас өмсөж, эмэгтэй хүн шиг биеэ авч явдаг эрэгтэй хүн байж болно. Эсвэл эрэгтэй хүний хувцас өмсөж, эрэгтэй хүн шиг биеэ авч явдаг эмэгтэй хүн байж болно. Харин гомосексуал биш.

**Транссексуал:** Төрөлхийн хүйсээ өөр хүйс болгон шилжүүлэх хүсэлтэй хүн. Үүний тулд зарим хүмүүс мэс засал хийлгэдэг, зарим нь гормоны эмчилгээ эсвэл өөр үйл явцыг сонгодог. Гомосексуал, бисексуал, гетеросексуал мөн эсвэл биш ч байж болно. Эмэгтэйгээс эрэгтэй, эрэгтэйгээс эмэгтэй трансжендэр байж болно. Эсвэл аль нь биш байж болно

**Трансвестит:** Бэлгийн дур хүслээ төрүүлэх зорилгоор, эсрэг хүйсийн хүмүүсийн өмсдөг хувцасыг өмсдөг хүн. Ихэвчлэн эмэгтэй хүний хувцас өмсдөг эрэгтэй хүн байдаг.

**Эмэгтэй хүн:** Өөрийгөө эмэгтэй гэж тодорхойлсон хүн буюу эмэгтэй хүний бэлэг эрхтэн, нөхөн үржихүйн эрхтэн байхгүй байж болно.

### **Бэлэг, бэлгийн мөн чанар, жендэрийн талаархи суурь мэдээлэл**

**Агент / Agency:** хувийн болон нийгмийн амьдралаа зохион байгуулах, холбоотой сонголт хийх хувь хүмүүс болон бүлгүүдийн чадавхи, чадвар, арга хэрэгсэл. Нийгмээс тавьдаг хязгаарлалтаас үл хамааран, хувь хүмүүс энэхүү агентыг ашиглан бодит байдлыг өөрчлөх замаар шинэ бодит байдал, амьдралын статус, нөхцлийг өөрсөддөө бий болгодог. Гадуурхагдаж орхигдсон, аливаа нөөц боломж байхгүй хүмүүс, бүлгүүд хүртэл агенттай байж, одоогийн байгаа нийгмээс тэдэнд олгоогүй шинэ, тохиромжтой байдал, нөхцлийг өөрсөддөө бүрдүүлдэг байж болно. Жишээ нь, нөхрүүдийнхээ хүчинд автаж секс хийдэг эмэгтэйчүүд хүртэл нөөц, чадвараа ашиглаж тэгж хүчинд автагдахгүй байж чаддаг байж болно, сарын тэмдэг ирсэн гэх ч юм уу, эсхүл хүүхдээ дундаа унтуулж нөхрөө дайрахаас сэргийлэх ч юм уу.

**Жендэр / Gender:** эмэгтэй, эрэгтэй хүмүүс, тэдний бие биенээсээ ялгаатай байдлыг, тэдэнд оногддог үүрэг ролийн талаар нийгмээс үзэх үзэл баримтлал. Ерөнхийдээ хүмүүс өөрсдийгөө холбогдох жендэртээ хамааруулж, тэр жендэртээ тохирсон байдлаа биеэ авч явна гэж үздэг. Эр, эмд зохистой зан үйл гэж соёлоор тодорхойлогдсоны дагуу жендэрийн үүрэг ролийг хуваарилдаг ч, жендэрийн тодорхойлолт / харъяалал /gender identity/ нь тэр хувь хүний өөрөө өөрийгөө эмэгтэй, эрэгтэй аль нэгэнд хамаарна эсхүл алинд ч хамаарахгүй гэж үзэж байгаа мэдрэмж нь юм. Бид хүнийг нарийн төвөгтэй цогц хандаар нь аль нэг жендэрт хамааруулдаг ба тэр цогц нь соёлын орчноос нь хамаарч өөр өөр байдаг. Эдгээр хандын тоонд тэр хүний гаднах төрх, хувцаслалт, зан төрх зэргээс эхлэн тэр зан төрхөө гаргасан орчин, мөн тэдний эрх мэдэлтэй хэрхэн харьцаж, ашиглаж байгаа байдал хүртэл өргөн олон янз байдаг байна.

**Эцгийн эрхэт ёс / Patriarchy:** нийгмийн сэтгэхүйн шаталсан /иерархи/ систем – энэ системд эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдийгээ давамгайлдаг ба улмаар улс төр, эдийн засаг, нийгмийн орчинд тэдний хооронд эрх тэгш бус байдал үүсдэг. Эл системд нийгмийн бүх чухал байгууллага / институцэд эрэгтэйчүүд эрх мэдлийг эзэмшиж, эмэгтэйчүүдэд тэрхүү эрх мэдэл хүртээмжгүй. Гэсэн хэдий ч энэ системд эмэгтэйчүүд огт ямар ч эрх мэдэлгүй, эсхүл огт эрхгүй, нөлөөгүй, нөөцгүй гэсэн үг биш юм. (дэлгэрэнгүйг Агент-с үзнэ үү).

**Хүйс / Sex:** төрөхөөс заяасан эм, эрийн биологийн ялгаа. Эдгээрийн тоонд үтрээ, пенис зэрэг анатомийн ялгаа, тухайн хүний хромосомд илэрдэг генийн ялгаа, сарын тэмдэг, сперм боловсруулалт зэрэг физиологийн ялгаа орно. Секс гэдэг нь мөн пенис үтрээнд орох интеркорс, аман секс, анусын секс, гар хангалгаа, үнсэлт, г.м. бие махбодийн үйлдлийг хамарч болно /гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй/

**Бэлгийн мөн чанар / Sexuality:** бэлгийн мөн чанарыг үзэл баримтлал болохынх нь хувьд олон жил судалж байна. Эл үзэл баримтлалын олон бүрэлдэхүүн хэсгийн

хамарсан олон тодорхойлолт байдаг. Хэдийгээр бүгд хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт байхгүй ч, доорхи хоёр тодорхойлолт нь ойлголт өгөх юм.

- Бэлгийн мөн чанар нь хүний амьдралын гол аспект бөгөөд хүйс, жендэрийн хамаарал ба үүрэг роль, бэлгийн чиг баримжаа, эротизм, дур ханамж, янаглал, нөхөн үржилт зэргийг хамарна. Бэлгийн мөн чанар нь бодол, фантаз, хүсэл, итгэл, хандлага, үнэлэмж, зан үйл, практик үйлдэл, үүрэг роль, харилцаа зэргээр хэрэгжиж илэрхийлэгдэнэ. Бэлгийн мөн чанар ийм олон талтай хэдий ч, эдгээрийг бүгдийг нь дандаа илэрхийлж, хэрэглэдэггүй байна. Бэлгийн мөн чанар нь биологийн, физиологийн, нийгмийн, эдийн засгийн, улс төрийн, соёлын, ёс зүйн, эрх зүйн, түүхэн, шашны зэрэг хүчин зүйлс, тэдгээрийн харилцан үйлчлэлийн нөлөөнд байдаг. (ДЭМБ-ын 2002 оны ажлын тодорхойлолт)
- Хүний бэлгийн мөн чанар нь хувь хүмүүсийн бэлгийн мэдлэг, итгэл, хандалга, үнэлэмж, зан үйл, зэргийг багтаана. Түүний олон талын тоонд хүний бэлгийн системийн анатоми, физиологи, биохими, хамаарал, чиг баримжаа, үүрэг роль, хувь зан чанар, бодол, сэтгэл, харилцаа зэрэг багтана. Хүний ёс зүйн, шашны, ёс суртахууны байдал нь түүний бэлгийн мөн чанарын илэрхийлэлд нөлөөлнө. (SIECUS-н тайлан, боть 24 #3, 1996)

**Бэлгийн нэр харъяалал / Sexual identity:** бэлгийн үүднээс хэнд татагддаг талаараа хүн өөрийгөө хэрхэн үздэг үзлийг хэлсэн үзэл баримтлал. Тухайн хувь хүн өөрийн хүйсийн хүнд, эсхүл өөр хүйсийн хүнд, эсхүл нэгээс олон хүйсийн хүмүүст, татагддаг утгыг ялангуяа хамарна.



